

“БИЧИЛ УУРХАЙН ХҮҮХДҮҮДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН



World Vision Mongolia

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	4
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТЫН ТАЙЛБАР	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ.....	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
ХУРААНГУЙ	7
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	11
СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ.....	14
1 СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ.....	15
2 ТООН СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	21
2.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН СУДАЛГАА.....	21
2.1.1 Хамарсан хүрээ	21
2.1.2 Бичил уурхайчдын шилжилт хөдөлгөөн.....	22
2.1.3 Судалгаанд оролцогчийн хувийн мэдээлэл	24
2.1.4 Амьжиргааны нөхцөл байдал	26
2.1.5 Ажлын нөхцөл байдал.....	27
2.1.6 Өрхийн эдийн засаг	30
2.1.7 Бичил уурхайчдын хүүхдийн нийгмийн асуудал.....	35
2.2 УУРХАЙН ОРЧИНД АМЬДАРДАГ ХҮҮХДИЙН АСУУЛГЫН ҮР ДҮН.....	45
2.2.1 Ерөнхий мэдээлэл.....	45
2.2.2 Боловсрол	46
2.2.3 Хөдөлмөр эрхлэлт.....	47
2.2.4 Эрүүл мэнд	49
2.2.5 Хүүхдийн нийгмийн асуудал.....	50
2.3 ЭЦЭГ ЭХЭЭСЭЭ ТУСДАА АМЬДАРДАГ ХҮҮХДИЙН АСУУЛГЫН ҮР ДҮН	53
2.3.1 Ерөнхий мэдээлэл.....	53
2.3.2 Эрүүл мэнд	55
2.3.3 Хүүхдийн нийгмийн асуудал.....	56
3 ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН	59
3.1 БИЧИЛ УУРХАЙЧИН ЭЦЭГ, ЭХТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН.....	59
3.1.1 Бичил уурхайчид маш хүнд нөхцөлд ажиллаж байна.	63
3.1.2 Бичил уурхайчдын эрүүл мэнд доройтож байна.	66
3.1.3 Бичил уурхайчдын өрхийн эдийн засгаа хөтлөх мэдлэг, дадал муу байна.	

3.1.4	Тогтвортой ажлын байр дутмаг байна.....	68
3.1.5	Ажилд хандах хандлага сөрөг байна.....	69
3.1.6	Зөвшөөрөлгүй бичил уурхайчид болон цагдаа нарын хоорондын зөрчил	69
3.2	ХҮҮХДҮҮДТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН	71
3.2.1	Хүүхдүүд хэцүү нөхцөлд амьдарч байна.	71
3.2.2	Бичил уурхай хүүхдүүдийн боловсролд нөлөөлж байна.....	74
3.2.3	Бичил уурхайчдын хүүхдүүд хүчирхийлэлд өртөх эрсдэл илүү өндөр байна. 76	
3.2.4	Бичил уурхайн орчин хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж байна.	77
3.2.5	Хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.....	78
3.2.6	Хүүхдүүд уурхайн орчинд амьдарснаар гэмтэж бэртэх эрсдэл өндөр байна. 79	
3.2.7	Хүүхдүүд өрхийн эдийн засагт нэмэр болохыг хичээдэг.....	80
3.2.8	Хүүхдүүд аав, ээжийнхээ эрүүл мэндэд санаа зовж байна.	82
3.2.9	Хүүхдүүд эцэг, эхтэйгээ хамт амьдарч чадахгүй байна.	83

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТЫН ТАЙЛБАР

Ойлголт	Тодорхойлолт
Бичил уурхайчин	Нөхөрлөлийн гишүүн болон нөхөрлөлийн гишүүн биш, 3 сар түүнээс дээш хугацаагаар, гар аргаар алт олборлож байгаа иргэнийг ойлгоно.
Бичил уурхай эрхлэгчийн хүүхэд	Эцэг эх хоёулаа эсвэл хэн нэг нь бичил уурхайн хөдөлмөр 3 сар түүнээс дээш хугацаагаар эрхэлж байгаа, 7-17 насны хүүхдийг ойлгоно.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1 Түүврийн тархалт, судалгааны арга тус бүрээр	19
Хүснэгт 1-2 Хүүхдийн ганцаарчилсан ярилцлагын насны тархалт	19
Хүснэгт 2-1 Өрхийн судалгааны түүврийн тархалт	21
Хүснэгт 2-2 Шилжиж ирэгсдийн бүртгэгдсэн байдал	24
Хүснэгт 2-3 Судалгаанд оролцогчдын насны бүлэг	24
Хүснэгт 2-4 Ам бүлийн тоо	26
Хүснэгт 2-5 Амьдардаг сууцны хэлбэр	26
Хүснэгт 2-6 Ажил хийдэг хүний тоо	26
Хүснэгт 2-7 Бичил уурхайд ажилладаг хүний тоо	27
Хүснэгт 2-8 Хоногт ажилладаг цаг	28
Хүснэгт 2-9 Долоо хоногт ажилладаг өдөр	28
Хүснэгт 2-10 Ажил эрхлэлтийн цаашдын хандлага	29
Хүснэгт 2-11 Өрхийн сарын орлого	30
Хүснэгт 2-12 Бичил уурхайн орлого хасаж тооцсон өрхийн орлого	30
Хүснэгт 2-13 Өрхийн орлогын хүрэлцээ	31
Хүснэгт 2-14 Эд хөрөнгөө зарах болсон шалтгаан	34
Хүснэгт 2-15 Хүүхдийн тоо	36
Хүснэгт 2-16 Орчны хүүхдэд тохиромжтой эсэх байдал	37
Хүснэгт 2-17 Орчноос үүдэлтэй хүндрэл	38
Хүснэгт 2-18 Хүүхдүүдэд зориулж хийхийг хүссэн зүйлс	39
Хүснэгт 2-19 Хичээлдээ хэрхэн явдаг	40
Хүснэгт 2-20 Уурхайн ажилд хүүхдийн үүрэг оролцоо	41
Хүснэгт 2-21 Сүүлийн нэг жилийн хугацаанд тусдаа байсан хугацаа	42
Хүснэгт 2-22 Цэцэрлэгт хамрагддаггүй шалтгаанууд	43
Хүснэгт 2-23 Судалгаанд оролцогч хүүхдүүдийн хамрагдалт, аймгаар	45
Хүснэгт 2-24 Нүүж ирсэн шалтгаан	45
Хүснэгт 2-25 Судалгаанд оролцогч хүүхдүүдийн насны бүлэг	45

Хүснэгт 2-26 Бичил уурхайд ажилладаг хүний тоо	46
Хүснэгт 2-27 Сургуульд хамрагдалт.....	46
Хүснэгт 2-28 Хичээлдээ хэрхэн явдаг.....	46
Хүснэгт 2-29 Хичээлээ таслах, чөлөө авах тохиолдлын давтамж.....	47
Хүснэгт 2-30 Хүүхдийн өрхийн бизнест оролцох байдал, насны бүлгээр	48
Хүснэгт 2-31 Хүүхдийн уурхайн ажилд оролцох байдал, насны бүлгээр.....	48
Хүснэгт 2-32 Мөнгөний зарцуулалт	48
Хүснэгт 2-33 Өвчлөлийн хэлбэр.....	49
Хүснэгт 2-34 Хүүхдүүдэд тохиолдох эрсдэл	50
Хүснэгт 2-35 Уурхайн орчинд амьдрахад гардаг хүндрэл	51
Хүснэгт 2-36 Цаашид одоо байгаа газраа амьдрах эсэх	51
Хүснэгт 2-37 Хүүхдүүдийн орчиндоо бий болгохыг хүссэн зүйс.....	51
Хүснэгт 2-38 Судалгаанд оролцогч хүүхдүүдийн хамрагдалт, аймгаар.....	53
Хүснэгт 2-39 Шилжиж ирэгсдийн бүртгэлтэй байсан	53
Хүснэгт 2-40 Судалгаанд оролцогч хүүхдүүдийн нас	54
Хүснэгт 2-41 Уурхайд ажилладаг хүнтэй хамаарах хамаарал.....	54
Хүснэгт 2-42 Амьдардаг газар.....	54
Хүснэгт 2-43 1 жилийн хугацаанд хамт амьдардаг хугацаа	55
Хүснэгт 2-44 Өвчлөлийн хэлбэр.....	55
Хүснэгт 2-45 Утсаар холбоо барих хугацааны давтамж.....	56
Хүснэгт 2-46 Хүүхдэд тохиолдох эрсдэл.....	56
Хүснэгт 2-47 Аав, ээж нь байхгүй үед тохиолдох хүндрэл	57
Хүснэгт 2-48 Эцэг, эхийн нь цаашдын ажил эрхлэлтийн хандлага.....	57
Хүснэгт 2-49 Хүүхдүүдэд орчиндоо хийхийг хүссэн зүйл	58

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 2-1 Шилжилт хөдөлгөөн.....	22
График 2-2 Нийт судалгаанд оролцогчдын дунд шилжиж ирэгсдийн эзлэх хувь	23
График 2-3 Шилжин ирэгсдийн тухайн аймаг, суманд амьдарч буй хугацаа.....	23
График 2-4 Судалгаанд оролцогчдын хүйс.....	25
График 2-5 Судалгаанд оролцогчдын боловсрол	25
График 2-6 Бичил уурхайд ажиллах болсон шалтгаан.....	27
График 2-7 Бичил уурхайд ажиллах үе.....	29
График 2-8 Өрхийн орлогын эх үүсвэрүүд.....	31
График 2-9 Өрхийн хадгаламж, зээлийн харьцаа	32
График 2-10 Мөнгө зээлсэн шалтгаан.....	33
График 2-11 Хоол хүнсний тасалдалт	33
График 2-12 Өрхийн орлогогүй болсон тохиолдол байгаа эсэх.....	34
График 2-13 Хүүхэдтэйгээ хамт болон тусдаа амьдарч буй харьцаа	35
График 2-14 Хүүхдээ уурхайн орчинд амьдруулж байгаа шалтгаан.....	36
График 2-15 Хүүхдэдээ тавих анхаарал халамж.....	37
График 2-16 СӨБ-ийн насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт.....	39
График 2-17 Цэцэрлэгт хамрагддаггүй шалтгаан	40
График 2-18 Хүүхдүүд уурхайн ажилд оролцох байдал.....	41

График 2-19 Амьдардаг газар.....	42
График 2-20 СӨБ-ийн насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт.....	43
График 2-21 Хүүхдийн өрхийн бизнест оролцох байдал	47
График 2-22 Хүүхдийн орлогын өрхийн орлогод үзүүлэх хувь нэмэр	49

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1 Бичил уурхайн байршил тархалт	18
Зураг 3-1 Төв аймаг, Заамар сум, Хувиараа ашигт малтмал олборлогчид	59
Зураг 3-2 Нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон олборлолтын талбай	60
Зураг 3-3 Сэлэнгэ аймаг, Ерөө сум, Чингэлэгт амьдардаг охин	61
Зураг 3-4 Бичил уурхайчдын сууцны хэлбэрүүд	63
Зураг 3-5 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Ялаатын уурхай	64
Зураг 3-6 Баянхонгор аймаг, Галуут сумын уурхай.....	65
Зураг 3-7 Говь-Алтай аймаг, Дэлгэрийн уурхай: Тоосжилт ихтэй	66
Зураг 3-8 Хэнтий аймаг, Батноров сум.....	69
Зураг 3-9 Баянхонгор аймаг, Галуут сум	69
Зураг 3-10 Төв аймгийн Заамар сум, Цагдаагийн пост.....	70
Зураг 3-11 Хэнтий аймаг, Батноров сум, Бэрхийн уурхайн орчимд амьдардаг хүү	72
Зураг 3-12 Хэнтий аймаг, Батноров сум, Бэрхийн уурхай	73
Зураг 3-13 Баянхонгор аймаг, Жаргалант сум	74
Зураг 3-14 Төв аймаг, Заамар сум.....	74
Зураг 3-15 Хэнтий аймаг, Батноров сум, Сумруугаа явж буй байдал	75
Зураг 3-16 Хэнтий аймаг, Батноров сум, Бэрхийн уурхай	80
Зураг 3-17 Баянхонгор аймаг, Галуут сум	80
Зураг 3-18 Баянхонгор аймаг, Галуут сум	82
Зураг 3-19 Сэлэнгэ аймаг, Зүүнхараа хот, Усанд явж буй хүүхэд.....	84

ХУРААНГУЙ

Судалгааны түүврийн төлөөлөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд судалгаанд аль болох олон аймаг хамруулж авахыг хичээсэн бөгөөд нийт 10 аймгийн 17 сумыг хамруулан, нийт 387 бичил уурхайчинтай уулзаж, тэдний ажил амьдралтай танилцсан юм. Мөн эцэг, эхтэйгээ хамт болон тусдаа амьдарч байгаа 357 хүүхэд асуулга судалгаанд, 50 гаруй хүүхэд ганцаарчилсан ярилцлагад оролцсон юм. Судалгаанд хамрагдсан уурхайнууд ажиллаж буй хүний тооны хувьд, төрөл цар хүрээний харилцан адилгүй янз янзын уурхайнууд байсан юм.

Бичил уурхайд арав гаруй настай хүүгээс 60 гарсан настайчууд хүртэл ажиллаж байна. Тэдний ихэнх нь 45 хүртэл насныхан байгаа бөгөөд нийт судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 63.0 хувь нь эрэгтэйчүүд, 37.0 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

Иргэдийг бичил уурхайд ажил эрхлэхэд нөлөөлж буй 2 үндсэн шалтгаан байгаагийн нэг нь тухайн орон нутагт ажлын байрны хүртээмж муу байгаа, нөгөө нь тухайн иргэн тухайн ажлын байранд тэнцэхгүй буюу ажил олгогчийн тавих шалгуурт нийцэхгүй байгаа нь бичил уурхайчдын ярианаас харагдаж байлаа. Учир нь тэдний 87.1 хувь нь бүрэн дунд түүнээс доош боловсролтой, олж авсан мэргэжилгүй хүмүүс байгаа юм. Хөдөө орон нутагт хамгийн олдоцтой ажил нь барилга болон уурхайн компаний ажил. Гэтэл эдгээр ажил ч мөн улирлын шинжтэй, нөгөөтэйгүүр бичил уурхайчид өөрсдөө хүний доор, цаганд баригдаж ажиллах дургүй, зарим барилгын компани цалингаа тавьдаггүй зэрэг шалтгаанаас цалинтай албан ёсны ажлаас бичил уурхайн ажил эрхлэхийг илүүд үзэж байна.

Судалгаанд хамрагдсан 387 өрхөд ажил эрхэлдэг 598 хүн байгаагийн 537 нь буюу 89.8 хувь нь бичил уурхайд ажиллаж байна. Нийт өрхийн 64.4 хувийн амьдрал 100 хувь уурхайгаас хамааралтай байна.

Бичил уурхайчид долоо өдөрт дунджаар 10.3 цаг, долоо хоногт дунджаар 6.4 өдөр ажиллаж байгаа буюу долоо хоногт дунджаар 65.9 цаг ажиллаж байна. Энэ нь хөдөлмөрийн хуулийн заасан нормаас 1.6 дахин буюу 60 хувиар илүү цаг ажиллаж байна гэсэн үр дүн юм. Нэг бичил уурхайчин дунджаар жилд 201 өдөр ажилладаг байна.

Мөн тэдний 64.6 хувь нь цаашид бичил уурхайд ажилласаар байх, 19.6 хувь нь цаашид ажиллахгүй байх хандлагатай байна. Харин 14.5 хувь нь цаашид хэрхэхээ одоогоо хэлж мэдэхгүй байна.

Нэг өрх сард дунджаар бичил уурхайгаас 466800 төгрөг олж байна. Сүүлийн 12 сарын хугацаанд ямар ч өрхийн орлогогүй болсон тохиолдол нийт судалгаанд хамрагдсан өрхийн 35,4 хувьд тохиолдсон нь бичил уурхайн орлого тогтвортой биш байдгийн илрэл юм.

Бичил уурхайчид олон сараар хөдөө гадаа ажилласны хэрээр чамлахааргүй орлого олдог болохыг тэд өөрсдөө ч, орон нутгийн удирдлагууд ч хэлж байгаа юм. Гэсэн ч тэдний боловсрол мэдлэгийн нөлөө, нөгөө талаас амьдралын тогтворгүй хэв маягаас үүдэлтэйгээр орлогоо зөв зарцуулах мэдлэг, дадал сул байна. Өрөөс өрийн

хооронд, дээр нь архидалт нэлээд байдаг учир архинд тодорхой хувийг нь зарцуулж байгаа нь өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлдөг нь харагдаж байсан юм.

Бичил уурхайчдын олонх нь алт олборлодог. Алтны илэрц хаа л гарна, тийшээ очиж алтаа олборлоно. Тиймээс тогтворгүй амьдралын хэв маягтай. Нүүж суухад авсаархан майхан, машин, дугарцигт хоног төөрүүлж, мөн түлээ түлшгүй газар очсон тохиолдолд газ, паяльникаар галлаж дулаацаж, хоол цайгаа болгодог байна. Хөдөө хээр ажиллаж байгаа учир олон цагаар, шөнө оройгүй ажиллаж ядарснаас анхаарал болгоомж алдаж гэмтэж бэртэх асуудал гарахад ч хүргэдэг гэнэ.

Энэ хэцүү нөхцөлд ажиллахын зэрэгцээ байнга даарч хөрөх, шороо тоос ихтэй нөхцөлд ажиллах, нүхэнд орж ажилласнаас агаарын дутагдалд орох, усан дотор удаан зогссоноос жиндэх, ухсан нүхэндээ унах, хүнд зүйл өргөх зэргээр олон жил ажилласан бичил уурхайчид эрүүл мэндийн хувьд ихээхэн асуудалтай болж эхэлжээ. Судалгаанд оролцогчдын 20 орчим хувь нь бичил уурхайд ажилласнаас хойш эрүүл мэндийн хувьд дордсон гэсэн юм.

Байнгын бичил уурхай дээр ажилладаг бичил уурхайчид байхад, завтай боломжтой үеэрээ ажилладаг малчид, албан хаагчид, бусад аймаг, сумаас түр хугацааргаар ирж ажиллагсад гэсэн тогтмол биш, дуртай цагтаа ирж, дуртай цагтаа явдаг хүмүүс бичил уурхайчдын нэг хэсгийг бүрдүүлж байна.

Зөвшөөрөлгүй бичил уурхайчид болон цагдаа нарын хоорондын зөрчил насанд хүрэгчдийн төдийгүй хүүхдүүдийн сэтгэлийг зовоосон асуудал болоод байна. Учир нь зөвшөөрөлгүй газар олборлолт хийж байгаа бичил уурхайчдыг цагдаа нарын хүчээр хөөдөг. Энэ хөөлгөнөөс амжиж хэдэн шуудай шороо гаргаж авахын тулд өдөр шөнөгүй, яаруу сандруу ажилласнаас болж гэмтэж бэртэх, баригдсан тохиолдолд цагдаа нарт зодуулах асуудал нэлээд гардаг байна.

Бичил уурхай эрхлэгчдийн хүүхэд

Нийт судалгаанд хамрагдагсдын 25 хувь нь одоо хүүхдүүдтэйгээ хамт уурхайн орчинд амьдарч байгаа, 75 хувь нь хүүхдүүдээ хаа нэгтээ орхиод бичил уурхайд ажиллаж байна.

≡ Уурхайн орчинд амьдардаг хүүхэд

Эцэг, эхчүүд ар гэрт нь хүүхдийг нь харах хүнгүйгээс эсвэл өөрсөдтэйгээ хамт байлгах гэсэн 2 голлох шалтгааны улмаас хүүхдүүдтэйгээ уурхайн орчинд амьдардаг. Мөн зарим өрхийн хувьд угаасаа тэр сум, сууринд амьдардаг учир хүүхэд уурхайн орчинд амьдарч байна. Судалгаанд хамрагдсан 387 өрхөөс 97 өрх нь уурхайн орчинд хүүхдүүдтэйгээ амьдардаг. Тэдгээр өрхийн 179 хүүхэд байна. Тэдний 111 нь судалгаанд оролцсон юм.

Уурхайн орчинд амьдарч СӨБ-ийн насны хүүхдүүдийн 63.5 хувь нь цэцэрлэгт явж чаддаггүй. Тэдний 55.0 хувь нь цэцэрлэг байхгүй, 25.0 хувь нь цэцэрлэг байсан ч орон тоо байхгүйн улмаас цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй байна. Хүүхдээ цэцэрлэгт өгч

чадаагүй гэр бүлүүдийн хувьд хэн нэг нь хүүхдээ харах, хэн нэг нь ажлаа хийх гэх зэрэг хуваарьт ордог байна.

Бичил уурхайчдын хүүхдүүдийн тодорхой хэсэг нь мөн л эцэг, эхтэйгээ хамт амьдардаг учир мөн л хүнд хэцүү нөхцөлд амьдарч байна. Аав, ээж нь өглөө гараад явдаг, заримдаа ирнэ, заримдаа ирэхгүй.

Уурхайн орчинд амьдрахад тоос шороо, хог хаягдал, дуу чимээ, архидалт ихтэй. Мөн орчин тойронд ухсан нүх ихтэй учир хүүхэд амьдрахад төдийлөн таатай биш орчин нөхцөл юм. Ийм нөхцөлд амьдрахад хүүхдүүд гэмтэж бэртэх эрсдэл өндөр, мөн тоос шороо, дуу чимээ ихтэй, хүйтэн сэрүүн нөхцөлд амьдрах нь хүүхдүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Мөн олон газраас ирсэн олон хүн байдаг учир янз бүрийн зан харилцаатай хүмүүс алтнаас болж хэрэлдэж, зодолдох, архи уух асуудал зарим газар нэлээд байдаг байна. Энэ мэт нь хүүхэд хүчирхийлэлд өртөх нөхцөл бүрдүүлдэг бөгөөд нөгөөтэйгүүр хүүхдийн хүмүүжилд ихээхэн сөргөөр нөлөөлдөг болохыг судалгаанд оролцогчид хэлж байлаа.

Уурхайн орчинд амьдарч буй хүүхдүүдийн өөр нэг хүндрэлтэй асуудал нь хөдөлмөр эрхлэлт байлаа. Хүүхдүүд эцэг эх, өөр хэн нэгний шахалтаар гэхээс илүүтэйгээр өөрсдийн хүсэлтээр аав, ээжийнхээ ажилд тусалдаг байна. Энэ нь тэдний өрхийн эдийн засагт нэмэр болохыг хүссэний илрэл юм. Хүүхдийн уурхайн ажилд оролцох байдал зуны улиралд хичээл амарсантай холбоотойгоор эрс нэмэгддэг байна.

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 38 хувь нь хүүхдээ уурхайн ажилд туслуулдаг гэсэн бол, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 42.3 хувь нь хааяа, 22.5 хувь нь байнга тусалдаг гэсэн юм. Уурхайн ажилд туслахдаа ихэвчлэн ямар ажил хийдэг болохыг тодруулахад, угаахад зориулж бэлдсэн чулуу, шороо савлах зөөх, ус зөөх, нүх ухах, алт угаах зэрэг бүхий л үе шатанд оролцдог байна.

Энэ хичээлийн бус цагаар, амралтын өдрүүдээр хүүхдүүд эцэг эхдээ туслахаар уурхайн талбайруу явах зэргээр нааш цааш явсан тогтворгүй амьдралын хэв маяг нь зарим хүүхдүүдийн хувьд хичээл сургуульдаа дургүй болох, хичээлээ хийх цаг боломж олгохгүй байх зэргээр хүүхдүүдийн сурлагад хүртэл нөлөөлдөг талаар багш нар ярьж байлаа.

≡ Эцэг эхээсээ тусдаа амьдарч буй хүүхдүүд

Эцэг эхийн хэн нэгэн бичил уурхайд ажилласнаас хамт амьдарч чадахгүй байгаа 290 өрхийн 644 хүүхэд байна. Эдгээр 644 хүүхэд эцэг, эхийн аль нэгээс эсвэл хоёулангаас нь 3 болон түүнээс дээш сарын хугацаатайгаар хол амьдарч байна. Тэднээс 246 нь асуулга судалгаанд хамрагдсан.

Эдгээр хүүхдүүд 70 хувь нь өөрийнхөө гэртээ, үлдсэн 30 хувь нь эмээ, өвөөгийнхөө, танил айлдаа, хамаатны айлдаа гэх зэрэг өөр айлд амьдарч байна. Эцэг, эхээсээ хол амьдарч буй хүүхдүүдийн 92.8 хувь нь ааваасаа, 45.5 хувь нь ээжээсээ, 4.1

хувь нь хоёулангаас нь хол амьдарч байгаа юм. Ийнхүү гэрийнхнээсээ хол, өөр айлд амьдрах нь хүүхдүүдэд сэтгэлзүйн хувьд хүнд байдаг байна.

Цэцэрлэгт 41.2 хувь нь хамрагддаггүй. Уурхайн орчинд амьдарч буй хүүхдээс харьцангуй бага хувьтай байна. Хамрагддаггүй шалтгаан нь цэцэрлэгт орон тоо байхгүй, гэртээ харах хүнтэй гэсэн шалтгаанууд байлаа. Харин ЕБС-ийн насны хүүхдүүдийн хувьд 3 хүүхэд сургуулиас завсардсан. 1 нь багш нартайгаа таарамжгүй харьцаатай, 2 нь эрүүл мэндийн шалтгаанаар сургуульд сурдаггүй байна.

Тэд аав, ээжтэйгээ хамт амьдарч чадахгүй байгаа нь тэдний хувьд хамгийн том хүндрэлтэй асуудал бөгөөд тэднийг байхгүй хооронд их санадаг гэсэн юм. Мөн эцэг эхийн хурал болоход очих хүн байхгүй, сургуулиас мөнгө хураасан тохиолдолд өгч чаддаггүй, аав, ээж хүнд ажил хийдэг учир санаа зовдог гэх зэрэг хүндрэл үүсдэг байна.

Харин зарим өрхүүдийн хувьд хүүхдүүд өөр айлд байх дургүйн улмаас гэртээ байдаг. Арай том болсон нь дүүгээ харж үлддэг. Дүүгээ харахын хажуугаар, түлээ түлш бэлтгэх, ус авах, хоол унд хийх, гэр цэвэрлэх зэрэг гэрийн бүх ажлыг хийдэг. Тухайлбал, 13 настай хүү 2 дүүгийнхээ хоолыг хийгээд байж байхтай бид таарсан. Энэ мэт байдал мөн л хүүхдүүд бэртэх, түлэгдэх нөхцөл байдал үүсгэж байгаа юм. Үүнээс гадна ийнхүү гэрийн ажил их хийдэг хүүхдүүд хичээл даалгавраа хийх ч цаг гардаггүй талаар хүүхдүүд болон багш нар хэлж байлаа.

Эцэст нь судалгаанд оролцогч хүүхдүүдээс ямар зүйл хийвэл хүүхдүүдэд, чамд тус болж чадах вэ гэж асуухад:

- Тоглоомын талбай
- Хичээл хийх танхим
- Номын сан
- Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх газар
- Спорт заал
- Цэцэрлэг/Өдөр өнжүүлэх төв
- Эрүүл мэндийн төв зэрэг газрууд байвал сурахад, хөгжихөд, эрүүл саруул амьдрахад нэмэр болно гэсэн юм.

Өөр нэг анхаарал татсан зүйл бол хүүхдүүд аав, ээжийгээ арай хөнгөн ажил хийгээсэй. Хол явдаг биш, бусдын адил гэрээсээ өглөө явж, оройдоо ирдэг ажилтай болгomoор байна гэсэн санал нэлээд хэлж байсан юм.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Бичил уурхай дээр эрэгтэй, эмэгтэй, хүүхэд хөгшид гэлтгүй бүхий л насны хүмүүс амьдарлаа залгуулахын тулд ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 64.4 хувийн амьдрал 100 хувь уурхайгаас хамааралтай байна.

Иргэдийг бичил уурхайд ажил эрхлэхэд нөлөөлж буй 2 үндсэн шалтгаан байгаагийн нэг нь тухайн орон нутагт ажлын байрны хүртээмж муу байгаа (4 хүн тутмын 3-ийн хариулт) , нөгөө нь тухайн иргэн тухайн ажлын байранд тэнцэхгүй буюу ажил олгогчийн тавих шалгуурт нийцэхгүй байгаа нь бичил уурхайчдын ярианаас харагдаж байлаа. Учир нь тэдний 87.1 хувь нь бүрэн дунд түүнээс доош боловсролтой, олж авсан мэргэжил боловсролгүй хүмүүс байгаа юм.

Бичил уурхайд ажилласнаар хамгийн том ололт юу болох, хамгийн том хүндрэл юу байгааг тодруулахад, өрхийн орлого нийт өрхийн 70 орчим хувийн хувьд сайжирсан нь хамгийн том ололт гэсэн бол, 20 орчим хувь нь эрүүл мэндийн хувьд урьдынхаас дордсон гэсэн хамгийн нийтлэг хүндрэл болж байна.

Мөн тэдний 64.6 хувь нь цаашид бичил уурхайд ажилласаар байх, 19.6 хувь нь цаашид ажиллахгүй байх хандлагатай байна. Харин 14.5 хувь нь цаашид хэрхэхээ одоогоо хэлж мэдэхгүй байна.

Нийт судалгаанд хамрагдагсдын 25 хувь нь одоо хүүхдүүдтэйгээ хамт уурхайн орчинд амьдарч байгаа, 75 хувь нь хүүхдүүдээ хаа нэгтээ орхиод бичил уурхайд ажиллаж байна. Бичил уурхайн орчинд амьдарч байгаа, тусдаа амьдарч байгаа аль ч хүүхдүүдийн хувьд эцэг, эхийн анхаарал халамж ихээхэн сул байдаг байна. Бичил уурхайн ажил хүнд, зарим нь олон хоногоор гэрээсээ хол ажилладаг, гэрээсээ явж ажилладаг нь олон цагаар ажилладаг учир хүүхдүүдээ анхаарал тавих боломж хомс байна.

Уурхайн орчинд амьдрахад тоос шороо, хог хаягдал, дуу чимээ, архидалт ихтэй. Орчин тойронд ухсан нүх ихтэй учир хүүхэд амьдрахад төдийлөн таатай биш орчин нөхцөл юм. Ийм нөхцөлд амьдрахад хүүхдүүд гэмтэж бэртэх эрсдэл өндөр, мөн тоос шороо, дуу чимээ ихтэй, хүйтэн сэрүүн нөхцөлд амьдрах нь хүүхдүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Мөн уурхайн орчинд амьдарч байгаа хүүхдүүдийн хувьд уурхайн хөдөлмөрт татагдан ороход амархан байдаг нь анзаарагдсан юм. Хүнд хэцүү хөдөлмөр эрхлээд зогсохгүй, энэ амьдарлын хэв маяг нь хүүхдүүдийн боловсролд сөргөөр нөлөөлж, хүмүүжлийн хувьд ч доголдолтой болоход нөлөөлж байна. Зуны улиралд хичээл амарсантай холбоотойгоор хүүхдүүд уурхайд ажиллах нь нэмэгддэг аж.

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 38 хувь нь хүүхдээ уурхайн ажилд туслуулдаг гэсэн бол, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 42.3 хувь нь хааяа, 22.5 хувь нь байнга тусалдаг гэсэн юм. Уурхайн ажилд туслахдаа угаахад зориулж бэлдсэн чулуу, шороо савлах зөөх, ус зөөх, нүх ухах, алт угаах зэрэг бүхий л үе шатанд оролцдог байна.

Зөвлөмж- Богино хугацаанд:

Зарим орон нутгийн хувьд ийш тийш нүүсэн шинжтэй, нэг газар удаан хугацаанд ажилладаггүй. Зарим орон нутагт тосгон, суурингийн ойролцоо үйл ажиллагаа явуулж, тосгоны ихэнх нь бичил уурхайгаас амьдралаа залгуулж байна. Эдгээр тосгон, суурингуудад дийлэнх бичил уурхайчид, тэдний хүүхдүүд амьдарч байгаа бөгөөд илүү олон хүнд хүрсэн үйл ажиллагаа явуулахын тулд эдгээр сум, сууринд тулгуурлавал илүү үр дүнтэй байна. Тухайлбал, Төв аймгийн Заамар сумын Хайлааст баг, Ховд аймгийн Цэцэг сумын Хөшөөт, Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгон, Сэлэнгэ аймгийн Зүүнхараа гэх мэт.

Хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагаа:

- Цэцэрлэг, өдөр өнжүүлэх төв байгуулах: Зарим газар огт цэцэрлэг байхгүй, байгаа газар нь орон тоо нь бүрдчихдэг учир хүүхдүүдээ өгч чадахгүй байна. Бичил уурхайчдын ажил жилийн дөрвөн улиралд явагдаж, зуны цагаар илүү идэвхждэг. Гэтэл зун хүүхдийн сургууль, цэцэрлэг амарчихдаг учир хүүхдээ олборлолтын талбайруу авч явах, эсвэл гэртээ хэн нэгэн харж үлдэх, ах эгч нарт нь харуулж үлдээх зэрэг нэг бол эрсдэлтэй орчинд байлгах, нэг бол эцэг эх нь ажлаа хийж чадахгүй байх нөхцөл үүсдэг. Өрөөсгөл гэр бүлүүдийн хувьд хүүхдүүдээ ойр орчмын хэн нэгэнд захиж, харах хүнгүй гэрт нь үлдээдэг. Тиймээс цэцэрлэг байгуулсан тохиолдолд, нэг талаар хүүхдүүд уурхайн аюултай орчинд очихгүй, гэртээ харах хүнгүй үлдэхгүй, нөгөө талаар эцэг эхчүүд ажлаа хийх боломж бүрдэх юм. Мөн цэцэрлэг байлаа ч яслийн бүлэг байдаггүй учир яслийн бүлэг нээвэл зүгээр гэж байлаа. Мөн сум, суурингаас хол олборлолт хийж байгаа өрхүүдийн хувьд, явуулын гэр цэцэрлэг хэрэгтэй байна. Энэ нь дүү нараа хардаг хүүхдүүдийн хувьд ч чөлөөт цаг гарч, өөрсдийн хөгжилд анхаарах боломж олгох юм.
- Хүүхдийн хөгжилд зориулсан газар байгуулах: Эцэг эх нь олон хоногоор ийш тийш явах, гэртээ байсан ч олон цагаар ажилладаг учир хүүхдүүдийн хичээлд санаа тавих, дэмжлэг үзүүлэх боломжгүй байдаг учир ийм үйл ажиллагаа явуулдаг газар байвал хүүхдүүд сурч хөгжихөд дэмжлэг болох юм. Мөн зуны цагт хүүхдүүд хийх юмгүй, тэнэх асуудал гардаг байна. Тиймээс дараахь үйл ажиллагааг багтаасан байвал зүгээр гэсэн эцэг эх, хүүхдүүдийн санал ирсэн. Үүнд:
 - Хүүхдүүд хичээл хийх боломжтой
 - Номын сантай
 - Интернет, компьютер гэх зэрэг технологитой танилцах боломжтой
 - Эцэг, эхээсээ тусдаа байгаа хүүхдүүдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгдөг
- Хичээлийн хэрэгсэл, хувцсаар дэмжлэг үзүүлэх: Хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө сайн дурын бүлэглэлүүд зохион байгуулж, хичээлийн хэрэгсэл, бусад шаардлагатай хэрэгслийн хандив цуглуулж, эдгээр хүүхдүүдэд дэмжлэг үзүүлснээр нэг ч гэсэн хүүхэд сургууль завсардахаас сэргийлж чадах юм.
- Тоглоомын талбай байгуулах: Одоо нэг сум, сууринд нэг ч тоглоомын талбай байхгүй газар олон байна. Байгаа тоглоомын талбайн тоглоомууд эвдэрч муудсан учир хүүхдүүдэд харин ч аюултай болсон байна. Тиймээс хүүхдүүдэд тоглож наадах боломжийг бий болгохын тулд тоглоомын талбай байгуулах хэрэгтэй байна.

- Замын тэмдэглэгээ, хашлага: Уурхайн үйл ажиллагаа ихээхэн идэвхтэй явагдаж байгаа машин ихтэй учир хүүхдүүд осол гэмтэлд өртөх эрсдэл их байна. Тиймээс тэдгээр газруудад замын тэмдэг, тэмдэглэгээ хийх, шаардлагатай газар замын хашлага хийх хэрэгтэй байна.
- Орчны бохирдлыг шийдвэрлэх: Мөн уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор сул шороо ихтэй учир тоос шороо ихтэй. Олон хүн ажиллаж байгаа тохиолдолд хог хаягдал ихтэй, эрчүүд дуртай газраа бие засдаг учир орчны бохирдол ихтэй.
- Сургууль барих, засварлах: Зарим сургуулиудын орчин маш муу, дээврээс ус гоождог, шал нь цөмөрсөн, халаалт байхгүй учир өвлийн цагаар хичээлээ зогсоохоос өөр аргагүйд хүрсэн сургууль ч байна. Тиймээс сургууль шаардлагатай газар сургууль барих, муу засвартай сургуулиудыг засах, ядаж дулаанаар хангах зэрэг сургуулиудад хэрэгтэй байна.
- Бичил уурхайчид болон тухайн орчинд амьдарч байгаа хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн тусламж үзүүлэх, явуулын эмийн сангаар хангах.
- Бичил уурхайчдын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал: Энэ тал дээр хамгийн дорвитой үйл ажиллагаа явуулж буй газар бол Швейцарийн Хөгжлийн Агентлагийн "Тогтвортой бичил уурхай" төсөл юм. Уг төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллавал бичил уурхайчид төдийгүй тэдний хүүхдүүдийн төлөө хийх нэг алхам болох юм.
- Хүмүүсийн хандлагыг өөрчлөх, сэтгэлзүйд нөлөөлөх: Хүмүүс өдөр, шөнөгүй цөөн хэдэн хүмүүстэй, орчин нөхцөл муу газар ажиллаж байгаа тэдний хувьд амьдарлаа төлөвлөх, алсыг харах, өрхийн эдийн засгаа оновчтой хөтлөх, төлөвлөх ч мэдлэг, дадал дутмаг байна.

Зөвлөмж- Урт хугацаанд: Бичил уурхайчдын үйл ажиллагааг албан ёсоор хүлээн зөвшөөрч, хууль эрхзүйн орчноор баталгаажуулж, нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулж эхэлснээс хойш бичил уурхайчидтай холбоотой үүсдэг байсан маш олон асуудал сайнаар шийдэгдсэн нь харагдаж байлаа. Хэрэгжилт орон нутаг бүрт харилцан адилгүй явцтай, өөр өөр хэлбэртэй байсан юм. Бичил уурхайн энэ шинэчлэл маш олон асуудлыг сайнаар шийдсэн ч гэр бүлд, хүүхдүүдэд үзүүлэх нөлөөний хувьд төдийлөн их өөрчлөлт авчираагүй байна. Бичил уурхайчид зохион байгуулалтанд орж, албан ёсоор үйл ажиллагаа явуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал хангаж ажиллаж байгаа нь шууд бусаар гэр бүлд баталгаа болж байгаа ч зарим бичил уурхайчид нөхөрлөлд орохоос "нууц"-аар үйл ажиллагаа явуулахыг илүүд үзэж байна. Зарим тогтмол биш үйл ажиллагаа явуулдаг хүмүүс ч байсаар байгаа.

Тиймээс эдгээр хүмүүсийн өөрсдийн төдийгүй гэр бүлийн эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөө, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалын төлөө, тогтвортой орлогын эх үүсвэртэй аюулгүй ажлын байр бий болгох нь чухал байна.

Ингэснээр дээр дурьдагдсан боловсрол, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлт зэрэг бүхий л асуудлыг сууриар нь, урт хугацаанд шийдэх арга зам юм.

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Сүүлийн жилүүдэд бичил уурхайн асуудал ихээр анхаарал татсан, нийгмийн эмзэг асуудлуудыг нэг болсон. Бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсоор хүлээн зөвшөөрч, хууль эрхзүйн орчин бүрдэж байгаа хэдий ч уурхайн хөдөлмөр эрхлэлтийн онцлогтой холбоотойгоор гэр бүл, хүүхдүүдэд үзүүлэх нөлөө анхаарал татсан асуудал хэвээр байна.

Монгол улсын Үндэсний статистикийн хороо болон Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран 2012 онд хийсэн “Бичил уурхайн эрхлэгчдийн судалгааны нэгдсэн тайлан”-аар 13375 иргэн бичил уурхай эрхэлж байна. Тэдний 928 нь буюу 7.0 хувь нь 10-19 насныхан байна.

Бичил уурхайн салбар болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн тухайд олон судалгаа хийгдэж байсан боловч яг бичил уурхайн хүүхдэд үзүүлж буй нөлөөг хэмжсэн судалгаа одоогоор хийгдээгүй байгаа юм. Тиймээс энэхүү судалгаагаар энэ орон зайг нөхөхөөр зорьсон нь энэхүү судалгааны онцлог, шинэлэг тал юм. Зөвхөн бичил уурхай эрхэлж буй орчинд амьдарч байгаа хүүхдүүдэд бичил уурхайн нөлөөлөөд зогсохгүй, хаа нэгтээ гэртээ үлдсэн, хэн нэгэнд харуулууд үлдээсэн хүүхдүүд хүртэл бичил уурхайн нөлөөллийн тусгал болж байна.

Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагын үндсэн үйл ажиллагаа хүүхдийн сайн сайхны төлөө чиглэдэг бөгөөд манай төсөл хөтөлбөрт одоогийн байдлаар 86,500 гаруй хүүхэд хамрагддаг. Тиймээс бид манай төсөл хөтөлбөрүүдэд хамрагддаг хүүхдүүдээс гадна хамрагдаж чаддаггүй бичил уурхайчдын хүүхдэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, тэдэнд дэмжлэг үзүүлэх боломжийг эрэлхийлсэн юм.

Мөн энэхүү судалгаагаар бид ямар нэгэн тооллого хийхийг урьтал болгоогүй бөгөөд түүвэр судалгааны үр дүнд тулгуурлан, бичил уурхайчдын гэр бүлийн ерөнхий дүр төрхийг харах, хүүхдүүдэд ямар нөлөө үзүүлж буйг тодорхойлохыг зорьсон юм.

1 СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны зорилго нь бичил уурхайчдын хүүхдүүдэд тулгарч буй бэрхшээл, эцэг, эх нь бичил уурхайд ажилласнаас үүдэлтэй тэдэнд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг тодорхойлох, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд оршино.

Судалгааны зорилтууд:

- Бичил уурхайчдын гэр бүлийн амьдралын хэв маягийг тодорхойлох
- Ажил эрхлэлтээс үүдэлтэй бичил уурхайчдын шилжилт хөдөлгөөн
- Бичил уурхайн хүүхдүүдийн боловсролд нөлөөлөх нөлөөлөл
- Бичил уурхайн хүүхдүүдийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл
- Бичил уурхай дээрх хүүхдийн хөдөлмөр эрхлэлт
- Бичил уурхайн хүүхдийн хүмүүжилд нөлөөлөх нөлөө
- Хүүхэд хамгааллын асуудал (гэмт хэрэг, хүчирхийлэл, өнчрөл гэх зэрэг)
- Засгийн газар, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагуудаас бичил уурхайчдын хүүхдүүд рүү чиглэсэн ямар нэгэн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг бий болгох

Судалгааны арга, аргачлал:

Судалгааны мэдээллийн итгэх түвшинг дээшлүүлэхийн тулд фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, асуулгын арга гэх зэрэг тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан ашигласан юм.

Судалгааны онцлогоос хамаарч судалгааны мэдээллийг нэлээд өргөн хүрээтэй цуглуулсан бөгөөд судалгаанд оролцогчийн ангилал тус бүрт тааруулж өөр өөр мэдээлэл цуглуулах хэрэглэгдэхүүн боловсруулсан.

Мэдээлэл цуглуулалтын аргууд

Судалгааны нэгж

**Фокус бүлгийн
ярилцлага**

Төрөл 1: Хүүхдүүдтэйгээ уурхайн орчинд амьдардаг эцэг эхчүүд

Төрөл 2: Хүүхдүүдээ гэртээ үлдээгээд уурхайд ажиллаж буй эцэг эхчүүд

**Ганцаарчилсан
ярилцлага**

Төрөл 1: Уурхайн орчинд амьдардаг хүүхдүүд

Төрөл 2: Эцэг, эхээсээ тусдаа амьдардаг хүүхдүүд

Асуулга

Төрөл 1: Өрхийн асуулга (насанд хүрэгчид)

Төрөл 2: Уурхайн орчинд амьдардаг хүүхдүүд

Төрөл 3: Эцэг, эхээсээ тусдаа амьдардаг хүүхдүүд

Ажиглалт

Экспертийн ярилцлага

Судалгаанд оролцогч:


Судалгааны үндсэн оролцогчид нь дараахь 3 төрлийн оролцогч байсан бөгөөд судалгаанд оролцогчийн мэдээлэл өгөх чадварыг харгалзан үзэж дараахь шалгууруудыг тавьж судалгаанд оролцогчийг сонгосон юм.

Мөн судалгаанд оролцогчдыг сонгохдоо насанд хүрэгчдийн хувьд ч, хүүхдийн хувьд ч нэг өрхөөс нэг хүн сонгох замаар сонгосон.



Бичил уурхайчин насанд хүрэгч

- 17 түүнээс доош насны дор хаяж нэг хүүхэдтэй
- Уурхайд 3 болон түүнээс дээш сар ажиллаж байгаа



Уурхайн орчинд амьдарч буй хүүхэд

- 8-17 настай
- Сэтгэцийн хувьд эрүүл, үнэн бодит мэдээлэл өгөх чадвартай
- Уурхайн орчинд 3 болон түүнээс дээш сар амьдарч байгаа




Эцэг, эхээсээ тусдаа амьдардаг бичил уурхайчдын хүүхэд

- 8-17 настай
- Сэтгэцийн хувьд эрүүл, үнэн бодит мэдээлэл өгөх чадвартай
- Эцэг, эхийн хэн нэгэн уурхайд ажилладаг
- Эцэг, эхийн хэг нэгнээс дор хаяж 3 сар хол амьдарсан

Судалгааны түүвэрлэлт:

Судалгаанд хамрагдах аймгуудыг сонгохдоо Уул уурхайн яамны харъяа Ашигт малтмалын газраас гаргасан бичил уурхайн талхалтын дараахь зураглал дээр үндэслэн бичил уурхайн нягтаршил ихтэй аймгуудыг сонгосон.

Зураг 1-1 Бичил уурхайн байршил тархалт¹



- Бичил уурхай бүхий сумд
- ◆ Бичил уурхайн эрх зүйн орчины сургалтанд хамрагдсан сумд
- Бичил уурхайгаар ашиглах газрын дүгнэлт гаргуулах тухай хүсэлт гаргасан сумд
- Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авсан сумд
- ☺ Зохион байгуулалтад орсон сумд
- ★ Бичил уурайн үйл ажиллааг зохицуулах, хууль тогтоомжыг хэрэгжүүлэх талаар идвэхтэй ажиллаж байгаа сумд

Судалгаанд хамруулахаар сонгосон аймаг, сумдуудын хүн амын тоон дээр үндэслэн түүвэрлэлтийг хийсэн. Нийт эх олонлогийн тоо $89,995^2$ үүнээс томъёо 1-р 95% хувийн итгэх түвшин, 5 хувийн алдааны хязгаартай тооцож үзэхэд түүврийн хэмжээ 383 судалгааны нэгж байна.

$$n = \frac{N}{1 + N(e)^2} = \frac{89995}{1 + 89995(0,05)^2} = 383(1)$$

Энд:

n- нийт түүвэрлэгдэх нэгжийн тоо

N- нийт эх олонлогийн хэмжээ

e – байж болох алдаан түвшин (алдааны хязгаар)

¹ www.bichiluurhai.mn

² Үндэсний статистикийн хороо, Статистикийн эмхтгэл-2012 он

Хүснэгт 1-1 Түүврийн тархалт, судалгааны арга тус бүрээр

Аймаг	Сум	Фокус бүлгийн ярилцлага		Ганцаарчилсан ярилцлага		Асуулга		
		Төрөл 1	Төрөл 2	Төрөл 1	Төрөл 2	Төрөл 1	Төрөл 2	Төрөл 3
Ховд	Дөргөн, Цэцэг	Х		3	3	30	15	15
Увс	Тариалан, Өмнөговь		Х	3	3	35	18	17
Говь-Алтай	Бигэр, Тайшир	Х		3	3	25	13	13
Завхан	Ургамал		Х	3	3	15	7	8
Хөвсгөл	Улаан-Уул, Ренчинлхүмбэ	Х		3	3	40	20	20
Баянхонгор	Баян-Овоо, Галуут,		Х	3	3	30	15	15
Дархан-Уул	Шарын гол	Х		3	3	35	17	18
Сэлэнгэ	Ерөө			3	3	30	15	15
Сэлэнгэ	Мандал /Зүүнхараа/		Х	3	3	70	35	35
Төв	Заамар, Борнуур	Х		3	3	45	23	22
Хэнтий	Батноров /Бэрх/		Х	3	3	30	15	15
Нийт		5	5	30	30	385	193	193

Ганцаарчилсан ярилцлага

Судалгаанд оролцогч хүүхдүүдтэй илүү дэлгэрэнгүй ярилцаж мэдээлэл авахын тулд нас насны ангиллаар бүлэглэж, нийт 60 ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан бөгөөд ярилцлагыг урьдчилж бэлтгэсэн удирдамжийн дагуу явуулсан.

Ганцаарчилсан ярилцлагын насны тархалт:

Хүснэгт 1-2 Хүүхдийн ганцаарчилсан ярилцлагын насны тархалт

№	Аймаг	8-10 настай	11-14 настай	15-17 настай	Нийт
1.	Ховд	2	2	2	6
2.	Увс	2	2	2	6
3.	Говь-Алтай	2	2	2	6
4.	Завхан	2	2	2	6
5.	Хөвсгөл	2	2	2	6
6.	Баянхонгор	2	2	2	6
7.	Дархан-Уул	2	2	2	6
8.	Сэлэнгэ	2	2	2	6
9.	Төв	2	2	2	6
10.	Хэнтий	2	2	2	6

Фокус бүлгийн ярилцлага зохион байгуулах

Тоон судалгааны үр дүнгээр гаргаж авах боломжгүй үр дүнгүүдийг фокус бүлгийн ярилцлагаар тодорхойлох, тоон судалгааны үр дүнгүүдийг баримтжуулах, судалгааны багийн урьдчилж харж чадаагүй асуудлуудыг тодруулах зорилгоор фокус бүлгийн ярилцлагыг мэдээлэл цуглуулах өөр нэг аргаар сонгосон.

Мэдээллийг илүү дэлгэрэнгүй төрөлжүүлж авахын тулд 2 төрлийн нийт 10 бүлгийн ярилцлага зохион байгуулсан.

Бүлгийн ангиллыг дараахь байдлаар ангилсан. Үүнд:

- Хүүхдүүдтэйгээ хамт уурхайн орчинд амьдардаг эцэг эхчүүд
- Хүүхдүүдээ гэртээ үлдээгээд уурхайд ажиллаж буй эцэг эхчүүд

Ярилцлагыг аймаг бүрт ижил удирдамжийн дагуу зохион байгуулсан бөгөөд бүлгийг модератор удирдаж, ажиглагч, тэмдэглэл хөтлөгч нарын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа The Survey System програмын ухаалаг утсанд зориулсан аппликешнийг ашиглан цуглуулсан. Цаг хугацааны хувьд 2013 оны 10-р сарын эхний хагаст бүх аймгуудад зэрэг хийгдсэн. Цаг агаарын хувьд нэлээд хүйтэрсэн байсан учир бичил уурхайчид нэлээд цөөрсөн байсан юм.

Мэдээллийн санд дүн шинжилгээ хийхдээ SPSS (Statistical Package for the Social Sciences) програмыг ашигласан болно.

2 ТООН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН СУДАЛГАА

2.1.1 Хамарсан хүрээ

Судалгааны түүврийн төлөөлөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд судалгаанд аль болох олон аймаг хамруулж авахыг хичээсэн бөгөөд нийт 10 аймгийн 17 сумыг хамруулан, нийт 387 бичил уурхайчинтай уулзаж, тэдний ажил амьдралтай танилцсан юм. Судалгаанд хамрагдсан уурхайнууд ажиллаж буй хүний тооны хувьд, төрөл цар хүрээний харилцан адилгүй байсан юм.

Судалгаанд хамрагдсан сумдуудаас хамгийн олон хүн амтай сум болох Сэлэнгэ аймгийн Мандал (Зүүнхараа) сумаас хамгийн олон бичил уурхайчин судалгаанд хамрагдсан.


Хүснэгт 2-1 Өрхийн судалгааны түүврийн тархалт

Аймаг	Сум	Тоо	Хувь
Баянхонгор	Баян-Овоо	14	9.0
	Галуут	9	
	Жаргалант	12	
Сэлэнгэ	Мандал	71	26.4
	Ерөө	31	
Төв	Борнуур	16	12.4
	Заамар	32	
Увс	Өмнөговь	20	12.1
	Тариалан	22	
Завхан	Ургамал	18	3.4
Ховд	Цэцэг	17	9.0
	Дөргөн	18	
Хөвсгөл	Улаан-Уул	18	5.2
	Ренчинлхүмбэ	2	
Дархан	Шарын гол	32	8.3
Говь-Алтай	Есөнбулаг	26	6.7
Хэнтий	Батноров	29	7.5
Нийт		387	100.0

2.1.2 Бичил уурхайчдын шилжилт хөдөлгөөн

Бичил уурхай дагасан шилжилт хөдөлгөөн сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэх болсон бөгөөд ажил эрхлэлт дагаж хийгдэж буй бусад шилжих хөдөлгөөнтэй харьцуулахад бичил уурхайчдын шилжилт хөдөлгөөн илүү богино хугацааны, ирж очсон, гэр бүлийн гэхээс илүү зөвхөн бичил уурхайд ажиллаж буй хувь хүний нүүдэл суудал шинжтэй байна.


График 2-1 Шилжилт хөдөлгөөн



Нийт судалгаанд оролцсон 387 хүний 104 нь буюу 27 хувь нь нутгийн уугуул иргэн биш, хаа нэгтгээгээс шилжиж ирсэн бөгөөд эдгээрийн 23 хувь нь уурхай бараадаж нүүж иржээ. Эдгээр хүмүүс ажилтай, орлоготой байхын тулд нутаг усаа орхиж, сум аймаг дамжин нүүж ирсэн нь хөдөө орон нутагт ажлын байрны хомсдол хэр их байгаа, эдгээр хүмүүс амьдралаа залгуулахын тулд ямар их чармайлт гаргаж байгааг харуулж байна. Бичил уурхай дагасан энэхүү шилжилт хөдөлгөөн Сэлэнгэ (Зүүн хараа), Төв аймаг (Заамар), Хэнтий (Бэрх) зэрэг аймгуудад хамгийн их байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгаас судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 38,2 хувь нь өөр аймаг эсвэл сумнаас нүүж ирсэн байна.


Төв аймгийн Заамар сумын хувьд л гэхэд Архангай, Баянхонгор, Булган, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд, Хэнтий, Төв аймгийн бусад сумдуудаас ирсэн иргэд байна.

График 2-2 Нийт судалгаанд оролцогчдын дунд шилжиж ирэгсдийн эзлэх хувь



Харин нүүж ирсэн хугацааны хувьд 40.4 хувь нь 1 жил хүртэл хугацаанд тухайн аймаг сумандаа амьдарч байгаа нь бичил уурхайчдын энэхүү шилжилт хөдөлгөөн богино хугацааны шинжтэй байгааг харуулж байна. Шилжиж ирэх болсон шалтгаан уурхайд ажил эрхлэх байсантай холбоотойгоор нийт шилжиж ирэгсдийн 80 орчим хувь нь сүүлийн 5 жилийн хугацаанд тухайн орон нутагт амьдарч байна.

График 2-3 Шилжин ирэгсдийн тухайн аймаг, суманд амьдарч буй хугацаа



Хэдийгээр тухайн аймаг, суманд амьдарч байгаа ч, нийт шилжиж ирэгсдийн 3 хүн тутмын 2 нь тухайн аймаг, сумандаа бүртгэлгүй байна.

Иргэний бүртгэлгүй ийнхүү орон нутагт суурьших тухайн хувь хүний хийгээд гэр бүлийн гишүүдийн боловсролын болон эрүүл мэндийн гэх зэрэг төрийн үйлчилгээ хүртэх боломжийг хязгаарлагдаж байгаа нь уурхайчдын сэтгэлийг зовоосон нэг асуудал болж байгаа юм.

Хүснэгт 2-2 Шилжиж ирэгсдийн бүртгэгдсэн байдал

Бүртгэл	Тоо	Хувь	Хувь
Энэ сумандаа бүртгэлтэй	34	8.8	32.7
Энэ сумандаа бүртгэлгүй	70	18.1	67.3
Нийт	104	26.9	100.0

Нөгөө талаар энэ нь зөвхөн бичил уурхайчдын гэр бүлийн эрх зөрчигдөхөөс гадна бүртгэлгүй олон иргэд орон нутагт нүүж ирснээр орон нутгийн суурин иргэдийн төрийн үйлчилгээний хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. Учир нь орон нутгийн төсөв тухайн орон нутгийн суурин хүн амын тоонд үндэслэгдэж хуваарилагддаг. Гэтэл зарим орон нутгийн хувьд бодит суурьшмал хүн ам нь бүртгэлтэй хүн амаас эрс зөрүүтэй, олон байгаа нь төрийн үйлчилгээний хүртээмжид ийнхүү нөлөөлдөг болох нь судалгааны явцад зарим орон нутагт хурцаар яригдаж байлаа.

2.1.3 Судалгаанд оролцогчийн хувийн мэдээлэл

Бичил уурхайн ажил эрхлэх нь хэдийгээр хүнд хөдөлмөрийн хэлбэрт орох боловч насны болон хүйсийн ялгаагүй, эрэгтэй эмэгтэй, бүх насны хүмүүс ажиллаж байна.


Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 80 орчим хувь нь 45-аас доош насныхан байгаа юм. Судалгааны зорилго хүүхдийн асуудалд илүү чиглэгдэж байсан учир бид судалгаанд оролцогчид дор хаяж нэг хүүхэдтэй байх шалгуур тавьсан учир хамгийн залуу судалгаанд оролцогч 22 настай. Хүүхэдтэй байх гэсэн шалгуур тавиагүй бол бичил уурхайчдын нас ихээхэн залуу байх нь судалгааны явцад харагдаж байсан юм. Харин хамгийн ахмад бичил уурхайчин 60 настай байсан юм.

Хүснэгт 2-3 Судалгаанд оролцогчдын насны бүлэг

Насны бүлэг	Тоо	Хувь
25 хүртэл	18	4.7
26-35 хүртэл	128	33.1
36-45 хүртэл	162	41.9
46-55 хүртэл	71	18.3
56-аас дээш настай	8	2.1
Нийт	387	100.0

Хүйсийн хувьд эрэгтэйчүүд эмэгтэйдээс илүү давамгайлж байгаа бөгөөд нийт судалгаанд хамрагдагсдын 63 хувь нь эрэгтэйчүүд байна. Уурхайд ажиллах нь харьцангуй хүнд хөдөлмөр учир эмэгтэйчүүдэд төдийлөн тохиромжтой биш нь ойлгомжтой. Гэвч эмэгтэйчүүд амьдралын эрхээр уурхайд нүх ухаж, шороо зөөж байна. Эхнэр, нөхөр, хүүхэд гэх зэрэг бүх гэр бүлээрээ бичил уурхайд ажиллаж буй гэр бүлтэй ч бид таарсан юм.

График 2-4 Судалгаанд оролцогчдын хүйс



Иргэдийг бичил уурхайд ажил эрхлэхэд нөлөөлж буй 2 үндсэн шалтгаан байгаагийн нэг нь тухайн орон нутагт ажлын байрны хүртээмж муу байгаа, нөгөө нь тухайн иргэн тухайн ажлын байранд тэнцэхгүй буюу ажил олгогчийн тавих шалгуурт нийцэхгүй байгаа нь бичил уурхайчдын ярианаас харагдаж байлаа.

Судалгаанд оролцсон бичил уурхайчдын 87.1 хувь нь бүрэн дунд түүнээс доош боловсролтой буюу ямар нэгэн их дээд сургууль, коллежоор олж авсан мэргэжилгүй болох нь харагдаж байна. Харин үйлдсэн 12.9 хувь нь тусгай дунд, дээд боловсролтой. Эндээс харахад бичил уурхайчдын боловсрол, мэргэжил нь одоогийн хөдөлмөрийн зах зээлд ажил олоход ихээхэн хүндрэлтэй байгаа төдийгүй, бичил уурхайд ажиллахад нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байгааг харж болохоор байна.

График 2-5 Судалгаанд оролцогчдын боловсрол



Нийт 387 өрхийн 19.1 нь 1-3 ам бүлтэй, 70.8 хувь нь 4-6 ам бүлтэй, 10.1 хувь нь 7-оос дээш ам бүлтэй, **дундаж ам бүлийн тоо 4.9** байна. Хамгийн олон ам бүлтэй айл 9 ам бүлтэй.

Хүснэгт 2-4 Ам бүлийн тоо

Ам бүл	Тоо	Хувь
1-3 ам бүлтэй	74	19.1
4-6 ам бүлтэй	274	70.8
7-оос дээш ам бүлтэй	39	10.1
Нийт	387	100.0

Амьдарч буй сууцны хувьд, зарим уурхайчид байнгын оршин суудаг газраасаа өглөөдөө ирж, оройдоо буцах замаар ажилладаг учир доорх үр дүнг 100 хувь уурхайн орчин дахь сууц гэж авч үзэхэд хүндрэлтэй. Гэвч уурхайн талбайд амьдарч буй сууцны хамгийн нийтлэг хэлбэр Монгол гэр, майхан гэнэ. Зарим тохиолдолд зуны улиралд түр зуур амьдарч болох оромж барьж толгой хоргоддог байна.

Хүснэгт 2-5 Амьдардаг сууцны хэлбэр

Төрөл	Тоо	Хувь
Монгол гэр	174	45.0
Майхан	83	21.4
Байшин	68	17.6
Түр оромж	25	6.5
Нүхэн сууц	1	.3
Бусад	36	9.3
Нийт	387	100.0

2.1.4 Амьжиргааны нөхцөл байдал

Хүүхдийн төдийгүй тухайн өрхийн амьжиргаанд хамгийн их нөлөөтэй зүйл бол тухайн өрх орлоготой байх асуудал. Тиймээс судалгаанд хамрагдсан өрхүүдийн ажил эрхлэлтийн байдлыг харахад нийт өрхийн 50 хувьд дөнгөж 1 хүн ажил эрхэлж байна. Харин 45.2 хувьд 2 хүн, 3.9 хувьд 3 хүн, 2 өрхөд 4 хүн ажил эрхэлдэг аж.

Хүснэгт 2-6 Ажил хийдэг хүний тоо

Хүний тоо	Тоо	Хувь
1 хүн	195	50.4
2 хүн	175	45.2
3 хүн	15	3.9
4 хүн	2	0.5
Нийт	387	100.0

Дараахь хүснэгтэнд зөвхөн бичил уурхайд ажиллаж буй хүний тоог харуулсан бөгөөд нийт ажил эрхэлж буй 598 хүний 537 нь буюу 89.8 хувь нь бичил уурхайд ажиллаж байна. Эдгээр өрхийн 64.6 хувийн амьдрал 100 хувь бичил уурхайгаас

хамааралтай байгаа нь бичил уурхайн талаар төрөөс баримталж буй бодлого хичнээн олон өрхөд хамааралтай болохыг харуулж байгаа юм.


Хүснэгт 2-7 Бичил уурхайд ажилладаг хүний тоо

Хүний тоо	Тоо	Хувь
1 хүн	250	64.6
2 хүн	125	32.3
3 хүн	11	2.8
4 хүн	1	0.3
Нийт	387	100.0

Бичил уурхайд ажил эрхэлдэг эдгээр хүмүүсийн 54 нь бичил уурхайн ажлаас гадна давхар ямар нэгэн ажил хийдэг гэж бөгөөд ихэвчлэн жижиглэн худалдаа, ачаа тээврийн үйлчилгээ үзүүлж байна.

Чухам ямар шалтгааны улмаас бичил уурхайд ажил эрхлэх болсон талаар судалгаанд оролцогчдоос асуухад 4 хүн тутмын 3 нь буюу 75.2 хувь нь байнгын ажлын байр олдоогүй гэсэн шалтгаан хэлсэн юм. Үүнд мөн тэдний амьдарч буй орон нутгийн ажлын байрны хүртээмж, тэдний мэргэжил боловсролын асуудал ихээхэн нөлөөтэй байгаа нь бусад үр дүнгүүдээс мөн харагдаж байгаа юм.

График 2-6 Бичил уурхайд ажиллах болсон шалтгаан



2.1.5 Ажлын нөхцөл байдал

Бичил уурхайг албан ёсоор ажлын байрны нэг хэлбэр гэж хүлээн зөвшөөрч, хууль эрхзүйн орчин нь бүрдэж байгаа ч энэ нь төдийлөн нийтлэг үр дүнтэй байж чадахгүй байна. Учир нь албан ёсоор нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж ажиллаж байгаа уурхайчдын хажуугаар “нууц”-аар олборлолт хийдэг хэсэг байсаар байгаа юм.

Тиймээс тэдгээр хүмүүсийн ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг асуудал хяналтаас гадуур явж байгаа нь тэдний эрүүл мэнд, амь насанд аюул

дагуулж байна. Ялангуяа нийт бичил уурхай эрхэлдэг өрхийн 60 гаруй хувь 100 хувь бичил уурхайгаас хамааралтай байгаа энэ нөхцөлд тэдний эрүүл мэнд, аюулгүй байдал төдий чинээ хурц тавигдах ёстой.

Зөвхөн ажлын цагийн хувьд авч үзвэл, 60 гаруй хувь нь өдөрт 8-аас илүү цаг ажилладаг бөгөөд хамгийн дээд тал нь хоногт 20 цаг хүртэл ажиллах тохиолдол гардаг байна. Учир нь хулгайгаар олборлолт хийж байгаа тохиолдолд хэзээ ч “баривчилгаа” хийгдэх магадлалтай учир нэг өдрийн өмнө ч болов, шөнө оройн цагаар ажиллаж ахиухан шороо гаргаж авахыг хичээдэг учир тэдэнд ажлын цагийн асуудал ярих ямар ч боломжгүй байдаг.

Хүснэгт 2-8 Хоногт ажилладаг цаг

Ажлын цаг	Тоо	Хувь
8 цаг хүртэл	152	39.3
9-12 цаг	176	45.5
13-16 цаг	30	7.8
17-20 цаг	29	7.5
Нийт	387	100.0

Харин ажлын өдрийн хувьд мөн л дээрх шалтгааны улмаас амрахгүйгээр ажиллахыг илүүд үздэг байна. Тиймээс хөдөлмөрийн хуулийн дагуу буюу долоо хоногт 5 өдөр ажилладаг 20 гаруйхан хувь байна. Үлдсэн 80 орчим хувь 7 хоногт 6-7 өдөр ажилладаг.

Хүснэгт 2-9 Долоо хоногт ажилладаг өдөр

Ажлын өдөр	Тоо	Хувь
1-3 өдөр	16	4.1
4-5 өдөр	67	17.3
6-7 өдөр	304	78.6
Нийт	387	100.0

Бичил уурхайчид долоо өдөрт дунджаар 10.3 цаг, долоо хоногт дунджаар 6.4 өдөр ажиллаж байгаа буюу долоо хоногт дунджаар 65.9 цаг ажиллаж байна. Энэ нь хөдөлмөрийн хуулийн заасан нормаас 1.6 дахин буюу 60 хувиар илүү цаг ажиллаж байна гэсэн үр дүн юм.

Дээрх үр дүн бүх хүний хувьд бүтэн жилийн хугацаанд үргэлжилдэггүй зөвхөн уурхайн дээр ажиллаж буй хугацааны хооронд яригдаж буй асуудал юм.

Бичил уурхайн ажил эрхлэлтийн нэг онцлог нь улирлын шинжтэй байдаг бөгөөд хавар, зун, намар дулааны улирлуудад идэвхтэй, өвлийн улиралд идэвхи нь сулардаг. Мөн албан ёсны бусад ажлын байртай харьцуулахад ажил эрхлэгчид өөрсдийн хүссэн үедээ ажиллаж, мөн хүссэн үедээ ажиллахаа больдог. Тиймээс бичил уурхайн ажил эрхлэлт ямар мөчлөгтэй байгааг сонирхож үзэхэд, 44.7 хувь нь бүтэн жилийн туршид

бичил уурхайд ажилладаг гэсэн бол 52.5 хувь нь ямар нэгэн тогтсон хугацаагүй боломжтой үедээ ирж ажилладаг гэжээ.

Бичил уурхайчдын жилд ажилладаг хоног ялгаатай байгаа ч дундаж үр дүнгээр нь авч үзвэл, нэг уурхайчин жилд дунджаар 201 өдөр ажилладаг байна.

График 2-7 Бичил уурхайд ажиллах үе



Бичил уурхайчдын асуудал сүүлийн жилүүдэд ихээр анхаарал татаж, түүнд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, хууль эрхзүйн орчин бүрдэж байгаа гэх зэргээр бичил уурхайчдын нийгмийн асуудалд нааштайгаар шийдэгдэж байгаа олон асуудал байгаа.

Гэтэл ажлын онцлогтой холбоотойгоор хууль эрхзүй, журмаар шийдэгдэхгүй олон асуудал байсаар байна. Гэр бүлээсээ удаан хугацаагаар хол амьдарч, үр хүүхдүүдээ анхаарал тавих боломжгүй болох, гэр бүл салах, эрүүл мэнд доройтох зэрэг асуудал хамгийн ил тод анхаарал татаад байгаа.

Бичил уурхайд ажилласнаар хамгийн том ололт юу болох, хамгийн том хүндрэл юу байгааг тодруулахад, өрхийн орлого нийт өрхийн 70 орчим хувийн хувьд сайжирсан нь хамгийн том ололт гэсэн бол, 20 орчим хувь нь эрүүл мэндийн хувьд урьдынхаас дордсон гэсэн хамгийн нийтлэг хүндрэл болж байна.

Харин тэдний ажил эрхлэлтийн цаашдын хандлагын талаар тодруулахад 64.6 хувь нь цаашид бичил уурхайд ажилласаар байх болно гэсэн бол 19.6 хувь нь цаашид ажиллахгүй гэжээ. Харин 14.5 хувь нь цаашид хэрхэхээ одоогоо хэлж мэдэхгүй байна гэсэн юм.

Зарим хэсэг нь цаашид ажиллахаа болилоо ч, өөр нэг хэсэг нь шинээр ажиллаж эхэлдэг энэ үйл явц байнга явагддаг нь судалгааны явцад ажиглагдаж байлаа.

Хүснэгт 2-10 Ажил эрхлэлтийн цаашдын хандлага

Төлөв	Тоо	Хувь
Цаашид ажилласаар байх болно	250	64.6
Цаашид ажиллахгүй	76	19.6

Мэдэхгүй	56	14.5
Хариулахыг хүсээгүй	5	1.3
Нийт	387	100.0

2.1.6 Өрхийн эдийн засаг

Эрүүл мэнд, гэр бүлээ ч умартан хүнд хэцүү нөхцөлд ажиллаж байгаа тэдний гол зорилго амьжиргаагаа залгуулах мөнгө олох. Харин тэдний хувьд орлого нь тун тогтворгүй бөгөөд зарим сард огт орлогогүй байхад зарим сард хэдэн сая төгрөг олох тохиолдол ч байна. Мөн тэд мөнгө олохын тулд багаж хэрэгсэл, унаа тэрэг гэх зэрэг зардал ч багагүй гаргадаг.

Өрхийн орлогыг дунджаар тодруулахад, 85 орчим хувь нь сард 1 сая төгрөг хүртэл хэмжээний орлоготой байна. **Нэг өрхийн сарын дундаж орлого 747800 төгрөг** байна.

Хүснэгт 2-11 Өрхийн сарын орлого

Орлогын түвшин	Тоо	Хувь
200,000 хүртэл төг	37	9.6
200,001-350,000 төг	60	15.5
350,001-500,000 төг	97	25.1
500,001-750,000 төг	63	16.3
750,001-1,000,000 төг	74	19.1
1,000,001-2,000,000 төг	40	10.3
2,000,001-ээс дээш төг	16	4.1
Нийт	387	100.0

Харин бичил уурхайгаас олсон орлогыг хасахад өрхийн дундаж орлого 281000 төгрөг болж 466800 төгрөгөөр буурч байгаа юм. Эндээс харахад нэг өрх бичил уурхайгаас сард дунджаар 466800 төгрөг олж байна.

Хүснэгт 2-12 Бичил уурхайн орлого хасаж тооцсон өрхийн орлого

Орлогын түвшин	Тоо	Хувь
50,000 хүртэл төг	124	32.0
50,001-100,000 төг	56	14.5
100,001-200,000 төг	49	12.7
200,000-350,000 төг	47	12.1
350,001-500,000 төг	64	16.5
500,001-1,000,000 төг	33	8.5
1,000,000-аас дээш	14	3.6
Нийт	387	100.0

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн өрхийн орлого ямар эх үүсвэрүүдээс бүрдэж буйг тодруулж үзлээ. Уул уурхайн орлого бүх өрхийн хувьд голлох эх үүсвэр болж байгаа бөгөөд дараагийн амьжиргааны гол эх үүсвэр нь тэтгэвэр, тэтгэмж болж байна. Харин нийт өрхийн 19.4 хувьд бусад байгууллагад ажиллаж олсон цалин хөлс бүртгэгдэж байгаа нь албан ажил эрхлэлтийн хувь маш бага байгааг харуулж байна.

График 2-8 Өрхийн орлогын эх үүсвэрүүд



Бичил уурхайчдын гэр бүлийн орлогын гол эх үүсвэр бичил уурхайн орлого. Бусад эх үүсвэрүүдээс тун бага орлого олдог. Харин хүрэлцээний хувьд 23.6 хувь уг орлогоор өдөр тутмын хоол хүнсэнд ч хүрэлцдэггүй, 33.1 хувь нь хоол хүнсээ авчихдаг, түүнээс илүү гардаггүй гэжээ. Харин үлдсэн 43.3 хувь нь өрхийн орлогоо харьцангуй хүрэлцээтэй гэж үнэлсэн байна.

Хүснэгт 2-13 Өрхийн орлогын хүрэлцээ

Хүрэлцээ	Тоо	Хувь
Өдөр тутмын ойр зуурын (Хоол унд гэх мэт) хэрэгцээнд ч хүрэлцдэггүй	92	23.8
Өдөр тутмын хоол хүнсний хэрэгцээнд хүрэлцдэг, илүү гардаггүй (Хувцас хунар авч чаддаггүй)	128	33.1
Дээрхээс гадна зайлшгүй шаардлагатай (хувцас хунар гэх мэт) зүйлсээ авч чаддаг	122	31.5
Тэдгээрээс гадна (үнэт зүйл, тавилга, тоног төхөөрөмж гэх мэт) зүйлийг ч авчихдаг	25	6.5
Хүссэн зүйлээ авч чаддаг	19	4.9
Хариулаагүй	1	.3
Нийт	387	100.0


Өрхийн орлогын хувьд нэг өрхийн сарын дундаж орлого 747800 төгрөг, судалгаанд хамрагдсан өрхүүдийн нэг өрхийн дундаж ам бүл 4.9 хүн.

$$152612 \text{ төг} = \frac{747800 \text{ төг}}{4.9 \text{ хүн}}$$

Эндээс тухайн өрхүүдийн амьжиргааны нөхцөл байдлыг үнэлж үзвэл, нэг хүнд ногдох өрхийн орлого 152,612 төгрөг байна. 2013 оны 4 сард батлагдсан амьжиргааны баталгаажих доод түвшин бүс нутаг тус бүрээр өөр өөр байдаг бөгөөд хамгийн өндөр нь Улаанбаатарт 149,900 төгрөг байгаагаас дээгүүр орлоготой байна. Энэ нь тэднийг өдөр тутамд шаардлагатай хүнсний хэрэглээгээ ядаж хангаж чаддаг болохыг харуулж байна.

Гэвч нийт өрхийн 42.1 хувь нь их бага хэмжээгээр зээлтэй байгаа бол 37.5 хувь нь хадгаламжтай гэжээ. Үлдсэн 20.4 хувь нь өдөр тутмын орлогоороо зарлагаа нөхөж ямар нэгэн өр зээлгүй амьдарч чадаж байна.

График 2-9 Өрхийн хадгаламж, зээлийн харьцаа



Өнгөрсөн 3 сарын хугацаанд нийт судалгаанд хамрагдсан өрхийн 40.1 хувь буюу 155 өрх нь гэр бүлийн хүрээнд болон гэр бүлийн гишүүдээс хэн нэгэн их бага хэмжээгээр бусдаас мөнгө зээлсэн байна. Эдгээр 155 өрхийн 45.2 хувь нь хоол хүнс худалдаж авах зорилгоор мөнгө зээлсэн нь эдгээр өрхийн хувьд хоол хүнсээр тасрах магадлал өндөр байгааг харуулж байна. Үүнд бичил уурхайчдын орлого тогтвортой биш байгаа нь ихээхэн нөлөө үзүүлдэг байна.


Харин 34.8 хувь нь хүүхдийн хичээлийн хэрэгсэл, сургалтын төлбөр төлөх зорилгоор зээлсэн гэжээ. Энэ төрлийн зардал ихээхэн хэмжээтэй байдаг учир тодорхой хэмжээгээр мөнгө зээлэх шаардлага тулгардаг байна. 9.0 хувь өөр нэг зээл төлөхийн тулд, ахин нэг газраас мөнгө зээлж байгаа нь эдгээр өрхийн хувьд амьжиргааны тогтвортой байдал тун эмзэг байгаа нь харагдаж байна.

График 2-10 Мөнгө зээлсэн шалтгаан



Өрхийн гишүүдийн хүнсний наад захын хэрэгцээг хангаж чадахаар хоол хүнсгүй болсон тохиолдол сүүлийн 12 сарын хугацаанд нийт өрхийн 24.3 хувьд тохиолджээ. Ийм тохиолдол 11, 12, 1 саруудад буюу өвөл, 2, 3, 4-р саруудад буюу хаврын улиралд хамгийн их байна. Хаврын улиралд дунджаар 34.8 хувь нь ийм нөхцөлд орсон нь бусад улирлаас харьцангуй өндөр байна.

График 2-11 Хоол хүнсний тасалдалт




Сүүлийн 6 сарын хугацаанд 50 өрх ямар нэгэн эд хөрөнгө зарсан бөгөөд ихэвчлэн машин тээврийн хэрэгсэл, мал зарсан байна. Үүн дотор 8 өрх гэр орноо зарсны 2 нь өдөр тутмын хэрэгцээний ч мөнгөгүй болсон учир, 3 нь өрөө дарахын тулд, 3 нь эм, эмнэлгийн төлбөрт зориулж гэр орноо зарахад хүрсэн нь зарим өрхийн хувьд амьдарлын баталгаа муутай, эмзэг нөхцөлд амьдарч байгааг илтгэж байна.

Хүснэгт 2-14 Эд хөрөнгөө зарах болсон шалтгаан

Зарсан эд хөрөнгө	Зарах болсон шалтгаан								Нийт	
	Хэрэгцээг үй болсон учир	Сайжруулж, шинийг худалдаж авахын тулд	Өдөр тутмын хэрэгцээний мөнгө болгох гэж	Өрхийн хоол хүнсний хэрэглээний мөнгө болгох гэж	Эм, эмнэлгийн төлбөр төлөхийн тулд	Өрөө төлөхийн тулд	Боловсролын төлбөрт зориулж	Бусад	Тоо	Хувь
Мал, амьтан	0	2	7	2	0	1	8	1	15	28.3%
Тээврийн хэрэгсэл	2	11	1	1	0	3	4	6	24	45.3%
Гэр орон	0	0	2	1	3	3	1	1	8	15.1%
Бусад хөрөнгө	1	0	1	1	1	4	1	1	6	11.3%
Тоо	3	13	11	5	4	10	13	8	50	100.0%
Хувь	6.0%	26.0%	22.0%	10.0%	8.0%	20.0%	26.0%	16.0%		134.0%

Сүүлийн 12 сарын хугацаанд ямар ч өрхийн орлогогүй болсон тохиолдол нийт судалгаанд хамрагдсан өрхийн 35,4 хувьд тохиолджээ.

График 2-12 Өрхийн орлогогүй болсон тохиолдол байгаа эсэх



2.1.7 Бичил уурхайчдын хүүхдийн нийгмийн асуудал

≡ Хүүхдийн тухай мэдээлэл


Судалгааны үндсэн зорилго хүүхдийн асуудал учир бид хүүхдийн асуудлыг илүү онцолсон бөгөөд илүү энэ хэсэгт судалгаанд хамрагдсан өрхүүдийн хүүхдүүдийн ерөнхий мэдээллийг илүү дэлгэрэнгүй авч үзлээ.

Нийт судалгаанд хамрагдсан 387 өрх 1052 хүүхэдтэй байгаа бөгөөд эдгээр 1052 хүүхдийн 856 (423 эрэгтэй, 433 эмэгтэй) нь 17 түүнээс доош нас хүүхэд байгаа юм. Эдгээр 856 хүүхдээр дамжуулж, Монголын бичил уурхайчдын хүүхдүүдийн ерөнхий дүр зургийг харахыг оролдсон юм.

Судалгаанд оролцогчдоос хэдэн хүүхэдтэйг асууж тодруулахад 1-7 хүүхэдтэй өрхүүд энэхүү судалгаанд хамрагджээ. Дундаж хүүхдийн тоо 2.7 байна.

Нийт судалгаанд хамрагдагсдын 25 хувь нь одоо хүүхдүүдтэйгээ хамт уурхайн орчинд амьдарч байгаа, 75 хувь нь хүүхдүүдээ хаа нэгтээ орхиод бичил уурхайд ажиллаж байна.

График 2-13 Хүүхэдтэйгээ хамт болон тусдаа амьдарч буй харьцаа



Нийт судалгаанд хамрагдсан 387 өрхөөс 97 өрхийн 179 хүүхэд уурхайн орчинд амьдарч байгаа бөгөөд эдгээр 179 хүүхдийн 73 нь СӨБ-ийн насны, 106 нь ЕБС-ийн насны хүүхэд байна. Зарим өрхийн хувьд 1-5 хүртэл хүүхэдтэйгээ уурхайн орчинд амьдарч байна.

Эцэг эхийн хэн нэгэн бичил уурхайд ажилласнаас хамт амьдарч чадахгүй байгаа 290 өрхийн 644 хүүхэд байна. Эдгээр 644 хүүхэд эцэг, эхийн аль нэгээс эсвэл хоёулангаас нь 3 болон түүнээс дээш сарын хугацаатайгаар хол амьдарч байгаа.

Хүснэгт 2-15 Хүүхдийн тоо

Хамт амьдардаг эсэх	Нас	Өрхийн тоо	Хүүхдийн тоо
Хамт амьдардаггүй	СӨБ-ийн насны хүүхэдтэй	136	176
	ЕБС-ийн насны хүүхэдтэй	247	468
	Нийт		644
Хамт амьдардаг	СӨБ-ийн насны хүүхэдтэй	63	73
	ЕБС-ийн насны хүүхэдтэй	61	106
	Нийт		179

≡ Уурхай орчимд эцэг эхтэйгээ хамт амьдардаг хүүхдүүд

Эцэг эхийн анхаарал халамж

Хүүхдүүд уурхайн орчинд амьдрах нь хүүхдүүдийн хувьд төдийлөн таатай орчин биш ч өрхүүд амьжиргааны нөхцөлдөө захирагдаж хүүхдүүдтэйгээ амьдарсаар байна.

Хүүхэдтэйгээ хамт амьдарч байгаа 97 өрхөөс ямар шалтгааны улмаас хүүхдүүдтэйгээ уурхайн орчинд амьдрах болсныг тодруулахад, өөртэйгээ хамт байлгаж харах гэж, үндсэн гэрт нь харах хүнгүй, зуны амралтаар өөртэйгээ хамт байлгаж байгаа гэсэн байна. Харин бусад өрхүүдийн хувьд угаасаа үндсэн гэр нь уурхайн орчинд байдаг учир хүүхдүүдтэйгээ хамт амьдардаг гэжээ.

График 2-14 Хүүхдээ уурхайн орчинд амьдруулж байгаа шалтгаан



Бичил уурхай бий болоод нэлээд олон жилийн нүүр үзэж байгаа учир бичил уурхайн ойролцоох жижиг баг, тосгоны оршин суугчид тэр чигээрээ бичил уурхайчин болсон тохиолдол байна. Жишээ нь: Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн иргэд, Хэнтий аймгийн Бэрх тосгон.

Уурхайн орчинд амьдарч байгаа гэр бүлүүдийн хувьд дан ам бүлээрээ амьдрах тохиолдол тун бага. Хаа нэгтгээгээс ирсэн хамаатан, нутгийн хүнээ гэртээ байлгах, эсвэл дундаа гэр барьж амьдрах тохиолдол их байна. Тиймээс 10 хүртэл тооны хүн хамтаар амьдарч байна.


Уурхайн орчинд хүүхэдтэйгээ амьдарч байгаа 97 өрхийн хувьд л авч үзэхэд 30 өрхөд гаднаас өөр хэн нэгэн хүн амьдардаг бөгөөд хамгийн олон гадны хүн байгаа өрхөд 8 гадны хүн амьдарч байна.

Судлаачийн хувиар уурхайн орчинд хийсэн ажиглалтаар бичил уурхайчид маш олон цагаар ажилладаг бөгөөд ажилд гараагүй үедээ цагийг өнгөрөөх ямар ч орчин нөхцөл байхгүй учир бие биеэ уруу татаж архидах нь хэвийн үзэгдэл болсон байна.

Эрчүүд голдуу, архидалт ихтэй энэ орчин хамт амьдарч буй хүүхдүүдийн хувьд амьдралын таатай орчин нөхцөл, зөв үлгэр дууриалал гэж ярихын өмнө тэдний эрхийн асуудал ихээр хөндөгдөж байгааг хэлэх хэрэгтэй.

Уурхайн орчинд амьдарч буй эцэг эхчүүдээс хүүхдүүдтэй хэр анхаарал тавьж чаддаг вэ гэж асуухад 46.4 хувь нь хангалттай анхаарал тавьж чаддаг гэсэн бол, 29.9 хувь нь дунд зэрэг, 23.7 хувь нь хангалтгүй гэж хариулсан байна. Үүнээс харахад олон цагаар ажилладаг ажилладаг эцэг эхчүүдийн хувьд хүүхдүүддээ тавих анхаарал халамж хангалттай биш байна.

График 2-15 Хүүхэддээ тавих анхаарал халамж



Мөн эцэг эхчүүдийн зүгээс уурхайн орчинд хүүхдүүдтэйгээ хамт амьдрах төдийлөн хүсэлгүй байдаг бөгөөд сул шороо, нүх сүв ихтэй энэ орчинд хүүхдүүд амьдрахад гэмтэж бэртэх, өвчин эмгэг тусахдаа амархан байдаг учир энэ орчинд амьдрахад төдийлөн тохиромжгүй гэж судалгаанд оролцогчдын 66.0 хувь нь хариулсан юм.

Хүснэгт 2-16 Орчны хүүхдэд тохиромжтой эсэх байдал

	Тоо	Хувь
Тохиромжтой	28	28.9

Тохиромжгүй	64	66.0
Мэдэхгүй	5	5.2
Нийт	97	100.0

Амьжиргааны нөхцөл байдал хүнд, олон цагаар ажилладаг, хязгаарлагдмал орчинд амьдарч байгаатай холбоотойгоор хүүхдүүдийн эрх олон талаар зөрчигдөж байгаагийн нэг томоохон илрэл нь уурхайн орчинд хүүхдүүдтэйгээ хамт амьдардаг 97 өрхийн хувьд 9 хүүхэд төрсний гэрчилгээ эсвэл иргэний үнэмлэхгүй байна.

Уурхайн орчинд хүүхэд амьдрахад тохиромжгүй гэж эцэг, эхчүүдийн дийлэнх нь үзэж байгаа ч өөр аргагүйн улмаас амьдарсаар л байгаа. Харин энд амьдарснаас үүдэлтэйгээр хүүхдүүдэд ямар хүндрэлтэй асуудал тулгарч буйг тодруулахад 7 хүүхэд уурхайн орчинд осол гэмтэлд өртөж байсан, 20 хүүхэд өвчин эмгэг тусч байсан, 1 хүүхэд хэрэг зөрчилд холбогдож байсан, 1 хүүхэд гэмт хэргийн хохирогч болж байсан байна. Өвчин эмгэг тусч байсан хүүхдүүдийн хувьд амьсгалын замын өвчлөл, чих хамар, хоолойн өвчин тусах нь элбэг байдаг бөгөөд энэ нь нэг талаар манай орны уур амьсгалд нийтлэг өвчин боловч нөгөө талаар сул шороо ихтэй, гадаа хөдөө амьдарч байгаа нь нөлөөлдөг гэж эцэг эхчүүд хэлж байлаа. Харин өвдсөн үедээ эрүүл мэндийн байгууллагад хандах нь бага байдаг бөгөөд орчин тойрны хүмүүс, эмийн санч гэх зэрэг хүмүүсээс зөвлөгөө авах, эсвэл өөрсдөө туршлага дээрээ үндэслэж эмчилдэг байна.

<i>Ямар нэгэн осол гэмтэлд өртөж байсан</i>	<i>7</i>
<i>Ямар нэгэн өвчин тусч байсан</i>	<i>20</i>
<i>Хэрэг зөрчилд холбогдсон</i>	<i>1</i>
<i>Гэмт хэргийн хохирогч болсон тохиолдол</i>	<i>1</i>

Уурхайн орчинд хүүхэд амьдрахад тохиромжгүй төдийгүй аюултай гэж эцэг эхчүүд үзэж байгаа бөгөөд хамгийн гол асуудал нь орчин нөхцөлийн бохирдол, сул шороо ихтэй, архи мансууруулах бодисын хэрэглээ ихтэй байгаа нь хүүхдүүдэд хамгийн муу нөлөө үзүүлж байгаа гэж үзсэн бол үүнтэй уялдан гэмт хэргийн хохирогч болох, бусдад уруу татагдах асуудал их гардаг учир уурхайн орчинд амьдрахад хүндрэлтэй байдаг гэсэн байна.

Мөн уурхайн орчинд амьдарч буй хүмүүсийн дийлэнх нь эрчүүд голдуу байдаг учир хүүхдүүд бэлгийн хүчирхийлэлд өртөх асуудал ч байдаг аж. Судалгаанд оролцогчдоос ийм тохиолдол байсан эсэхийг тодруулахад 6 ч удаа ийм тохиолдол гарч байжээ.

Хүснэгт 2-17 Орчноос үүдэлтэй хүндрэл

Эрсдэл	Хариулт	
	Тоо	Хувь
Орчин нөхцөлийн бохирдол	26	70.3%
Архи, мансууруулах бодисын хэрэглээ их	24	64.9%
Зам, тээврийн осол	18	48.6%
Гэмт хэрэг (хулгай, дээрэм гэх мэт)-ийн хохирогч болох	4	10.8%

Бусдад уруу татагдах	3	8.1%
Бэлгийн хүчирхийлэл	2	5.4%
Бусад	3	8.1%

Уурхайн орчинд амьдарч байгаа хүүхдүүдэд нэн тэргүүнд хийх шаардлагатай дэмжлэг юу байгааг тодруулахад, судалгаанд оролцогчдын 70.1 хувь нь тоглоомын талбай гэсэн бол 51.5 хувь нь цэцэрлэг, 21.6 хувь нь өдөр өнжүүлэх төв шаардлагатай байна. Ингэснээр ар гэр, хүүхдүүддээ санаа зовохгүй ажлаа хийх боломжтой болно. Нөгөөтэйгүүр хүүхдүүд аюулгүй орчинд өсч хүмүүжих боломжтой болно гэсэн байна.


Хүснэгт 2-18 Хүүхдүүдэд зориулж хийхийг хүссэн зүйлс

Хийх зүйл	Хариулт	
	Тоо	Хувь
Тоглоомын талбай	68	70.1%
Цэцэрлэг	50	51.5%
Өдөр өнжүүлэх төв	21	21.6%
Эрүүл мэндийн төв	17	17.5%
Албан бус сургууль	7	7.2%
Сургууль, цэцэрлэгт зөөх автобус	7	7.2%
Бусад	21	21.6%
Нийт	191	196.9%

Хүүхдийн боловсролын асуудал

Уурхайн орчинд амьдарч буй СӨБ-ийн насны хүүхдүүдийн 36.5 хувь нь өдөр өнжүүлэх, цэцэрлэгт явж байгаа бөгөөд ихэнх нь сум, аймгийн цэцэрлэгт явдаг байна. Үлдсэн цөөн хүүхдийг өөрсдөө зохион байгуулалттайгаар гэр цэцэрлэг байгуулж харуулдаг байна. Энэ зөвхөн Төв аймгийн Заамар суманд ийм зохион байгуулалтанд орсон байлаа.

График 2-16 СӨБ-ийн насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт



Цэцэрлэгт хамрагддаггүй хүүхдүүдийн эцэг, эхээс ямар шалтгаанаар хүүхдээ цэцэрлэгт өгдөггүй талаар тодруулахад, 55.0 хувь нь цэцэрлэг байхгүй, цэцэрлэг байлаа ч орон тоо байхгүйн улмаас цэцэрлэгт өгч чаддаггүй гэсэн юм. Энэ тухайн орчинд цэцэрлэгийн хүрэлцээ хомс байгааг илэрхийлж байгаа бөгөөд эцэг эхчүүдийн хувьд хүүхдээ цэцэрлэгт өгөх сонирхол маш ихтэй байгаа нь судалгааны явцад харагдаж байлаа.

График 2-17 Цэцэрлэгт хамрагддаггүй шалтгаан



Уурхайн орчинд нийт 61 ЕБС-ийн насны хүүхэд байгаагийн 59 нь сургуульд сурдаг, 2 хүүхэд сургууль завсардсан байна. Сургуульд сурдаг хүүхдүүдийн хувьд сургуульдаа алхаж явдаг бөгөөд зарим зарим тохиолдолд эцэг эхчүүд ээлжээр машин, мотоциклиор хүргэж өгдөг байна.

Хүснэгт 2-19 Хичээлдээ хэрхэн явдаг

Арга хэлбэр	Хариулт	
	Тоо	Хувь
Машинаар	14	21.5%
Мотоциклиар	2	3.1%
Алхаж явдаг	35	53.8%
Чөлөө авсан байгаа	1	1.5%
Бусад	13	20.0%
Нийт	65	100.0%

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт

Уурхайн орчинд амьдарч буй хүүхдүүдийн хувьд уурхайн оролцохгүй байх боломж бараг үгүй бөгөөд ялангуяа нас нь томрох тусам гэр бүлийнхэндээ туслах нь элбэг байдаг ажээ. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 38 хувь нь хүүхдээ уурхайн ажилд туслуулдаг гэжээ. Эцэг эхчүүдийн хувьд хүүхдээ ажилдаа туслуулах дургүй,

аюултай гэдгийг маш сайн мэддэг ч зуны цагт ялангуяа туслуулах тохиолдол их байдаг гэсэн юм.

График 2-18 Хүүхдүүд уурхайн ажилд оролцох байдал



Уурхайн ажилд туслахдаа ихэвчлэн ямар ажил хийдэг болохыг тодруулахад, угаахад зориулж бэлдсэн чулуу, шороо савлах зөөх, ус зөөх, нүх ухах, алт угаах зэрэг бүхий л үе шатанд оролцдог байна.

Хүснэгт 2-20 Уурхайн ажилд хүүхдийн үүрэг оролцоо

Хийдэг ажил	Хариулт	
	Тоо	Хувь
Чулуу, шороо савлах, зөөх	15	68.2%
Ус зөөх	11	50.0%
Нүх ухах	8	36.4%
Алт угаах	7	31.8%
Чулуу бутлах	2	9.1%
Бусад	5	22.7%
Нийт	48	218.2%


Уурхайгаас гадна өөр хөдөлмөр эрхэлдэг эсэхийг асуухад 3 хүүхэд бичил уурхайчдад идэж, уух юм зардаг гэсэн юм.

≡ Эцэг эхээсээ тусдаа амьдарч буй хүүхдүүд

Эцэг эхийн хэн нэгэн бичил уурхайд ажилласнаас хамт амьдарч чадахгүй байгаа 290 өрхийн 644 хүүхэд байна. Эдгээр 644 хүүхэд эцэг, эхийн аль нэгээс эсвэл хоёулангаас нь 3 болон түүнээс дээш сарын хугацаатайгаар хол амьдарч байна.

Эдгээр хүүхдүүд 70 хувь нь өөрийнхөө гэртээ, үлдсэн 30 хувь нь эмээ, өвөөгийнхөө, танил айлдаа, хамаатны айлдаа гэх зэрэг өөр айлд амьдарч байна. Эцэг, эхээсээ хол амьдарч буй хүүхдүүдийн 92.8 хувь нь ааваасаа, 45.5 хувь нь ээжээсээ, 4.1 хувь нь хоёулангаас нь хол амьдарч байгаа юм.

График 2-19 Амьдардаг газар



Нийт судалгаанд оролцсон эцэг эхийн 116 нь буюу 40 хувь нь 3 сар хүртэл хугацаагаар, 29.0 хувь нь 3-6 сарын хугацаагаар, 17.9 хувь нь 6-9 сарын хугацаагаар сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхдүүдээсээ хол байсан гэсэн бол 13.1 хувь нь буюу 38 эцэг эх жилийн туршид хүүхдүүдтэйгээ хамт байж чаддаггүй гэжээ.


Хүснэгт 2-21 Сүүлийн нэг жилийн хугацаанд тусдаа байсан хугацаа

Хугацаа	Тоо	Хувь
3 сар хүртэл	116	40.0%
3-6 сар хүртэл	84	29.0%
6-9 сар хүртэл	52	17.9%
9-12 сар хүртэл	38	13.1%
Нийт	290	100.0%

Хүүхдийн боловсролын асуудал

Эцэг, эхээсээ хол амьдарч байгаа 644 хүүхдийн 176 нь СӨБ-ийн насны хүүхэд байгаа бөгөөд цэцэрлэгт хамрагдалтын хувь уурхайн орчинд амьдарч байгаагаас харьцангуй өндөр буюу 59.0 хувь байна.

График 2-20 СӨБ-ийн насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт



Харин цэцэрлэгт хамрагддаггүй гэх хүүхдүүдийн хувьд ихэвчлэн цэцэрлэгт орон тоо байхгүй, гэртээ харах хүнтэй учир явуулах шаардлагагүй гэжээ. Цөөн хүүхдүүдийн хувьд цэцэрлэгээс хол амьдардаг учир зөөхөд хүндрэлтэй, зөөх хүн байхгүй, бичиг баримтын асуудалтай гэх зэрэг шалтгааны улмаас цэцэрлэгт явж чадахгүй байна.

Хүснэгт 2-22 Цэцэрлэгт хамрагддаггүй шалтгаанууд

Шалтгаанууд	Хариулт	
	Тоо	Хувь
Цэцэрлэгт орон тоо байхгүй	25	44.6%
Гэртээ харах хүнтэй	20	35.7%
Цэцэрлэгээс хол амьдардаг	7	12.5%
Зөөх, хүргэж өгөх хүн байхгүй	3	5.4%
Бичиг баримтын асуудалтатй/сумандаа бүртгэлгүй гэх мэт	3	5.4%
Хоолны, хичээлийн хэрэгсэл зэрэг шаардсан зүйлсийг төлж чадахгүй	2	3.6%
Бие муутай	1	1.8%
Цэцэрлэгт явах дургүй	1	1.8%
Бусад	11	19.6%
Нийт	73	130.4%

Харин ЕБС-ийн насны хүүхдийн хувьд авч үзвэл, эцэг эхээсээ хол амьдарч буй 247 өрхийн 468 ЕБС-ийн насны хүүхэд байгаагаас 3 хүүхэд сургууль завсардсан байсан. Тэдний 1 нь багш нартай таарамжгүй харилцаатайн улмаас, 2 нь өвчний улмаас сургуульд явдаггүй гэсэн юм.

≡ ЕБС-ийн дараахь насны хүүхэд

Судалгаанд 8-17 насны хүүхдүүдтэй эцэг эхчүүдийг хамруулсан бөгөөд тэдний 60 нь ЕБС-иа төгссөн хүүхэдтэй. Тэдгээр 60 хүүхдийн 43 нь оюутан болж үргэлжлүүлэн суралцаж байгаа бол 5 хүүхдийг сургалтын төлбөргүйн улмаас, 5 хүүхдийг амьжиргаандаа хэрэг болгож ажил хийлгэхийн тулд оюутан болгож чадаагүй байна. Харин үлдсэн хүүхдүүдийн хувьд өөрөө хүсээгүй, цэрэгт явсан гэх зэрэг шалтгаанаар үргэлжлүүлэн суралцаагүй байна.

2.2 УУРХАЙН ОРЧИНД АМЬДАРДАГ ХҮҮХДИЙН АСУУЛГЫН ҮР ДҮН

2.2.1 Ерөнхий мэдээлэл

Судалгаанд уурхайн орчинд амьдардаг 111 хүүхэд хамрагдсан. Судалгааны аргазүйн хүрээнд хийгдсэн түүвэрлэлтийн дагуу уурхайн орчинд амьдардаг 193 хүүхэд хамруулах байсан боловч цаг агаар хүйтэрсэнтэй холбоотойгоор уурхайн орчинд амьдарч байгаа хүүхэд цөөхөн байсан учир төлөвлөсөн тооноос цөөн хүүхэд судалгаанд хамрагдсан.

Хүснэгт 2-23 Судалгаанд оролцогч хүүхдүүдийн хамрагдалт, аймгаар

Аймаг	Тоо	Хувь
Завхан	5	4.5
Ховд	24	21.6
Увс	20	18.0
Говь-Алтай	2	1.8
Баянхонгор	17	15.3
Дархан	1	.9
Сэлэнгэ	2	1.8
Төв	31	27.9
Хэнтий	9	8.1
Нийт	111	100.0

Судалгаанд оролцсон 111 хүүхдийн 16 нь өөр аймаг, сумнаас шилжиж ирсэн буюу түр оршин сууж байгаа. Эдгээр 16 хүүхдийн 13 нь эцэг, эх нь уурхайд ажиллахтай холбоотойгоор нүүж ирсэн байна. Нүүж ирсэн 13 хүүхдийн 8 нь одоо амьдарч буй орон нутагтаа бүртгэлгүй байгаа юм.

Хүснэгт 2-24 Нүүж ирсэн шалтгаан

Шалтгаан	Тоо	Хувь
Уурхай бараадаж ирсэн	13	81.3
Бусад шалтгаан	3	18.8
Нийт	16	100.0

Судалгаанд 8-17 насны хүүхэд хамрагдсан бөгөөд 8-11 насны 24 хүүхэд, 12-15 насны 56 хүүхэд, 16-17 насны 31 хүүхэд хамрагдсан байна. Тэдний 65 нь буюу 58.6 хувь нь эрэгтэй, 46 нь буюу 41.4 хувь нь эмэгтэй.

Хүснэгт 2-25 Судалгаанд оролцогч хүүхдүүдийн насны бүлэг

Нас	Тоо	Хувь
8-11 настай	24	21.6
12-15 настай	56	50.5

16-17 настай	31	27.9
Нийт	111	100.0

Судалгаанд оролцогч хүүхдүүдийн гэр бүлээс хэдэн хүн хагас болон бүтэн цагийн ажил хийдгийг сонирхоход 80 орчим хувьд 1-2 хүн ажил хийдэг байна. Нийт 111 өрхийн хувьд, ажил хийдэг хүний дунд бичил уурхайд ажилладаг хүний тоо 87.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2-26 Бичил уурхайд ажилладаг хүний тоо

Хүний тоо	Тоо	Хувь
1 хүн	63	56.8
2 хүн	27	24.3
3 хүн	18	16.2
4 хүн	2	1.8
7 хүн	1	.9
Нийт	111	100.0

2.2.2 Боловсрол

Судалгаанд оролцогчдын 104 нь одоо сургуульд сурч байгаа, 5 нь сургуулиа төгссөн, 2 нь сургуульд завсардсан. Сургууль завсардсан 2 хүүхдийн хувьд сургуульд хэрэглэгдэх хичээлийн хэрэгсэл, хувцас дутагдалтай гэх зэрэг өрхийн эдийн засгаас үүдэлтэй шалтгаанаар сургуулиас завсарджээ. 1 нь уншиж бичиж чадахгүй, 1 нь чаддаг байна.

Хүснэгт 2-27 Сургуульд хамрагдалт

Сургуульд хамрагдалт	Тоо	Хувь
Сургуульд сурч байгаа	104	93.7
Сургууль завсардсан	2	1.8
Сургууль төгссөн	5	4.5
Нийт	111	100.0

Уурхайн орчинд амьдарч буй хүүхдүүд ихэнх нь суурин газартай ойролцоо уурхайн ойролцоо амьдарч байгаа ч сургуульдаа алхаж явахад тийм ч ойр биш. Тиймээс эцэг эх нь ээлжээр хүүхдүүдээ сургуульд нь хүргэх зэргээр зохион байгуулалтанд ордог. Гэвч зарим гэр бүлүүдийн хувьд тийм боломжгүй учир хүүхдүүд хол хэдий ч алхаж явдаг.

Хүснэгт 2-28 Хичээлдээ хэрхэн явдаг

Арга хэлбэр	Хариулт	
	Тоо	Хувь
Машинаар	17	16.3%
Мотоциклиар	7	6.7%

Алхаж явдаг	84	80.8%
Чөлөө авсан байгаа	1	1.0%
Бусад	1	1.0%
Нийт	110	105.8%

Уурхайн орчинд буюу суурин газраас зайдуу амьдарч буй хүүхдүүдийн хувьд уурхайн орчинд амьдарч байгаагаас үүдэлтэйгээр хичээлээ таслах, чөлөө авах тохиолдол байсан эсэхийг тодруулахад, 70 орчим хувь нь тийм тохиолдол байгаагүй гэж хариулсан бол үлдсэн 30 орчим хувьд нь байнга эсвэл хааяа энэ асуудал тохиолддог гэжээ.

Хүснэгт 2-29 Хичээлээ таслах, чөлөө авах тохиолдлын давтамж


	Тоо	Хувь
Тийм тохиолдол байхгүй	72	69.2
Хааяа	29	27.9
Байнга	3	2.9
Нийт	104	100.0

Сургуулиа төгссөн 5 хүүхдийн хувьд одоо бичил уурхайд ажиллаж байгаа бөгөөд 4 нь ажил хийж, гэр бүлдээ дэмжлэг үзүүлэх үүднээс оюутан болоогүй гэжээ.

2.2.3 Хөдөлмөр эрхлэлт

Уурхайн орчинд амьдарч байгаа хүүхдүүдийн хувьд аав, ээждээ дэмжлэг болох, гэр орны ажилд туслах нь мэдээж. Харин гэр бүлийн бизнес болон уурхайн ажилд оролцох байдлаар хүүхэд хөдөлмөр эрхэлж буй тохиолдол хэр их байгааг тодруулахад, 25 хүүхэд гэр бүлийн бизнест байнга тусалдаг, 47 хүүхэд хааяа тусалдаг, нийт 72 хүүхэд хөдөлмөр эрхэлдэг гэж хариулжээ. Энэ нь хүүхэд эцэг, эхтэйгээ хамт амьдрах шаардлагатай хэдий ч уурхайн орчинд амьдарснаар хөдөлмөр эрхлэх нөхцөл илүү бүрдэж байгааг харуулж байна.

График 2-21 Хүүхдийн өрхийн бизнест оролцох байдал



Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийг насны хувьд харвал, 12 нь 8-14 насны, 36 нь 12-15 насны хүүхэд, 24 нь 16-17 насны хүүхэд байна. Хөдөлмөр эрхэлдэг гэх 72 хүүхдийн 51 нь уурхайн ажилд тусалдаг, үлдсэн 21 нь уурхайн орчинд зарах зорилгоор хоол хүнс хийх, зарах, дэлгүүрт юм зарах зэрэг ажил хийдэг байна.

Хүснэгт 2-30 Хүүхдийн өрхийн бизнест оролцох байдал, насны бүлгээр

	Насны бүлэг						Нийт	
	8-11 нас		12-15 нас		16-17 нас			
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Байнга	1	4.2%	14	25.0%	10	32.3%	25	22.5%
Хааяа	11	45.8%	22	39.3%	14	45.2%	47	42.3%
Огт үгүй	12	50.0%	20	35.7%	7	22.6%	39	35.1%
Нийт	24	100.0%	56	100.0%	31	100.0%	111	100.0%

Уурхайн ажилд тусалдаг 51 хүүхдийн 9 нь 8-11 насны, 25 нь 12-15 насны, 17 нь 16-17 насны хүүхэд байна. Тэд ихэвчлэн чулуу, шороо зөөх, алт угаах, ус зөөх, нүх ухах зэрэг ажил хийдэг бөгөөд ажилын хувьд насны ялгаа аль ч төрлийн ажлыг хийж байна.

Хүснэгт 2-31 Хүүхдийн уурхайн ажилд оролцох байдал, насны бүлгээр

Ажлын төрөл	Насны бүлэг						Нийт	
	8-11 нас		12-15 нас		16-17 нас			
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нүх ухах	3	12.0%	10	11.9%	12	18.8%	25	34.7%
Ус зөөх	3	12.0%	14	16.7%	10	15.6%	27	37.5%
Чулуу бутлах	3	12.0%	4	4.8%	7	10.9%	14	19.4%
Алт угаах	3	12.0%	17	20.2%	10	15.6%	30	41.7%
Мөнгөн ус бариулах	2	8.0%	1	1.2%	0	.0%	3	4.2%
Чулуу, шороо зөөх	4	16.0%	22	26.2%	14	21.9%	40	55.6%
Тэсэлгээ хийх	0	.0%	1	4.0%	1	1.6%	2	2.8%
Бусад	5	20.0%	14	16.7%	8	12.5%	27	37.5%
Нийт	25		84		64		173	

Хөдөлмөр эрхэлж буй 72 хүүхдийн 25 нь тусдаа тооцож цалин авдаг, 47 нь цалин авахгүйгээр гэр бүлийнхээ тусалдаг гэжээ. Тогтмол ажил биш учир төдийлөн их орлого олоод байдаггүй ч сард 5,000-500,000 хүртэл төгрөг олдог. 200,000 төг түүнээс дээш орлого олдог 5 хүүхэд байна. Харин олсон мөнгөө ихэвчлэн гэр бүлийнхэндээ өгдөг, өөртөө хэрэгтэй зүйлд зарцуулдаг. 4 хүүхдийн хувьд хуримтлал үүсгэдэг.


Хүснэгт 2-32 Мөнгөний зарцуулалт

Зарцуулалт	Хариулт	
	Тоо	Хувь
Хуримтлуулдаг	4	16.0%
Гэр бүлийнхэндээ өгдөг	18	72.0%
Өөртөө хэрэгтэй бараа бүтээгдэхүүн худалдаж авдаг	15	60.0%
Бусад	1	4.0%
Нийт	38	152.0%

Ажил хийдэг хүүхдүүдийн хувьд тэдний олсон орлого өрхийн эдийн засагт хэр нэмэртэй байдаг талаар тодруулахад, 3 хүүхдийн хувьд өрхийн орлогын гол эх үүсвэр болдог, 6 хүүхдийн хувьд тодорхой хэмжээний нэмэртэй, 15 хүүхдийн хувьд бага хэмжээний нэмэр болдог гэсэн байна.

Зарим хүүхдүүдийн хувьд томчуудтай яг л адилхан хөдөлмөр эрхэлж, яг л адилхан цагаар ажиллаж гэр бүлдээ дэмжлэг болдог бөгөөд олсон орлогоороо гэр бүлээ авч явдаг. Энэ нь ихэвчлэн 16, 17-той хүүхдүүд байсан юм.

График 2-22 Хүүхдийн орлогын өрхийн орлогод үзүүлэх хувь нэмэр



2.2.4 Эрүүл мэнд

Уурхайн орчинд амьдарч буй 25 хүүхэд эрүүл мэндийн хувьд ямар нэгэн байнгын асуудалтай байдаг. Амьсгалын замын өвчин, арьсны өвчин, чих хамар хоолойн өвчин, бөөр шээсний замын өвчин зэрэг өвчин бусад төрлийн өвчнөөс илүү нийтлэг байна.

Хүснэгт 2-33 Өвчлөлийн хэлбэр

Өвчлөлийн хэлбэр	Хариулт	
	Тоо	Хувь
Амьсгалын замын өвчин	11	42.3%
Арьсны өвчин	6	23.1%
Чих, хамар, хоолойн өвчин	6	23.1%
Бөөр, шээсний замын өвчин	5	19.2%
Ядаргаа, сульдаа	4	15.4%
Зүрх судас	3	11.5%
Үе мөч, булчингийн өвчин	1	3.8%
Бусад	7	26.9%

Уурхайн орчинд амьдарснаас үүдэлтэй 8 хүүхэд ямар нэгэн гэмтэл бэртэл авч байсан бөгөөд ухсан нүхэнд унах нь их байна. Уурхайд ажилладаг 2 хүүхэд нүхэнд унаж байсан. Бэртэл хүндхэн байсан учир сумын эмнэлгээс тусламж авчээ.

Судалгаанд хамрагдсан 3 хүүхэд тутмын 1 нь ямар нэгэн өвчин туссан эсвэл бэртсэний улмаас хичээлээ таслах, чөлөө авах тохиолдол гарсан байна.

2.2.5 Хүүхдийн нийгмийн асуудал

Тухайн орчинд амьдарч буй хүүхдүүдийн хувьд газар газраас ирсэн олон хүмүүсийн дунд амьдраад зогсохгүй, нэг гэрт хамт амьдардаг олон хүүхэд бий. Тиймээс тэдгээр хүмүүстэй зохицож амьдрахад олон асуудал байх нь ойлгомжтой. Эцэг эхчүүдийн зүгээс ч хүүхэддээ санаа зовох асуудал их байдаг нь эцэг эхчүүдээс авсан судалгааны үр дүнгээс харагдсан.

Судалгаанд оролцогч хүүхдүүдийн 30 гаруй хувь нь орчны хүмүүсээс ямар нэгэн хүчирхийлэл, дарамтанд өртөж байсан бөгөөд дараахь хүчирхийллийн хэлбэрүүд бүгд л их бага хэмжээгээр тохиолдож байсан байна. Үүнээс хэл амаар доромжлуулах, зодуулах, сүрдүүлэх зэрэг асуудал ихэнхдээ тохиолддог. Харин доорхоос гадна зам тээврийн осол гэмтэл хүүхдүүдэд их тохиолддог нь судалгааны явцад харагдаж байсан юм.

Хүснэгт 2-34 Хүүхдүүдэд тохиолдох эрсдэл

Тохиолдох эрсдэл	Өөрөө		Бусад хүүхэд	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хэл амаар доромжлуулах	25	22.5%	31	27.9%
Сүрдүүлэх	9	8.1 %	21	18.9%
Зодуулах	7	6.3%	30	27.0%
Эд зүйлсээ дээрэмдүүлэх	5	4.5%	13	11.7%
Мөнгө татуулах	4	3.6%	7	6.3%
Бэлгийн дарамтанд өртөх	-	-	3	2.7%
Бусад	-	-	2	1.8%

Хүүхдүүдтэй ярилцахад томчуудаас илүүтэйгээр бусдынхаа, найзуудынхаа асуудлыг мэдэж байсан бөгөөд эцэг, эхдээ ч хэлэхгүй зүйлээ найздаа хэлдэг байна. Тиймээс ч бид судалгааны явцад хүүхдийн хувьд хамгийн эмзэг хүчирхийллийн хэлбэр болох бэлгийн хүчирхийллийн талаар илүү тодотгож, тухайн орчинд амьдардаг охид бэлгийн дарамтанд өртсөн тохиолдол мэдэх эсэх талаар тодруулахад 9 хүүхэд тийм тохиолдол мэднэ гэсэн юм. Эдгээр 9 хүүхдийн 7 нь эмэгтэй хүүхэд байгаа юм.

Судалгаанд оролцогч хүүхдүүдээс тухайн орчинд амьдрахад ямар хүндрэлтэй асуудал байдаг талаар тодруулахад, дуу чимээ, тоос шороо, хог хаягдал орчны бохирдол ихтэй нь хүндрэлтэй байдаг. Мөн ухсан нүх ихтэй байдаг учир унаж бэртэх аюултай, бие засах газар, усанд орох газар, худаг цэвэр ус байхгүй, тог цахилгаан байхгүй зэргээр амьдрах орчин нөхцөл муутай нь хүүхдүүдийн хувьд хүндрэлтэй байдаг байна.

Харин ажил хийдэг хүүхдүүдийн хувьд нүх ухах, шороо зөөх, ус зөөх, алт угаах зэрэг уурхайн ажилд хүнд байдаг гэсэн юм.

Хүснэгт 2-35 Уурхайн орчинд амьдрахад гардаг хүндрэл

Хүндрэл	Тоо
Тоос шороо ихтэй	21
Ажил хүнд	20
Хог хаягдал, орчны бохирдол	19
Дуу чимээ ихтэй	15
Нүхэнд унах аюултай	9
Орчин нөхцөл байхгүй	8
Тоглоом байхгүй	6
Хэрүүл маргаан, зодоон ихтэй	6
Цэвэр ус байхгүй	6
Зам тээврийн осол	4
Архидалт ихтэй	3
Тог цахилгаангүй	3
Нийт	120

Судалгаанд оролцогчдоос тэдний гэр бүл цаашид энэ орон нутагт амьдарсаар байх эсэхийг асуухад 55.9 хувь нь амьдарсаар байна. 18.0 хувь нь үгүй, нүүнэ, 26.1 хувь нь мэдэхгүй байна гэсэн юм. Ерөнхийдөө эдгээр өрхүүдийн амьжиргаанд бичил уурхай ихээхэн нөлөөтэй учир тэд ажиллаж болох өөр уурхай гарсан тохиолдолд хаашаа ч нүүхэд бэлэн байгаа нь судалгааны үр дүнгүүдээс харагдаж байгаа юм.

Хүснэгт 2-36 Цаашид одоо байгаа газраа амьдрах эсэх

Хариулт	Тоо	Хувь
Нүүнэ	62	55.9
Нүүхгүй	20	18.0
Мэдэхгүй	29	26.1
Нийт	111	100.0

Уурхайн орчинд амьдарч буй хүүхдүүдэд зориулсан ямар үйл ажиллагаа хэрэгжүүлмээр байгаа талаар асуухад, хамгийн олон хүүхэд тоглоомын талбай, спорт заал, чөлөөт цаг өнгөрүүлэх газар хэрэгтэй байна гэсэн юм. Мөн хүүхдүүд зөвхөн өөрийн хэрэгцээнээс гадна нийгмийн шинжтэй асуудлууд нэлээд дурьдсан байлаа. Үүнд: сургууль, цэцэрлэг, тог цахилгаантай болох, аав ээжийгээ ажилтай болгомоор байна гэх зэрэг асуудлууд бага насны хүүхдүүдийн хувьд ч хэлж байсан нь нийгмийн наад захын үйлчилгээ авч чадахгүй байгаа нь нөлөөлж байгаа юм.

Хүснэгт 2-37 Хүүхдүүдийн орчиндоо бий болгохыг хүссэн зүйс

Хийх зүйл	Тоо
Тоглоомын талбай	53

Чөлөөт цаг өнгөрөөх газар	10
Спорт заал	7
Сургууль засах, барих	10
Ээж, аав ажилтай болох	7
Интернэт үйлчилгээ	5
Нөхцөл сайжруулж өгөх	4
Сургуулийн халаалт	3
Тог цахилгаан	3
Хичээлийн хэрэгсэл хэрэгтэй	3
Цэвэр усны хангамж	3
Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх газар	3
Хичээл хийх кабенет	2
Хоол хүнсээр туслах	2
Гэр цэцэрлэг	2
Хувцасаар туслах	2
Бусад	10

2.3 ЭЦЭГ ЭХЭЭСЭЭ ТУСДАА АМЬДАРДАГ ХҮҮХДИЙН АСУУЛГЫН ҮР ДҮН

2.3.1 Ерөнхий мэдээлэл

Эцэг, эхийн хэн нэгэн бичил уурхайд ажилласны улмаас, 3 болон түүнээс дээш сарын хугацаатайгаар эцэг эхийн хэн нэгэн эсвэл 2уулангаас нь тусдаа амьдарч байгаа хүүхдүүд бичил уурхайн уурхайн нийгэмд үзүүлж буй нөлөөлний нэг тусгал болж байгаа. Тиймээс тэдгээр хүүхдүүдэд тулгамдаж буй асуудлыг тодруулсныг энэхүү бүлэгт оруулав.

Энэ бүлгийг төлөөлж 246 хүүхэд судалгаанд оролцсон. Эдгээр хүүхдүүд уурхайн орчинд амьдарч буй хүүхдүүдтэй харьцуулахад ажил хийхгүй, боловсролын болон эрүүл мэндийн наад захын үйлчилгээ авч чадаж байгаа боловч эцэг эхээсээ хол амьдарч байгаагийн улмаас мөн л олон асуудалтай тулгардаг байна.

Хүснэгт 2-38 Судалгаанд оролцогч хүүхдүүдийн хамрагдалт, аймгаар

Аймаг	Тоо	Хувь
Завхан	13	5.3
Ховд	13	5.3
Увс	20	8.2
Говь-Алтай	22	9.0
Баянхонгор	17	6.9
Хөвсгөл	2	.4
Дархан	28	11.4
Сэлэнгэ	101	41.2
Төв	13	5.3
Хэнтий	17	6.9
Нийт	246	100.0

Ний 246 хүүхдийн 41 нь аль нэг аймаг, сумнаас шилжиж ирсэн бөгөөд тэдний 30 нь эцэг эх нь уурхайд ажиллах болсон учир шилжиж ирсэн байна. Аль ч бүлгийн хувьд шилжиж ирсэн шалтгааны дийлэнх нь бичил уурхайн ажил эрхлэлт байна. Эдгээр 41 хүүхдийн 33 нь одоо амьдарч буй газраа бүртгэлтэй, 8 нь бүртгэлгүй гэжээ.

Хүснэгт 2-39 Шилжиж ирэгсдийн бүртгэлтэй байсан

Шалтгаан	Тоо	Хувь
Уурхай бараадаж ирсэн	30	73.2
Бусад шалтгаан	11	26.8
Нийт	41	100.0

Энэ бүлгийн судалгаанд хамрагдсан 246 хүүхдийн 102 нь 8-11 настай 104 нь 12-15 настай, 40 нь 16-17 настай хүүхдүүд байна. 110 нь буюу 44.7 эрэгтэй, 136 нь буюу 55.3 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 2-40 Судалгаанд оролцогч хүүхдүүдийн нас

Нас	Тоо	Хувь
8-11 настай	102	41.5
12-15 настай	104	42.3
16-17 настай	40	16.3
Нийт	246	100.0

Судалгаанд оролцогч хүүхдүүдийн хэн нь бичил уурхайд ажиллаж байгааг тодруулахад, 87.4 хувийн аав нь, 39.4 хувийн ээж нь, 26.8 хувийн аав ээж 2 уулаа ажилладаг. Мөн эцэг, эхээс гадна ах, эгч, дүү, эмээ, өвөө нар нь ажиллаж байгаа юм.

Хүснэгт 2-41 Уурхайд ажилладаг хүнтэй хамаарах хамаарал

Хамаарал	Хариулт	
	Тоо	Хувь
Аав	215	87.4%
Ээж	97	39.4%
Ах	29	11.8%
Эгч	5	2.0%
Дүү	3	1.2%
Эмээ, өвөө	1	.4%
Нийт	350	142.3%

Эцэг, эхийн хэн нэгэн болон 2-уулаа гэрээсээ хол ажиллахаар явсан тохиолдолд эцэг, эхээсээ хол төдийгүй айлд амьдрах тохиолдолд цөөнгүй байна. Тодруулбал, манай судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 68.3 хувь л өөрийн гэртээ бусад нь эмээ/өвөөгийнхдөө, танил айлдаа, хамаатныдаа, дотуур байранд амьдарч байгаа юм.

Мөн нийт хамт амьдарч буй хүмүүсийн 30 орчим хувь нь гэр бүлийн эсвэл хамаатан садан биш хүмүүс байна.

Хүснэгт 2-42 Амьдардаг газар

Хаана	Тоо	Хувь
Өөрийн гэртээ	168	68.3
Эмээ, өвөөгийнхдөө	20	8.1
Танил айлдаа	36	14.6
Хамаатны айлдаа	18	7.3
Бусад	4	1.6
Нийт	246	100.0

Уурхайд ажиллахаар явсан эцэг, эхчүүдээсээ хол амьдарч буй хүүхдүүдийн хувьд хэдий хугацаатайгаар хамт амьдарч буйг тодруулахад, 20.7 хувь нь 3 сар хүртэл хугацаагаар, 28.9 хувь нь 3-6 сарын хугацаатайгаар, 24.4 хувь нь 6-9 сар хүртэл

хугацаатайгаар, 26.0 хувь нь 9-12 сарын хугацаатайгаар эцэг, эхтэйгээ хамт амьдарч чаддаг. Бусад үед нь тусдаа амьдардаг байна.

Эндээс харахад, гэр бүлийн уур амьсгал, хүүхэдрүү чиглэсэн эцэг, эхийн хайр халамж, хүмүүжил, хүүхдийн эцэг, эхээ гэх хандлага алдагдахгүй байхын аргагүй байдалтай байна.

Хүснэгт 2-43 1 жилийн хугацаанд хамт амьдардаг хугацаа

Хугацаа	Тоо	Хувь
3 сар	51	20.7
3-6 сар хүртэл	71	28.9
6-9 сар хүртэл	60	24.4
9-12 сар хүртэл	64	26.0
Нийт	246	100.0

2.3.2 Эрүүл мэнд

Эрүүл мэндийн хувьд 26.8 хувь нь буюу 66 хүүхэд эрүүл мэндийн хувьд ямар нэгэн байнгын асуудалтай байдаг. Үүнд бөөр, шээсний замын өвчин, чих хамар хоолойн өвчлөл, амьсгалын замын өвчлөл илүү нийтлэг байна. Уурхайн орчинд амьдарч буй хүүхдүүдийн амьсгалын замын өвчлөл илүү нийтлэг байсан бол эдгээр хүүхдүүдийн хувьд хамгийн олон тохиолдох өвчлөл нь бөөр, шээсний замын өвчин байна. Энэ тохиолдолд ажиглалтын тоо цөөхөн байгаа учир тодорхой дүгнэлт хийж үзэхэд хүндрэлтэй байна.

Хүснэгт 2-44 Өвчлөлийн хэлбэр

Өвчний төрөл	Хариулт	
	Тоо	Хувь
Бөөр, шээсний замын өвчин	21	31.8%
Чих, хамар, хоолойн өвчин	13	19.7%
Амьсгалын замын өвчин	7	10.6%
Зүрх судас	6	9.1%
Үе мөч, булчингийн өвчин	3	4.5%
Арьсны өвчин	3	4.5%
Ядаргаа, сульдаа	2	3.0%
Бусад	21	31.8%

Ээж ааваасаа хол байх хугацаанд 25 хүүхэд ямар нэгэн осол гэмтэлд өртөж байсан бөгөөд 13 нь гадны дэмжлэг хүссэн, сум, өрхийн эмнэлгээс голдуу эрүүл мэндийн тусламж авсан байна. Харин бусад хүүхдүүдийн хамаатан саднаасаа зөвлөгөө авах, өөрөө эм авч уух, өөрөө эдгэхийг хүлээх байдлаар хандсан байх юм.

2.3.3 Хүүхдийн нийгмийн асуудал

Хүүхдүүд ихэвчлэн хол байгаа эцэг, эхтэйгээ утсаар холбоо барьдаг. Бага насны хүүхдүүдийн хувьд утсаар ярих боломж бүрдэх нь бага байдаг. Гэвч сард дор хаяж 1 удаа утсаар холбоо барьдаг. Мөн эцэг, эхчүүд нь боломжтой үедээ хүүхдүүд дээрээ ирдэг. 2 тохиолдлоос бусад нь сүүлийн нэг жилийн хугацаанд хамгийн багадаа нэг удаа уулзсан байна.

Хүснэгт 2-45 Утсаар холбоо барих хугацааны давтамж

Давтамж	Тоо	Хувь
Утсаар ярьдаггүй	26	10.6
Өдөр бүр	105	42.7
Долоо хоногт 3-4 удаа	46	18.7
Долоо хоногт 1-2 удаа	58	23.6
Сард 1-2 удаа	11	4.5
Нийт	246	100.0

Анхдагч гэр бүлийн хүн байхгүй, өөр гэр бүлд амьдарч буй хүүхдүүдийн хувьд хамт амьдарч буй хүмүүстэйгээ зөрчилдөх тохиолдол бусад хүүхэдтэй харьцуулахад их байсан бөгөөд ихэвчлэн 12-17 насны хүүхдүүдийн хувьд их байгаа нь харагдсан.

Судалгаанд хамрагдсан 246 хүүхдийн 20.7 хувь буюу 51 нь ямар нэгэн байдлаар дараахь хүчирхийллүүдийн хохирогч болж байсан гэжээ. Өөрийн тохиолдлын хувьд ч, бусад хүүхдийн хувьд хамгийн олон давтагдсан нь зодуулах, хэл амаар доромжлуулах асуудал байсан юм.

Хүснэгт 2-46 Хүүхдэд тохиолдох эрсдэл

Тохиолдох эрсдэл	Өөрөө		Бусад хүүхэд	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хэл амаар доромжлуулах	32	13.0%	24	9.8%
Зодуулах	17	6.9%	35	14.2%
Сүрдүүлэх	16	6.5%	24	9.8%
Мөнгө татуулах	5	2.0%	14	5.7%
Эд зүйлсээ дээрэмдүүлэх	3	1.2%	19	7.7%
Бэлгийн дарамтанд өртөх	-	-	1	.4%
Бусад	2	.8%	6	2.4%

Дээрх үзүүлэлтийг уурхайн орчинд амьдарч буй хүүхдүүдийн уг үзүүлэлттэй харьцуулж үзвэл, нийт дунд эзлэх тооны хувьд уурхайн орчинд амьдарч буй хүүхэд илүү эрсдэл өртөж байна.

Аав, ээжээсээ олон хоногоор хол амьдарч буй хүүхдүүдийн хувьд юу нь хэцүү байдаг талаар асуухад, 109 хүүхдийн хувьд төдийлөн хүндрэлтэй асуудал байдаггүй гэсэн бол, хамгийн олон тохиолдсон хүндрэлтэй асуудал аав, ээжийгээ санадаг,

байхгүй үед нь мөнгө өгөх хүн байхгүй, сургуулиас мөнгө нэхэх үед бүр хэцүү байдаг, аав ээжийгээ хүнд ажил хийдэг учир өвдөх, бэртэхээс санаа зовдог гэжээ.

Мөн аав ээж нь байхгүй учир дүү нараа харах, гэрийн бүх ажил хийх зэрэг нь хэцүү байдаг, хичээлээ хийх боломж олгодоггүй гэсэн юм.

Харин зарим өрхийн хувьд аав, ээжийгээ байхгүй үед хоол хүнсгүй болох, түлээ түлшгүй болох зэрэг асуудал ч тулгардаг байна.

Эцэг, эхийн хэн нэгэн уурхайд ажиллаж, хэн нэгэн гэртээ хүүхдүүдтэй хамт байдаг, өвөө эмээтэйгээ амьдардаг хүүхдүүдийн хувьд харьцангуй асуудал багатай. Харин хоёулаа байхгүй тохиолдолд хоол хүнс, түлээ түлшгүй болох, гэрийн ажил хийх, дүү нараа харах зэрэг арай том хүүхдүүдэд илүү их ачаалал ирдэг байна.

Хүснэгт 2-47 Аав, ээж нь байхгүй үед тохиолдох хүндрэл

Хүндрэл	Тоо	Хувь
Байхгүй	109	44.3%
Аав, ээжийгээ санадаг	41	16.7%
Мөнгөөр дутагддаг	18	7.3%
Аав, ээжийгээ хүнд ажил хийдэгт санаа зовдог	18	7.3%
Гэрийн бүх ажил хийх хэцүү	17	6.9%
Дүү нараа харах хэцүү	15	6.1%
Айдаг	8	3.3%
Хоол хүнсгүй болдог	7	2.8%
Түлээ, түлшгүй болдог	6	2.4%
Гэртээ ганцаараа байх нь хэцүү	4	1.6%
Эцэг, эхийн хуралд суух хүнгүй	3	1.2%
Нийт	246	100.0%

Цаашид эцэг эх нь бичил уурхайд ажиллах эсэх талаар хүүхдүүдийн таамгийг тодруулахад, 40.7 хувь нь цаашид бичил уурхайд ажилласаар байна, 19.1 хувь нь ажиллахгүй, 40.2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Хүснэгт 2-48 Эцэг, эхийн нь цаашдын ажил эрхлэлтийн хандлага

Цаашдын хандлага	Тоо	Хувь
Цаашид уурхайдаа ажилласаар байна.	100	40.7
Цаашид уурхайд ажиллахгүй ажиллахгүй	47	19.1
Мэдэхгүй	99	40.2
Нийт	246	100.0

Судалгаанд оролцогч хүүхдүүдээс хүүхдүүдэд зориулж юу хийгээсэй гэж хүсэж байна гэж асуухад, тоглоомын талбай, спорт заал/ хүүхдийн парк, чөлөөт цагаа өнгөрөөх газар, сургууль гэх зэрэг зүйл байгуулаасай гэсэн бол өөр нэг анхаарал

татсан зүйл нь хүүхдүүд аав, ээжтэйгээ хамт байхын тулд аав, ээж гэртээ амьдрах боломжтой ажлын байр хүсэж байгаа юм.

Хүснэгт 2-49 Хүүхдүүдэд орчиндоо хийхийг хүссэн зүйл

Хийх зүйл	Тоо	Хувь
Тоглоомын талбай	72	34%
Спорт заал	27	13%
Аав, ээж гэртээ байдаг ажил	23	11%
Чөлөөт цагаа өнгөрүүлэх газар	16	8%
Сургууль засах, барих	12	6%
Амьдралын боломжгүй хүмүүст туслах	8	4%
Дотуур байр янзлах, хоолыг сайжруулах	7	3%
Номын сан	7	3%
Хичээлийн хэрэгсэл хэрэгтэй байдаг	7	3%
Интернет	6	3%
Сургуулийн унаа	5	2%
Хичээл хийх газар	4	2%
Гэр оронтой болох	3	1%
Гэртээ үлдсэн хүүхдүүдийг тусгай байранд оруулах	3	1%
Хоол хүнс хэрэгтэй	3	1%
Бусад	7	3%
Нийт	210	100%

3 ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1 БИЧИЛ УУРХАЙЧИН ЭЦЭГ, ЭХТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан цуглуулсан. Энэ бүлэгт чанарын судалгааны үр дүн танилцуулж байна. Чанарын судалгааны мэдээллийг бичил уурхайчин эцэг эхчүүд болон тэдний хүүхдүүдтэй аль аль нь хамрагдсан.

Бидний зочилсон 10 аймаг, 17 сумын олборлолтын талбай нь орчин нөхцөлийн хувьд, цар хүрээний хувьд, ажиллаж буй хүний тооны хувьд, үйл ажиллагаа явуулж буй хэлбэрийн хувьд маш ялгаатай байсныг дурьдах хэрэгтэй. Жишээ нь зарим олборлолтын талбай сум, багийн төвийн ойролцоо байрладаг бол зарим олборлолтын талбай хэдэн зуун км хол, олон цөөн хүн ажиллах, нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон ороогүй гэх зэрэг маш олон янзын газар очсон. Тиймээс судалгааны зорилгод нийцсэн хүүхдийн тухай нийтлэг асуудлыг илүү анхаарч авч үзсэн.

Судалгаанд хамрагдсан хувиараа ашигт малтмал олборлогчид алт, нүүрс, жонш олборлогчид байсан юм. Эдгээр гар аргаар олборлогчдын үйл ажиллагаа зуны улиралд хамгийн идэвхтэй байдаг байна. Харин нүүрс олборлогчдын хувьд өвөл нүүрсний борлуулалт өсдөгтэй холбоотойгоор өвөл үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг. Мөн тэдгээрийн тодорхойгүй хувь нь жилийн дөрвөн улиралд ажилладаг. Бичил уурхайчдаас гадна худалдаа, наймаа эрхлэх гэр бүлүүд ч байна.

Зураг 3-1 Төв аймаг, Заамар сум, Хувиараа ашигт малтмал олборлогчид



≡ Нөхөрлөлийн зохион байгуулалт

Бидний зочилсон орон нутгуудад бичил уурхайчид зохион байгуулалтанд орсон байдал харилцан адилгүй байсан. Зарим орон нутагт нөхөрлөл болохыг илүүд үзэж байхад, зарим орон нутагт нөхөрлөлд орохоор илүү дарамт үүснэ гэж үзэж байна.

Нөхөрлөлд хамрагдалтанд нөлөөлж буй нэг үндсэн нөхцөл нь олборлолтын талбай хэр тогтвортой, олдоцтой байх вэ гэдгээс хамаарч байгаа нь ажиглагдаж байсан.

Жишээ нь: Төв аймгийн Заамар суман дахь Хайлааст багийн орчим олборлолт хийх боломж ихтэй учир Хайлааст багийнхан нөхөрлөлийн зохион байгуулалтанд орохыг илүүд үзэж байна. Олборлолт хийх талбай олдоцтой байх үед сард 53000 төгрөг төлөөд тайван ажлаа хийх боломжтой байна гэдэг нь тэдний хувьд илүү дээр нөхцөл юм.

Зураг 3-2 Нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон олборлолтын талбай



Харин түр хугацаанд ажиллах малчид, өөр аймаг сумнаас ирж олборлолт хийж байгаа хүмүүст зохион байгуулалтанд орох нь харин ч хохиролтой гэж үзэж байна. Сар бол 53000 төгрөг төлнө. Дээрээс нь нөхөн сэргээлт хийх гэх зэрэг дараагийн хариуцлагууд төвөгтэй байдаг учир хууль бусаар олборлолт хийсээр байна. Зөвхөн Баянхонгор аймгийн Галуут суманд Засаг даргын хэлснээр 140 гаруй бүртгэлгүй гар аргаар алт олборлогчид байна.

Нөхөрлөлийн зохион байгуулалт орон нутаг бүрт адил биш зарчимтай явагдаж байгаа нь судалгааны явцад ажиглагдсан. Зарим орон нутагт зөвхөн тухайн сумын иргэд л нөхөрлөлд хамрагдах эрхтэй байхад, зарим орон нутагт иргэний харъяалал хамаагүй байх жишээтэй. Орон нутгийн удирдлагаас хууль эрхзүйн дагуу үйл ажиллагаа явуулахыг бичил уурхайчдаас хүсдэг ч зөвхөн орон нутгийн гэлтгүй, өөр аймаг хотоос хүмүүс ирдэг учир зохицуулалт хийхэд хэцүү байдаг байна.

Бичил уурхай тойрсон асуудлууд их байдаг ч зохион байгуулалтанд орсон бичил уурхайчид орон нутгийн төсөвт бага ч гэсэн хувь нэмрээ оруулдаг нөгөөтэйгүүр өөрсдийнх нь амьжиргаа дээшилж байгаа нь хамгийн том үр ашиг болж харагдаж байлаа.

≡ Хүүхдийн асуудал

Энэхүү судалгаагаар хүүхдэд нөлөөлж буй нөлөөллийг судалж байгаа учир сөрөг тал нь илүү байсан нь судалгааны үр дүнд харагдсан юм.

Бичил уурхайчид амьдарч буй орчинд хүүхэд амьдарч байгаа учир хүүхдүүдэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд бичил уурхайчдын асуудлыг шийдэх, тэдний эцэг эхийн асуудлыг шийдэх нь хамгийн том нөлөө болж чадахаар байлаа.

Бичил уурхайчид дунд гэр бүлийн хүмүүс хүүхдүүдтэй, өрх толгойлсон эмэгтэй, өсвөр насны хүүхэд гэх зэрэг маш олон янзын хүмүүс байгаа учир тэд бүхний төлөөлөл судалгаанд оролцсон юм.

Тухайлбал, 3 хүүхэдтэй, өрх толгойлсон ээж тэнд хүүхдүүдийнхээ өмсөж зүүх, идэж уух, сургуулийг нь таслуулчихгүй юмсан гэж өдөр болгон амрахгүйгээр ажилладаг хэмээн ярьж байлаа. Өөрөө л тэнд ажиллахгүй бол тэднийг хэн ч тэжээхгүй идэх хоолгүй болно. Мөн 5-хан сартай охиноо ээж дээрээ үлдээгээд ажиллаж байгаа өрх толгойлсон эмэгтэй манай судалгаанд хамрагдсан юм.

Уурхайд ажиллаж байгаа өрх толгойлсон ээжийн гэрт очиж үзэхэд 4 настай дүүгээ ээлжилж хардаг 3 болон 5 ангийн 2 охин зутруухан сууж байсан юм. Энэ мэтчилэн хараа хяналтгүй хэцүүхэн амьдарч байгаа хүүхдүүд олон байна.

Зураг 3-3 Сэлэнгэ аймаг, Ерөө сум, Чингэлэгт амьдардаг охин



Зөвхөн Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Цагаан цахирын уурхайгаар жишээ авахад, ажиллагсдын зарим нэг нь хамгаалах хэрэгсэл өмссөн байхад, зарим нь огт хамгаалалтын хувцас өмсөөгүй ажилладаг. Амьдарч байгаа суурин /гэр/ нь уурхайн нүхнээс ердөө 50-иадхан метрээс эхлээд байдаг. Ойролцоо маш олон ухсан нүх байдаг. Тэдгээр нүхнүүдийг дээрээс нь харахад ёроол нь харагдахгүй маш гүнзгий. Тухайн орчинд талбайн гэрэлтүүлэг огт байхгүй тул хүн, мал шөнө орой харанхуйд харахгүй унах аюул маш ойрхон байна. Зарим нүхний амыг нь тойруулон утас татан, бичиг хадсан ч тэр нь тийм нь анхааралд өртөхөөр биш байгаа юм. Гэр, майхан эсвэл

дугирцагт голчлон хоног төөрүүлдэг. Олохоосоо олохгүй нь их. Хоосон хонох ч тохиолдол гардаг ажээ. Багаж хэрэгсэл муутай учир олох алтны олдоц сайнгүй. Эдгээр хүмүүс дулааны улиралд гэр бүлээрээ, хүүхдүүдтэйгээ байх ба хүйтрээд хичээл сургууль орсон үед хүүхдүүдээ сумруугаа явуулаад өөрсдөө уурхайдаа үлддэг.

Бичил уурхайн орчинд өсөж хүмүүжиж байгаа хүүхдүүдэд бичил уурхайн нөлөө ихээхэн байдгийн тод илрэл нь хүүхдүүдийн өдөр тутмын яриа, үг хэллэгээс ч ихээхэн харагдаж байгаа юм.

Дэлхийн Зөн Монгол ОУБ. Хүүхэд хариуцсан мэргэжилтэн Баясгалан:

Манайх 1-2 жилийн өмнө ЕБС-ийн 9,10 дугаар ангийн хүүхдүүдийн дунд “Дэвжээ” тэмцээн чөлөөт сэдэвтэйгээр зохион байгуулсан. Гэтэл бүх сургуулийн бүх үзүүлбэр бүгд л ногоон төмөн барьж гарч ирээд л “бурзай, бурзай” гээд л, дандаа алттай холбоотой.

Нэг баг нь алтнаас болж байгаль, дэлхий яаж сүйдэж байгаа талаар сэдэвтэй байхад, нөгөө баг нь ээж, аав нь алтанд явчихаар ард үлдсэн хүүхдүүд нь яаж наргиж цэнгэж яваад замаа алдаж байгаа сэдэвтэй. Тэмцээнд оролцсон 6 сургуулийн баг 6-уулаа алттай холбоотой байсан нь энэ асуудал хүүхдүүдэд ямар гүнзгий тусаж буйг харуулж байгаа юм.

Бичил уурхайчдын эрх ашгийн төлөө хамгийн дорвитой үйл ажиллагаа явуулж буй газар бол Швейцарийн хөгжлийн агентлаг гэдгийг орон нутгийн захиргааны ажилчид, бичил уурхайчид хэлж байсан. Уг байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бичил уурхайчид хүлээн зөвшөөрөгдөж, хууль эрхзүйн орчин бүрдэж, нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж, хөдөлмөр хамгааллын хүрээнд хэрэгжүүлбэл зохих заавар зөвлөмж авч, сургалтанд хамрагдсан байна.

Шинэ хууль гарсантай холбоотойгоор гарсан өөр нэг өөрчлөлт бол тухайн орон нутагтаа алт олборлодог газраа компани, байгууллагуудад алдсан учир өмнөхөөсөө ч хол газар явж ажиллах болсон байна. Жишээ нь, Говь-Алтай аймгийн Бигэр сумын алтны уурхай Макс группын мэдэлд очсон. Үүнээс үүдэж хүмүүс ухах газаргүй болж Завхан аймагруу хүртэл явах болсон байна.

Энэ мэт асуудал нь бидний ярьж буй хүүхдийн асуудалд улам л хүндээр туссан нь судалгаанаас явцад харагдаж байлаа. Аймаг дотроо алтанд явдаг байхад сардаа нэг удаа гэртээ очиж, гэр бүл, хүүхдүүдтэйгээ уулздаг байсан бол одоо бүтэн жилээр ч гэрээсээ хол өөр аймагт ажиллаж, олсон мөнгөө сумын төв орж банкаар гэррүүгээ шилжүүлдэг болсон байна. Нүүрс, жонш олборлогчид харьцангуй тогтмол нэг газраа ажилладаг. Харин алт олборлогчид хаана л алт гарна тийшээ нүүж, байнгын хөдөлгөөнд байдаг аж.

3.1.1 Бичил уурхайчид маш хүнд нөхцөлд ажиллаж байна.

Өмнө дурьдсанчлан бичил уурхайчдын ажиллаж буй нөхцөл байдал харилцан адилгүй. Зарим аймаг, сумын хувьд өглөө гэрээсээ гарч олборлолтын талбай дээр ажиллачихаад орой гэртээ ирдэг бол ихэнх бичил уурхайчид гэрээсээ хол тэр байтугай өөр аймаг, сум дамжиж ажилладаг. Эдгээр хүмүүсийн хувьд ажиллах орчин нөхцөл бусдаасаа илүү хүнд байна.

Орон байр: Хаа нэгтээ алт гарлаа гэх сургаар тийшээ машин, мотоциклиар хэд хэдээрээ нийлэн бүлэг очиж ажиллана. Тухайн газрын ойролцоо ямар нэгэн сум, суурин байхгүй байсан ч эзгүй, зэлүүдийг үл хайхран, хэдэн хоног сараар ажиллана. Орж хоноглох, дулаацах орон гэр байхгүй. Машин эсвэл майханд хоноглож, хоол ундаа газрын плитка дээр хийдэг байна. Заримдаа майханд хоносноос гүнзгий ухсан нүхэнд орж унтах нь илүү дулаан байдаг ч гэх хүмүүс байсан юм.

Зураг 3-4 Бичил уурхайчдын сууцны хэлбэрүүд





Говь-Алтай аймаг, Бичил уурхайчин Бороо:

Хоол унд хийх газ хөлдчих гээд өвөртөө хийж дулаацуулж хонодог. Машиндаа паяльник асаагаад дулаацдаг. Өвөл бол ажиллахад хүнд байдаг. Амьдралын эрхээр л ажилладаг.

Ажлын цаг: Бичил уурхайчидтай ажлын цаг, ажлын өдөр гэсэн ойлголт, зааг ярихад ихээхэн хүндрэлтэй. Тэдний ихэнх нь ажилгүй иргэд байдаг учир жилийн 4 улиралд, тодорхой хугацаагаар ажилладаг. Олборлолт хийх газар олдсон тохиолдолд, алтны гарц ихтэй үед, цаг агаар дулаан байгаа үед улам ч илүү олон цагаар ажилладаг.

Зураг 3-5 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Ялаатын уурхай



Зураг 3-6 Баянхонгор аймаг, Галуут сумын уурхай



Баянхонгор аймаг, Бичил уурхайчин Баярсайхан:

Өглөө гараад орой ирнэ. Алт гарч байвал шөнө хоноод л ажиллана. Хагас бүтэн сайнаа мэдэхгүй л ажиллана. Амарна гэж мэдэхгүй, жилд хамгийн багадаа 200 хоног ажилладаг. Сард ойролцоогоор 600,00-700,000 төгрөг олдог.

Ундны ус: Мөн зарим уурхайн орчимд ундны ус авах газар байдаггүй. Бичил уурхай болон томоохон уурхайн нөлөөгөөр их бохирдсон байдаг учир ундны усаа холоос зөөдөг. Ажилдаа улайраад усаа авч чадаагүй тохиолдолд ажлын талбар дээр уух ус ч үгүй болдог байна.

Хөдөлмөр хамгаалал: Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн хүрээнд бичил уурхайчдад аюулгүй ажиллагааны дүрэм хэрэгжүүлж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэхийг санал болгодог ч албан бусаар үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн хувьд аюулгүй ажиллагааны дүрэм, хөдөлмөр хамгааллын хувцас алины ч талаар ойлголтгүй байгаа юм. “Тогтвортой бичил уурхай” төсөл илүү алтны чиглэлээр ажиллаж байгаа бичил уурхайчидруу чиглэгдсэн заавар зөвлөмжтэй байдаг учир жонш, нүүрс зэрэгт тийм ч тохиромжтой бус байдаг аж.

Дэлхийн зөн Монгол ОУБ, Бэрх тосгон хариуцсан Хөгжлийн ажилтан Мөнхжаргал:

Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны ямар ч дүрэм мэдэхгүй. Маш аюултай газар ажиллаж байгаа юм. 100 метрийн өнгөн хөрсөн доор тогтож байгаа, доогуураа хөндий газар л ажиллаж байгаа юм. Манай байгууллагын зүгээс “Хөдөлмөр хамгаалал”, “хүүхдийн хөдөлмөр” гэсэн хоёр асуудлаар очиж сургалт хийдэг.

3.1.2 Бичил уурхайчдын эрүүл мэнд доройтож байна.

Дээр дурьдсанчлан бичил уурхайчдын ажиллах нөхцөл тун хүнд. Байнга даарч хөрөх, шороо тоос ихтэй нөхцөлд ажиллах, нүхэнд орж ажилласнаас агаарын дутагдалд орох, усан дотор удаан зогссоноос жиндэх, ухсан нүхэндээ унах, хүнд зүйл өргөх зэргээр эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүнд нөхцөл. Бичил уурхайчид дунд эрэгтэй, эмэгтэй, өсвөр насны хүүхдээс эхлээд 60 гарсан хүн гээд л бүхий л насны хүмүүс байна.

Хүнд юм өргөх, даарч хөрснөөс үүдэлтэй бөөр нуруу, үе мөч өвдөх нь их байдаг нь судалгаанд оролцогчдоос харагдаж байсан. Тоосны харшил, ханиад зэргийг бараг л өвчин биш гэж хүлээж авч байлаа. Алт амины үнэтэй гэж ярьдаг, мэр сэр хүмүүс нас барж гэнэ энд тэнд дуулддаг. Тиймээс өвдөх ч гайгүй, амиа алдах асуудал байдаг гэж хүртэл ярьж байсан нь эдгээр хүмүүсийн эрүүл мэнд ямар байгаа, өөрсдөө эрүүл мэнддээ ямар хэнэггүй ханддагийг харуулж байсан юм.

Зураг 3-7 Говь-Алтай аймаг, Дэлгэрийн уурхай: Тоосжилт ихтэй



Баянхонгор аймаг, Бичил уурхайчин Баярсайхан:

Даарч хөрсөнөөс болоод бөөр нуруу өвдөнө. Бидний насны хүмүүс нуруу л их өвдөнө дөө. Хүнд шороо үүрнэ. Нурууны өвчнөөс болоод хагалгаанд орж байсан тохиолдол байгаа. Нүхэнд дотор аргалаар галдуур тавиад түүндээ угаартдаг. Заримдаа ухаангүй болж гарч ирнэ. Тэр их хэцүү.

Говь-Алтай аймаг, Бичил уурхайчин Мөнхжаргал:

Амиа алдахыг үгүйсгэхгүй шүү дээ. 2011 онд Яманусын уурхайд нүхэнд түнэл үүсгэж байгаад шороонд дарагдаж өнгөрсөн тохиолдол байгаа.

Говь-Алтай аймаг, Бичил уурхайчин Дэмбээ:

Гүний шрүп бол 20-26 метрт хүрдэг. Би тийм гүн шрүпэнд хөл алдаж унаад, хүнд бэртэж байсан. Цуг амьдарч байсан хүмүүс тусалж, асарч байсан. Унах, хавиргаа хугалах зэрэг бол байдаг шүү дээ.

Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга Баттулга:

Хоёр төрлийн өвчлөл манай хүмүүс дунд их байгаа нь ажиглагддаг. (i) Олон цагаар өвлийн нөхцөлд хөлдүү газар паяльник барьж суугаад үүнээс болоод уушигны өвчин тусах тохиолдол их байна. (ii) Мөн хүйтэн нөхцөлд олон цагаар суухаар доороосоо даарч бөөр нурууны өвчлөл их гарах юм. Шороонд дарагдаж амь насаа алдах ч тохиолдол гарч байсан.

Бичил уурхайчдын дээвэр холбооны Гүйцэтгэх захирал О.Цэцэгмаа:

Нүхэн дор явж байдаг болохоор бөөр, ууц нуруу, үе мөчний өвчин бол манайд маш их. Уушиг, зүрхний өвчлөл бас их. Яагаад гэхээр байнга агаарын дутагдалд ордог. Тоосжилт ихтэй. Тэгээд л зүрхний цусан хангамжийн дутагдал болно. Хүүхдэд ч бас ийм асуудал ялгаагүй л өртөнө. Тэр тусмаа зохион байгуулалтанд ороогүй хүмүүс байна шүү дээ. Бут модны ёроолд хүүхдээ боогоод тавьчихсан. Алсаас хараад л байж байдаг.. Өт хорхой ирээд хатгахаас авахуулаад наад захын асуудал бол зөндөө байна.

3.1.3 Бичил уурхайчдын өрхийн эдийн засгаа хөтлөх мэдлэг, дадал муу байна.

Бичил уурхайчдын 90-ээд хувь нь бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой иргэд байсан нь тоон судалгааны үр дүнгээс харагдсан. Зонхилох хувь нь ажил олдоогүй улмаас ажил эрхэлж байгаа иргэд. Тиймээс тэдний үг, үйлдлээс эдийн засгаа хөтлөх мэдлэг дутуу байгаа нь ихээхэн анзаарагдаж байсан юм.

Олон цагаар, хүнд нөхцөлд ажилладаг ч олох орлого харилцан адилгүй, гэвч чамлахааргүй орлого олдог нь тоон судалгаанаас харагдсан. Харин зарцуулалтын хувьд олсон орлогоо өдөр өдөрт нь хэрэглэдэг, буруу худалдан авалтууд хийх, хуримтлал үүсгэх бодол байхгүй, өр тавих зэрэг санхүүгийн сахилга бат, зохицуулалт шаардсан үйлдлүүд их байна.

Жишээ нь: Хөдөө 1 сар ажиллаж 500,000 төгрөгтэй суман дээрээ ирсэн иргэн, явахаасаа өмнө тавьсан өрөө дараад, үлдсэнээр нь гэртээ хоол хүнс, ойр зуурын хэрэгцээтэй юмаа аваад амарч байгаа нэрээр архидаж байгаад явдаг байна. Хэд хоногийн дараа ахин олборлолтын талбайруу явахдаа өөрийн хэрэглэх хоол хүнс, шатахуун зэргээ хүнээс мөнгө зээлээд аваад явах жишээний. Тэгэхээр энэ буруу хэвшлийн тойргоос гарах гол арга зам нь тэдний мөнгөтэй харьцах арга ухааныг өөрчлөх нь ихээхэн түлхэц болох нь харагдаж байгаа юм.

Баянхонгор аймаг, Жаргалант сум, Засаг дарга Сайнбилэг:

Архидалт бол байдаг. Наймаа хийж байгаа хүмүүс архи зарж байна. Хэт хавтгайраагүй ч байдаг асуудал. Захирамж гаргаад ажлын хэсэг томилоод хэд хэдэн удаа архи зарж байгаа хүмүүсийн архийг хураалгуулсан, торгуулсан. Гэвч хаширдаггүй. Дэлгүүрт 15,000 төгрөгний архи тэнд 30,000 төгрөгөөр зарагддаг. Зовж олсон хэдэн төгрөгөө архинаас өгчихдөг. Хуулийн хэмжээнд 50,000 хүртэл төгрөгөөр торгодог. Гэвч үүндээ эмзэглэхгүй.

Бидний зочилсон өрхүүдэд ажиглагдсан нэг нийтлэг асуудал нь сумын төвийн дэлгүүрүүдээс зээл авч, өр тавих асуудал. Зээлийн барьцаанд хөгшчүүлийн тэтгэврийн дэвтэр, хүүхдийн мөнгөний дэвтрийг үлдээсэн байх юм. Нэг хүнсний дэлгүүрээр орж сонирхвол бүр барьцааны дэвтрүүд хийх зориулалтын хайрцагтай, түүн дотроо үсгийн дарааллаар хийсэн 20 гаруй дэвтэр бидэнд гаргаж үзүүлсэн юм.

Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга Баттулга:

Бичил уурхай эрхлэгчид амжиргааны түвшин доогуур, ядуу амьдралтай, малгүй байгалийн баялгаас мөнгө олдог хүмүүс байдаг. Олохгүй биш олоод байдаг, олсноо зөв зарцуулж чаддаггүй. Ихэнх хугацаанд олж чадахгүй хий яваад байдаг. Тэгээд бага шиг юм олохоороо урдын өрөө төлдөг, үлдсэнээр нь ууж иддэг. Тэгээд маргааш нь ахиад л нүхээ үхна. Мөнгөний хуримтлал байхгүй. Дараа нь өөр баялаг бүтээх боломж байхгүй. Тэгэхээр эдийн засгийн хувьд батжих бэхжих юм байхгүй.

Иргэдийн мөнгөтэй харьцах харьцаа, өрхийн эдийн засгийн энэ хэв маяг тухайн гэр бүлийн гишүүд, хүүхдүүдийн эрүүл мэнд, боловсрол, хоол хүнсний хомсдолгүй байдал зэрэг бүхий л асуудлын үндэс болж байгаа нь олон өрхийн жишээн дээр харагдаж байгаа юм.

3.1.4 Тогтвортой ажлын байр дутмаг байна.

Судалгаанд оролцогчдын 4 хүн тутмын 3 нь өөр ажил олдохгүй улмаас бичил уурхай эрхлэх болсон гэж тайлбарласан. Аймгийн төв, сумын төв гэлтгүй орон даяар ажлын байрны дутагдал, ажиллах хүчний чанаргүй байгаа асуудал яригдаж байгаа. Үүний нэг хэсэг нь энд илэрч гарч байгаа юм.

Сум багийн түвшинд төрийн үйлчилгээний газрууд, төсвийн байгууллагууд (эмнэлэг, сургууль гэх мэт), хүнсний дэлгүүрүүд, кафе, цайны газар гэсэн цөөн хэдэн газар үйл ажиллагаа явуулж, тэнд нь цөөн хэдэн хүн ажиллаж байна. Өөр ажлын байхгүй учир, нөгөөтэйгээр мэргэжил, боловсролын хувьд тэнцэхгүй учир ихэнх иргэд ажилгүй.

Зураг 3-8 Хэнтий аймаг, Батноров сум



Зураг 3-9 Баянхонгор аймаг, Галуут сум



Аймгийн төв дээр арай илүү хувийн хэвшил үйл ажиллагаа явуулж ажлын байраар хангадаг ч эдгээр иргэдийн хувьд мөн л ажил мэргэжил, боловсрол, нас, хүйсээрээ гологддог байна. Хамгийн олдоцтой ажлын байр нь барилгын ажил. Гэтэл барилга дээр ажиллахад цалин хөлсөө өгөхгүй, ажил тасалдах зэрэг асуудал их байдаг учир бичил уурхайг илүүд үздэг ажээ.

3.1.5 Ажилд хандах хандлага сөрөг байна.

Судалгаанд оролцогчдын ихэнх нь бидэнд тогтмол ажлын байр хэрэгтэй байна гэх боловч барилга дээр ажиллах, уурхайн компанид ажиллах зэрэг ажил хийх боломж байхад ажилладаг байна. Учир нь цагаар ажиллахгүй, хүний удирдлаган доор ажиллахад хэцүү зэрэг шалтгаан хэлж, олох үедээ олоод, олохгүй үедээ олохгүй өөрийн дураар энэ ажил маань дээр гэж ярих нь тэдний ажил хөдөлмөрт хандах хандлага сөрөг байгааг харуулж байсан юм.

Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга Баттулга:

Олон жил ингэж дураараа дуртай газраа ухаж явсаар байгаад эдгээр хүмүүсийн бодол санааг ойлгоход хэцүү болсон. Сумын захиргаанаас гар аргаар алт олборлож байхаар гайгүй цалинтай энэ уурхайд ажилд орчихооч гэхээр орохгүй байгаа юм. Бид нар чөлөөтэй байна, цагаар ажиллаж чадахгүй гэдэг.

3.1.6 Зөвшөөрөлгүй бичил уурхайчид болон цагдаа нарын хоорондын зөрчил

Нөхөрлөлийн зохион байгуулалтанд бүхий л орон нутаг хамрагдаж чадаагүй. Зарим орон нутагт зохион байгуулалтанд орсон бичил уурхайчдад өгөх газар байхгүй, эсвэл газар нь нэг байгууллагын эзэмшилд орсон гэх зэрэг шалтгаанаар бичил уурхайчид зөвшөөрөлгүй газар нууцаар олборлолт хийсээр байна.

Үүнээс бол орон нутгийн цагдаа болон бичил уурхайчид хооронд багагүй зөрчил үүсдэг. Нууцаар олборлолт явуулж буй нь илэрсэн тохиолдолд, баривчилж

бороохойдох, багаж хэрэгслийг нь хураах, торгох зэрэг асуудлууд үүсдэг учир хөөлгөнөөс өмнө амжих гэж шөнө оройн цагаар ажиллах, ойр орчны хүмүүс, хүүхдүүдээ дайчлах асуудал ч үүсдэг байна. Тухайлбал, манай судалгааны мэдээлэл цуглуулах баг Төв аймгийн Заамар суманд ажиллахдаа судалгаа авахаар бичил уурхайчид хаагуур байгаа талаар асуухад бүх хүн тийм хүмүүс байхгүй, одоо тийм юм байхаа больсон гээд, нөхөрлөлд орсон хүмүүсийг л зааж өгч байлаа. Удаан хугацаанд нэлээн олон хүнээс асуусны эцэст, учраа сайтар тайлбарласны үндсэн дээр нэг хүн бидэн тусалж нууцаар олборлолт хийж буй газар дагуулж очиход бидний машиныг хараад машин мотоциклио асуугаад тал тал тийш, хоромхон зуур алга болов. Танихгүй машин хараад, барилчилгаа гэж бодож зугтаж байгаа нь тэр гэнэ. Харин дараа нь тэдэнд учраа хэлж уулзахад, энэ мэт явдал байнга тохиолддог. Ингэж зугтаж яваад унаж бэртэх, машинтай хоорондоо мөргөлдөх зэрэг асуудал гардаг гэнэ. Багаж хэрэгслээ хураалгахгүйн тулд нүхэндээ нуух зэргээр авч үлддэг аж.

Зураг 3-10 Төв аймгийн Заамар сум, Цагдаагийн пост



Бичил уурхайчдын дээвэр холбооны Гүйцэтгэх захирал О.Цэцэгмаа:

Баривчилгаа чинь нэг төрлийн дарамт болдог. Энэнээс болоод яадаг вэ гэхээр өнөө хүний амь нас эрсдэнэ, үхнэ, гэмтэнэ. Тайван орчинд бол хөдөлмөр хамгааллаа хамгаалаад явчихаж чаддаг хүмүүс. Гэтэл одоо хөөлгө, туулга гэхээр хөөгдөхөөсөө өмнө хэдэн юм олоод авъя гээд сандарна. Үүнээс болж осол аваар гарах тохиолдол байгаа шүү дээ.

3.2 ХҮҮХДҮҮДТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГЫН ҮР ДҮН

Судалгаанд оролцогч хүүхдүүд ерөнхийдөө 2 ангилалд хуваагдаж байгаа. Эхний хэсэг нь хүүхдүүдийн эцэг эхийн хэн нэгэн эсвэл хоёулаа тэднийг орхиж, хол амьдарч байгаа. Нөгөө хэсэг нь эцэг эх нь ажлын талбарруугаа аваад явдаг буюу уурхайн орчинд хамт амьдардаг.

Эдгээр хүүхдүүдийн аль алиных нөхцөл байдал хүнд байдаг нь судалгааны явцад харагдаж байлаа. Аль алинд эцэг, эхийн анхаарал халамж дутуу байдаг гэдгийг эцэг, эхчүүд болон хүүхдүүдтэй хийсэн ярианаас харагдаж байсан юм. Зуны улиралд, хичээл амрахаар эцэг эхээ дагаж явдаг, уурхайн орчинд амьдардаг хүүхдүүдийн тоо ихээхэн нэмэгддэг. Эцэг эхтэйгээ хамт амьдарч байгаа хүүхдүүд зуны улиралд ихээхэн нэмэгддэг ч зарим хүүхдүүдийн хувьд жилийн 4 улирлын туршид уурхайн орчинд амьдарч байна. Энэ нь зөвхөн эцэг, эхийн хараа хяналт, аюулгүй орчноор хязгаарлагдахгүй, тэдний хүмүүжил боловсрол, орчинд тойрондоо хандах хандлагад ч ихээхэн нөлөөлж байна.

Говь-Алтай аймаг, М. Субашид, 9 настай.

Аав ээжийнхээ араас нүхэндээ дарагдчихвийдээ гэж санаа их зовдог. Би хүн дарагдахад хажууд нь байсан. 2 хүн дарагдсан. 1 нь ухаан алдаад гарж ирсэн. Нөгөө нь газар дээрээ нас барсан. Нүх нь бараг 20 м гүнзгий гэж байсан. 5 настайгаасаа хойш аав, ээжийгээ дагаж явж байгаа. Хүйтэнд явахад их даардаг. Майханд салхилаад шөнө унтаж чаддаггүй. Ялаат зундаа их гоё дулаахан. Энэ зун 1 сар Ялаатад, 1 сар Рашаантад, Увсад 1 сар байсан.

3.2.1 Хүүхдүүд хэцүү нөхцөлд амьдарч байна.

Уурхайн орчинд амьдардаг хүүхэд зуны улиралд ихээхэн нэмэгддэг тухай дээр дурьдсан. Хүүхдүүд амьдарлаа гээд орчинд ямар ч өөрчлөлт байхгүй, бичил уурхайчид ямар орчинд амьдарч байна, хүүхэд тийм л орчинд амьдарна. Эцэг эх нь ямар орон байранд амьдарч байна. Түүний л адил орон байранд амьдрах учир ихэвчлэн монгол гэрт амьдардаг. Гэр ачих боломжгүй хол явж байгаа тохиолдолд майхан, дугирцаг, машинд хоног төөрүүлдэг байна.

Зураг 3-11 Хэнтий аймаг, Батноров сум, Бэрхийн уурхайн орчимд амьдардаг хүү



Завхан аймаг, Бямбажаргал, 9 настай.

Аав, ээж хоёулаа бичил уурхайчин. Зун харах хүнгүй болохоор намайг аваад явдаг. Аав, ээж, дүүтэйгээ хамт майханд амьдардаг. Аав, ээж, эгчтэйгээ байх нь сайхан ч тоглох газар байхгүй. Нүхрүү уначих байх гээд бараг гаргадаггүй. Тэр нь жоохон хэцүү.

Хээр хөдөө тохитой орон байхгүйн дээр гэр бүлээрээ амьдрах нь бараг ховор. Хэд хэдээрээ нийлж нэг гэрт, нэг майханд амьдардаг. Зарим нь өөрийн орон байр бэлдээгүй ирдэг учир тухайн шөнөө хоноглох боломжтой газраа хүртэл хонодог байна. Олон хүнтэй хамт амьдрахад хэцүү, унтах ч газар олдохгүй, хувцсаа ч тайлахгүй унтдаг тухай судалгаанд оролцогч хүүхдүүд ярьж байсан юм.

Зураг 3-12 Хэнтий аймаг, Батноров сум, Бэрхийн уурхай



Төв аймаг, Б.Гомбодорж, 15 настай.

Гэрийнхнээрээ байна гэж бараг байхгүй дээ. Хамгийн багадаа 2 тэгээд 14 хүнтэй хүртэл хамт амьдрах тохиолдол байсан.

Аюултай орчин нөхцөл

Томоохон суурин газруудын ойролцоо уурхай гарсан тохиолдолд зөвхөн бичил уурхайчид, тэдний хүүхэд гэлтгүй, тухайн орчинд амьдарч бүхий л хүүхдүүдийн хувьд орчин нөхцөлийн асуудал хүндхэн байдаг.

Тухайлбал, Төв аймгийн Заамар суман дахь Хайлааст багийн иргэд бараг 100 хувь бичил уурхай эрхлэгчид. Багийн иргэдээс гадна өөр аймгуудаас ч маш олон хүн алт ухахаар ирдэг. Судалгааны мэдээлэл цуглуулалтын баг Хайлааст багт ажиллахад, өөр аймаг, сумнаас ирсэн бичил уурхайчид багийн төвийн зочид буудалд заримдаа ирж хоноглодог, буудалд орж ирээд хамгийн хямд өрөө асууж, араас нь биеэ үнэлэгч асууж байлаа. Тухайн шөнөө шөнөжингөө архидаж, зодолдож хоносон юм. Өглөө нь буудлын үйлчлэгч эмэгтэйгээс тодруулахад, энэ бол энгийн үзэгдэл бүх буудал, бүх шөнө л иймэрхүү янзтай өнгөрдөг гэж хэлсэн юм.

Тухайн багийн охидтой ярилцахад ийм орчинд амьдарахад хэцүү, согтуу хүмүүс татаж чангаах асуудал хааяа гардаг. Орой үдэш гадуур явдаггүй, эцэг эх нь ч энэ байдлыг мэддэг учир гадуур гаргадаггүй. Жижиг газар учир хүмүүс бие биеэ сайн мэднэ. Ямар нэгэн юм боллоо гэхэд бусад хүнд хэлвэл, дороо л хов жив тарах учир цагдаа, эмчид хандахаасаа илүү чимээгүй өнгөрөхийг илүүд үздэг байдал ажиглагдсан.

Мөн хөл хөдөлгөөн ихтэй, машин мотоцикл ихтэй учир зам тээврийн осол гарах тохиолдол байдаг.

Заамар суманд бичил уурхайчдаас гадна томоохон уурхайнууд үйл ажиллагаа явуулдаг. Тэдний ашиглахаа больсон уурхайн карьер болох нүх хаа сайгүй байдаг. Тэр нүх нь хамгийн багадаа 5 метрийн гүн байдаг. Тэр карьерт хүүхдүүд тоглож байгаад унаж бэртэх, мал унаж үхэх тохиолдол гардаг. Мөн тухайн нүхнүүдээс ухаж гаргасан сум шороо уулын дайтай өндөр өндөр овоолгоотой. Салхи гарах төдийд л багийн төв шар шороогоор бүрхэгдэж байсан.

Зураг 3-13 Баянхонгор аймаг, Жаргалант сум



Зураг 3-14 Төв аймаг, Заамар сум



3.2.2 Бичил уурхай хүүхдүүдийн боловсролд нөлөөлж байна.

Хүүхдийн боловсролд улс орны шинжтэй асуудлууд голлох нөлөө үзүүлж байгаа ч бичил уурхайчны хүүхэд болсныхоо хувьд хохирох асуудал байна.

Бичил уурхайчид ажиллах боломжтой газар хаана л гарна тийшээ нүүж, шилжиж байдагтай холбоотойгоор зарим хүүхдүүд суурин сурч боловсрол боломж бололцоо байдаггүй. Иймэрхүү тогтворгүй амьдралын хэв маягаа дагаж хүүхдүүдийн сэтгэл санаа тогтворгүй, хичээл сургуульдаа явах дургүй, багш нар нь араас нь хөөцөлдөж байж хичээлд нь суулгах тохиолдол нэлээд байдаг аж. Жишээ нь: Хүүхдүүд зуны амралтаараа, хэрэв олборлолтын талбай ойрхон бол хагас бүтэн сайнаар аав, ээж дээрээ очих гэх зэрэг нь хүүхдийг тогтворгүй байдалд оруулж байна.

Ерөнхий боловсролоос гадна сургуулийн өмнөх боловсролд хамгийн их нөлөөлж байна. Цэцэрлэгийн орон тоо бүрдчихдэг, зарим газар ойр цэцэрлэг байхгүй учир хүүхдүүдээ цэцэрлэгт өгөх боломжгүй болдог. Тиймээс хүүхдээ харахын тулд ажлаа хийж чадахгүй, эсвэл урин цагт хүүхдээ авч олборлолтын талбайруу явах зэрэг асуудал гардаг байна.

Тухайлбал, Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн Туулын гүүр гэх жижиг хороолол тэр чигээрээ бичил уурхайчид. Тэнд цэцэрлэг, сургууль огт байхгүй. Багийн төв хүртэл 12 км байдаг. Эндээс машингүй айлын хүүхдүүд сургуульдаа алхаж,

машинтай айлын хүүхдүүд нь машинаар хичээлдээ явдаг. Эсвэл ээлжилж хүүхдүүдээ сургуульд нь хүргэж өгдөг байна.

Зураг 3-15 Хэнтий аймаг, Батноров сум, Сумруугаа явж буй байдал



Дараахь шалтгаануудын улмаас хүүхдүүдэд сурч боловсрох таатай орчин бүрдэхгүй байна. Үүнд:

- Байнга нааш, цааш явах гэх мэт тогтворгүй амьдралын хэв маяг
- Хувцас, хичээлийн хэрэгслийн дутагдалтай байдал
- Аав, ээжийгээ санах
- Хичээл заах, давтуулах хүн байхгүй
- Дүү нараа харах
- Аав, ээжийг орлож гэрийн ажил хийх
- Уурхайн орчноос сургуульд ирэх, очиход хүндрэлтэй
- Аав, ээжийнхээ ажилд туслах гэх зэрэг.

Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга Баттулга:

Хүүхдэд тавих анхаарлын хувьд тоглох, сурч боловсрох орчин байхгүй. Арай тусад орсныг өөрсдийнхөө хөдөлмөрт хамжуулаад үгүй ядаж шороогоо зайлуулна. Тэрнээс том болсныг нүхэнд оруулна гээд байнга газар шороотой харьцаж байна. Хичээл давтах, гэрэл цахилгаангүй учир сүүлийн үеийн компьютер тоног төхөөрөмжгүй харьцаж мэдэх юм байхгүй. Үүнээс хоцрогдож хаягдаж байна.

Баянхонгор аймаг, Б. Хишигжаргал, 17 настай.

10-р ангид сурдаг. Ах, эгч нартаа дайгдаад машинаар сургуульдаа ирдэг. Хичээл давтах боломж байхгүй дээ. Шөнө нь гэрэл байхгүй. Өдөр нь тоос, шороотой хийх бололцоо байдаггүй.

Хэнтий аймаг, Сувд, 14 настай.

9-р ангид сурдаг. Хичээлдээ машинаар ирчихдэг. Уурхайн орчинд хичээл хийх боломж бололцоо байхгүй. Үүнээс болоод хичээл таслах тохиолдол гардаг. Тэнд ээж, аавдаа тусалж ажил хийх гээд хичээлдээ ирж чаддаггүй. Бас заримдаа хичээлдээ ирэх гэхээр унаа машин олддоггүй.

Хэнтий аймаг, Б.Даваадамдин, 12 настай.

Би 7-р анги сурдаг. Дотуур байранд орсноор 5 дахь өдөр болгон хичээлээ тараад уурхай явдаг болсон. Бүтэн сайн өдрийн орой сумруу ирдэг. Заримдаа унаагүй болчихоод хичээлээ таслах тохиолдол гардаг.

3.2.3 Бичил уурхайчдын хүүхдүүд хүчирхийлэлд өртөх эрсдэл илүү өндөр байна.

Зарим сумын хувьд зөвхөн тухайн сумын хүмүүс ажилладаг байхад, зарим олборлох талбай ихтэй орон нутагт олон газраас олон хүн ирж ажилладаг. Тэдгээрийн ихэнх нь хүний нутагт, танихгүй хүмүүс дунд “хөлөөрөө толгой хийж, толгойгоороо хөл хийдэг” байна.

Мөн олон жил хөдөө хээр алт ухаж амьдарсан хүмүүсийн зан харьцаа, биеэ авч явах байдал ихээхэн доголдолтой болсон байдаг тухай орон нутгийнхан хэлж байлаа. Ярьж байгаа 2 үгний 1 нь хараал байх жишээний. Ийм хүмүүс өөрийн, бусдын бүхий л хүүхдүүдэд ингэж ханддаг байна.

Баянхонгор аймаг, Б.Отгонцэцэг, 13 настай.

Олон хүмүүстэй хамт байх хэцүү. Байнга л загнана, дээрэлхэнэ. Сүрдүүлэх ч тохиолдол гардаг. Жоохон зүйл дээр маргалдахад хүртэл “хараал хийлгэнэ шүү” гэдэг.

Алтны төлөө л ажиллаж байгаа учир гарц ахиутай байгаа нүхээ булаацалдаж хэрэлдэх, зодолдох асуудал ч гардаг. Согтуу хөлчүү муудалцах үе ч гардаг. Энэ томчууд хоорондын хэрүүл маргаанаас хальж хүүхдүүдэд нь хүртэл нөлөөлдөг байна.

Дэлхийн зөн Монгол ОУБ, Хөгжлийн ажилтан Энхсаруул:

Мэдээлэл авч байхад гэр бүлтэй хүмүүс нь зорилготой. Гэр бүлгүй залуучууд нь олсон мөнгөөрөө архи, тамхи хэрэглэх асуудал байдаг. Үүнээс даамжраад зодолдох, сүүлдээ цагдаа сэргийлэх болох тохиолдол нэлээн гардаг. Нөхцөл байдал бол хүнд шүү дээ.

Баянхонгор аймаг, Бурмаа, 13 настай.

Шороогоо булаацалдаад том хүмүүс маргалддаг. Бүр нэгнийгээ хүрзээрээ цохидог. Гэхдээ ноцтой гэмтэл учираагүй л дээ.

Уурхайн орчинд амьдарч байгаа хүүхдүүдээс гадна, аав ээж нь уурхайруу явсан бага насны хүүхдүүдийг томчууд дээрэлхэх асуудал байдаг. Биедээ үнэтэй зүйл, мөнгө төгрөг авч явахаас зайлсхийдэг бөгөөд эцэг эх нь ингэж зөвлөдөг гэнэ.

Төв аймаг, Бат-Эрдэнэ, 12 настай.

Эд зүйлсээ алдах тохиолдол гарч байсан. Гар утсаа 3 сарын өмнө алдаж байсан. Найзуудад маань ч бас ийм зүйл тохиолдож байсан. Том ах нар хааяа шинэ хувцасыг нь авах тохиолдол байдаг. 1000, 2000 төгрөг авах тохиолдол байдаг. Буцааж өгдөггүй.

Төв аймаг, Хажидсүрэн, 15 настай.

Хүүхдүүд зодуулчихсан л байдаг. Бас мөнгө төгрөгөө алдаж байсан. Дээд ангийн хүүхдүүд нь доод ангийн хүүхдээ сүрдүүлж мөнгө өг гээд өгөхгүй бол зоддог. Аав, ээж нь энд байдаггүй болохоор дээрэлхэх тохиолдол байдаг байх. Хулгай бас ихтэй.

Судалгааны гол зорилго биш боловч олон хүн цугларсан орон нутгуудад "биеэ үнэлэгч"-ийн асуудал ч байгаа нь анзаарагдаж байсан. Тухайн орон нутгийн хүмүүс нутгийн иргэдээс санаа нь зовж биеэ үнэлдэггүй, өөр газраас машинаар дайгдаж ирдэг гэж судалгаанд оролцогчид ярьж байсан юм. Энэ асуудалтай холбоотойгоор хүүхдүүд хүртэл тохиолдол байдаг байна.

Баянхонгор аймаг, Бичил уурхайчин Баярсайхан:

Манай суманд олон янзын газраас ирсэн хүн байдаг тул зөрчил их гардаг. Хэдэн жилийн өмнө 3 настай охиныг хүчиндсэн тохиолдол гарсан. Одоо зохион байгуулалтанд орсноор байдал дээрдэж байгаа.

3.2.4 Бичил уурхайн орчин хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж байна.

Өмнө нь дурьдсанчлан, олон газраас цугласан олон хүнтэй газар маш олон асуудал гардаг. Тэр хүмүүс дунд, тэр орчинд өсөж хүмүүжиж байгаа хүүхдүүд яг тэр хүмүүсийн тусгал болж хүмүүждэг нь судалгаанд оролцогчдын ярианаас, бидний уулзсан хүүхдүүдийн хандлагаас ч харагдаж байсан юм.

13, 14 наснаас доош хүүхдүүд харьцангуй даруухан, орчноос болгоомжилсон шинжтэй байсан бол түүнээс дээш насны хүүхдүүд илүү бие даасан, хүнд дээрэлхүүлэхгүй гэсэн хандлагатай байсан юм.

Баянхонгор аймаг, Жаргалант сум, Засаг дарга Сайнбилэг:

Орчны хувьд ч хүүхдийн хүмүүжил доголддог. Яагаад гэвэл бичил уурхай эрхэлж

байгаа хүмүүс чинь уулын мұхарт зэрлэг хүмүүс шиг байдаг. Яриа хөөрөө, үг хэл нь хэцүү шүү дээ. Хүүхдүүдийг нь харахад яг л тийм болдог. Хүмүүжлийн доголдолтой, хэл ярианы соёлгүй байдаг. Тэгэхээр би хүүхдийн хүмүүжилд муугаар нөлөөлдөг гэж үздэг.

Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга Баттулга:

Гайгүй юм олвол архи ууна. Тэнд байгаа хүмүүс чинь олон жил албан орчинд ажил эрхлээгүй зэрлэг танхай хүмүүс байдаг. Тэр хүмүүстэй харьцаж байгаа хүмүүс чинь адилхан харьцах шаардлагатай байдаг. Тэгэхээр тэнд хүнд нөхцөл байна гэсэн үг шүү дээ. Ярьж байгаа үг хэллэг гээд хэцүү шүү дээ.

Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг дарга Баттулга:

Архидалт их байна. Харин нөхөрлөл болоод зохион байгуулалтанд орсон хүмүүсийн хувьд арай эмх цэгцтэй, өөрсдийнхөө орчинд архи заруулахгүй гэсэн шаардлага тавиад байна. Харин тэр бүртгэлгүй хүмүүсийн хувьд архидалт нэлээн гардаг. Зодоон цохион хийнэ. Алт илүү гарч байгаа нүхээ булаацалдан зодолдоно. Нэг нэгнийгээ хайрлана гэж байхгүй, барьж байгаа багаж зэвсгээрээ цохино. Байж байгаад л суманд дуудлага ирнэ хэсгийн төлөөлөгчөө явуулаач гээд хүн алах нь гээд л. Тэгэхээр тэнд орчин бол хүнд л дээ.

Дэлхийн зөн Монгол ОУБ, Хөгжлийн ажилтан Энхсаруул:

Хүүхдүүдийн өсч хүмүүжих орчны хувьд сөрөг нөлөөтэй. Яагаад гэвэл уурхай дээр хүмүүсийн харьцаа доголдолтой. Гэртээ ирээд хүүхдүүдтэйгээ яг тэгж харьцдаг. Үг хэллэг, ааш авир бүгд. Мөн эцэг эх хоёрын хоорондын харьцаа ямар байна, яг тэрэн дээр хүүхдийн хүмүүжил тэр хэвээрээ болдог.

3.2.5 Хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Эцэг, эхтэйгээ ойр амьдарч байгаа хүүхдүүдийн хувьд ч, хол амьдарч байгаа хүүхдүүдийн хувьд ч аль алинд нь анхаарал халамж сул. Бага наснаас нь эхлээд л хөдөө хээр авч явах юмуу, хүйтэн гэрт харах хандах хүнгүй үлдээдэг байсан гэх гэр бүл олон таарсан. Тэдгээр хүүхдүүд ханиаднаас эхлээд л өвдөж эхэлдэг бөгөөд мөн л анхаарал халамж султай холбоотойгоор бүрэн эдгээж ч чадахгүй тохиолдол байдаг байна.

Хүйтэн гэрт хоол ундгүй үлдэх, шороо тоостой орчинд амьдрах, шаардлагатай үед өгөх эм тариагүй байх, эмчид үзүүлэх боломжгүй байх зэрэг нөхцөл байдлуудаас үүдэж хүүхдүүдийн өвчин улам даамжирдаг байна.

Бичил уурхайчидтай уулзаж байхад, маш хүнд өвдөж, биед нь ихээхэн өөрчлөлт гараагүй л бол, ханиад, харшил, гамрит, бие дээр юм туурах зэргийг огт өвчин гэж үзэхгүй шахуу байсан нь хачирхалтай. Зарим эцэг, эх ханиад хүрч л байдаг, тэгээд өөрөө аяндаа гайгүй болчихдог юм гэж хүртэл ярьсан юм. Ийм хандлагаас үүдэж хүүхдүүдийн өвчин хүндэрч дараа дараагийн шинэ өвчнүүд тусах, архагших асуудал үүсэж байна.

Завхан аймагт дөнгөж төрсөн, хэдхэн сартай хүүхдийг эмнэлэгт үзүүлэхэд, уушгины тоосжилттой гэсэн онош гарсан тухай судалгаанд оролцогчид ярьж байлаа.

Баянхонгор аймаг, Бичил уурхайчин Отгонбаяр:

Манай хүүхэд багаасаа л гэртээ ахтайгаа үлддэг байсан. Хүйтэн гэрт, халуун хоол ундгүй, боорцог идэж л өдрийг өнгөрүүлдэг. Үүнээс л болсон байх. Биер юм гарах, ханиад хүрэх тохиолдол байнга байдаг.

3.2.6 Хүүхдүүд уурхайн орчинд амьдарснаар гэмтэж бэртэх эрсдэл өндөр байна.

Уурхай орчинд амьдарч буй хүүхдүүдийн хувьд өмнө дурьдсан өвчлөлүүдээс гадна механик гэмтэлд өртөх эрсдэл бусад хүүхдүүдтэй харьцуулахад өндөр байна.

Харах хүнгүй, сургууль цэцэрлэг амарсан зэрэг шалтгааны улмаас хүүхдүүдээ уурхайн орчинд авч очдог. Тухайн орчинд мөн л адил өдөр өнжүүлэх төв, зуны цэцэрлэг байхгүй, хүүхэд тоглох орчин байхгүй учир хүүхдүүд олборлолтын талбайд тоглож байгаад гэмтэж бэртэх тохиолдол байдаг байна. Тиймээс эцэг эхчүүд хүүхдүүдээ өдөржингөө гэр, майханд нь байлгадаг. Нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон газруудад ийм асуудал харьцангуй арилж, уурхайн талбайруу хүүхэд оруулахгүй байх, анхааруулах самбар хадах гэх зэрэг арга хэмжээ авчээ.

Ховд аймаг, Оюунгэрэл, 14 настай.

Аав, ээжтэйгээ хамт байгаад, тусалж байгаа нь сайхан байдаг. Гэхдээ орчин нөхцөл аюултай, шороо тоос ихтэй, амрах ч газаргүй. Нүхрүү унах гээд асуудал гарах аюултай байдаг. Би уурхай дээр ажиллаж байхдаа санамсаргүй явж байгаад нүхэнд унасан. Нүхэнд унаснаас хойш толгой хатгаж өвддөг болсон.

Харин нөхөрлөлийн зохион байгуулалтанд ороогүй газар энэ эрсдэл байсаар байна.

Увс аймаг, "Бид Намирын эзэд" ТББ-ын тэргүүн И. Хуримхаан:

Дулааны улиралд бүгд гарна. 2-4 настай хүүхдүүд нүхний аман дээр сууж байна шүү дээ. Их эрсдэлтэй. Авч явахаас өөр арга байхгүй. Тэднийг чинь гэр орондоо орхивол гэр орноо түймэрдчихнэ шүү дээ. Бүгд л алтны төлөө үзэж байна.

3.2.7 Хүүхдүүд өрхийн эдийн засагт нэмэр болохыг хичээдэг.

Насанд хүрсэн хүн ажиллахад ч бэрх орчинд хүүхдүүд ажиллаж амьдарч байна. Тэд биедээ, нас насандаа тохирсон ажил хийдэг. Уурхайн шороон орд, үндсэн орд зэргээс хамаарч өөр өөр хөдөлмөрийн хуваарьтай. Уурхайн орчинд ойр л амьдарч байгаа тохиолдолд хүүхдүүд тогтмол биш ч, их бага хэмжээгээр, амралтын өдрүүдээр аав, ээжийнхээ ажилд туслах нөхцөл үүсдэг байна.

Уурхайд ажилладаг хүүхдүүдийн тухайд эцэг эхийн шахалт шаардлагаар ажиллахаас илүүтэй гэр бүлийнхээ орлогод нэмэр болох, өөрсдийн хэрэглээний мөнгөө олох, эцэг эхдээ тусалъя гэсэн санаагаар ажиллаж байна. Хэрэв эцэг, эх нь тогтмол ажлын байртай, хангалттай орлого олдог бол хүүхдүүд уурхайд хүнд хүчир хөдөлмөр эрхлэхгүй байх боломжтой. Эндээс харахад хүүхдүүдийг ажиллахгүй байхыг уриалах, хориглохоос илүүтэй эцэг, эхийг тогтмол ажилтай болгох, өрхийн амьжиргааг дэмжих чиглэлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс нааш энэ асуудал шийдэгдэхэд хүндрэлтэй байна. Тухайлбал, Увс аймагт газар нутаг, байгаль цаг уурын онцлогт нь нийцсэн газар тариалан (чацаргана г.м)-г хөгжүүлбэл эдгээр иргэдийг эрүүл мэндэд хоргүй ажлын байраар хангах, байгаль орчинд хор хөнөөлгүй, өрх тогтмол орлоготой болгох боломжтой гэдгийг орон нутгийн удирдлагууд ч дэмжиж байсан юм.

Зураг 3-16 Хэнтий аймаг, Батноров сум, Зураг 3-17 Баянхонгор аймаг, Галуут сум Бэрхийн уурхай



Хүүхдүүдийн уурхайд ажиллахад нөлөөлдөг гол зорилго нь мөнгө олох. 16, 17 той хүүхдүүд өөр хөнгөн ажил хийе гэхээр насанд хүрээгүй учир ажилд авдаггүй гэнэ. Тиймээс хүнд хэцүү ч гэсэн уурхайд ажиллахад цагдаа хүчнийхэн хөөхөөс ажил олгогч гэж байхгүй учир ажиллах боломжтой байдаг тухай хүүхдүүд ярьж байсан юм.

Ховд аймаг, Нэр: Ууганбаяр, Нас: 16

Гэр бүлээс аав бүтэн жилээр уурхай дээр ажилладаг. Аав, ээжтэйгээ хамт байгаад туслаад, хичээлийн хэрэглэлийн мөнгөө олж гэрийхэндээ олсон мөнгөө өгдөг. Гэхдээ орчин нөхцөл аюултай, шороо тоос ихтэй. Мөн дуу чимээ маш их. Яагаад гэвэл том машин маш их явдаг. Аав ажилладаг. Хамт байгаа үедээ байнга тусалдаг. Нүүрс цохиж гаргаж, шуудайлж, машинд ачуулдаг.

Баянхонгор аймаг, Далайжаргал, 14 настай.

Аав ээж 2 хоёулаа ажилладаг учир би ажилд нь тусалдаг. Фүнкэрлүү шороо шиддэг, шламыг нь цэвэрлэдэг, фүнкэрийн толгой, шланкийг нь барьж өгдөг. Өглөө 11, 12 цаг гээд гараад, орой 6, 7 гээд бууж ирдэг. Өдөрт дунджаар 7-8 цаг ажилладаг.

Баянхонгор аймаг, Хас-Эрдэнэ, 17 настай.

Энд ажиллахад хэцүү байдаггүйээ. Олон хүн таньдаг болсон нь сайхан. Би ер нь 14 настайгаасаа барилга дээр ажиллах, вагон буулгах гээд олон ажил хийж байсан. Тийм болохоор хэцүү санагддаггүй юм.

Ховд аймаг, Орхон, 14 настай.

Аав уурхайд ажилладаг. Зуны амралтаар аав, ээжтэйгээ уурхайн орчинд хамт туслаад л амьдардаг. Нүүрс уутлаад, хоол цайг нь хийгээд хүргэж өгдөг. Зуны амралт болон өвөл нүүрс сайн зарагддаг учир очиж ажилладаг.

Увс аймаг, Б. Сумъяа, 12 настай.

Аав хүмүүстэй хамтарч ажиллаж, шрүпэнд орж ажиллаад алт олдог. Би ах, дүү нарынхаа хүүхдүүдтэй нийлж, алтны шороог малтаж, зөөгөөд фүнкерт хийж усыг нь барьж өгдөг юм. Мотор ажиллуулж байгаад шрүпнээс ус татуулдаг. Усны шланкыг нь алттай шороо руу чиглүүлж урсгадаг юм. Заримдаа алт угаадаг.

Тоглох зав гардаггүйээ. Дандаа л ажил хийдэг. Нөгөө хүүхдээ амрахаар, би ажиллаж, намайг амархад нөгөө хүүхэд ажилладаг. Ээлжилдэг.

Харин уурхайн орчинд амьдрахгүй гэртээ байгаа хүүхдүүдийн хувьд гэрийн ажил хийдэг. 8 настай, 9 настай хүүхдүүд хийж гэрээ харж, хоол хийх, түлээ хагалах, ус зөөх, хүүхэд харах, гэрээ цэвэрлэх гэх мэт аав, ээжийнхээ ажлыг хийдэг. Эдгээр ажлууд ч түлэгдэх, хөл гараа цохих зэрэг эрсдэл дагуулдаг. Үүнээс гадна хичээлээ хийх, давтах боломж гардаггүй байна. Дүү нараа хардаг хүүхдүүдийн хувьд даалгавраа хийхгүй байх зэрэг асуудал илүү байдаг тухай сургуулийн багш нар хэлж байсан юм.

Эцэг эхийн зүгээс хүүхдүүдээрээ ажил хийлгэх сонирхол байхгүй. Харин ч хүүхдүүдээ өөрсдийн энэ амьдралаар амьдруулахгүй байхын төлөө зүтгэдэг гэдэг нь харагдаж байсан ч зарим тохиолдолд яалт үгүй ажиллуулах шаардлага гардаг бололтой.

3.2.8 Хүүхдүүд аав, ээжийнхээ эрүүл мэндэд санаа зовж байна.

Хүүхдүүд өөрсдөөсөө илүү эцэг, эхдээ санаа зовдог болох нь харагдаж байлаа. Ихэнх хүүхдүүд эцэг эхээ ямар орчинд ажиллаж амьдардгийг нүдээр үзсэн учир даарч хөрөхвий, өвдөхвий, шороонд дарагдахвий гэсэн айдастай байдаг тухайгаа ярьж байсан юм.

**Зураг 3-18 Баянхонгор аймаг,
Галуут сум**



Баянхонгор аймаг, Бурмаа, 13 настай.

Аав, ээж 2 хоёулаа уурхай дээр ажилладаг. Өмнө нь жилийн турш ажилладаг байсан бол энэ жилээс зундаа л ажилладаг болсон. Өвөл бие нь дийлэхээ больсон. Бараг 10 жил алт ухаж амьдарсан. Аавын хамар өвчилсөн. Ямар өвчнийг мэдэхгүй. Шороотой орчинд хамраар нь юм туурч гараад байдаг болсон учир ажиллаж чадахгүй болсон. Тэгээд ч дээрээс нь шороо нурчихвал яаана.

Увс аймаг, Г.Ганхуяг, 13 настай.

Аавыгаа гэртээ байлгаад, өөрөө ажлыг нь хийхсэн гэж боддог. Каск, өмд гээд чулуунд цохиулаад гэмтэхгүй, даарахгүй хувцастай бол зүгээр байх. Нүх нь шаттай байвал бас зүгээр.

Баянхонгор аймаг, Далайжаргал, 14 настай.

Аав, ээж 2 хоёулаа уурхайд ажилладаг. 4 жил ажилласан. Уурхайд ажиллах муухай. Шороон дунд ажиллана. Тэгээд аав, ээж минь их ядардаг. Уурхайд ажилласнаас хойш

манай аавын толгой их муудсан. Яагаад гэвэл манай аав шрүфэнд орчихсон байхад дээрээс нь том чулуу унаад толгой нь гэмтсэн. Ээж маань зайлуул, өвөл хүйтрээд ирэхээр ханиад хүрчихдэг. Бид нар байнга л ханиад хүрдэг. Сайн л эм уухгүй бол болдоггүй.

Харин сүүлийн үед өөр нэг санаа зовоох асуудал нь хууль бусаар алт олборлож байгаа хүмүүсийн хувьд баривчилгаанд явчихвий гэж айдаг гэнэ. Хамаг багаж хэрэгслээ хураалгаад, хоригдчихдог. Баривчлагдсан тохиолдолд цагдаад зодуулдаг учир санаа зовохгүй байж чаддаггүй гэж байсан юм.

Говь-Алтай аймаг М. Субашид, 9 настай.

Цагдаа нарын баривчилгаанаас их айдаг. Цагдаа нарт зодуулчихсан ирдэг. Ээжийг эмэгтэй хүн болохоор арай зодохгүй л дээ. Аавыг бол зодож байсан тохиолдол зөндөө байдаг. Нэг майханд 7,8-уулаа амьдардаг. Манай аав, ээж хөөлгө ирэхээр баригдахгүй гэж архи ч уудаггүй юм. Согтуу бол зугтаж чадахгүй баригдчихдаг юм.

3.2.9 Хүүхдүүд эцэг, эхтэйгээ хамт амьдарч чадахгүй байна.

Хичээл сургуультай гэх зэрэг шалтгаанаар нэг хэсэг хүүхдүүд эцэг, эхээсээ тусдаа амьдарч байгаа. Эдгээр хүүхдүүдэд мөн л асуудалтай амьдардаг. Аав, ээж нь ажилдаа явсан тохиолдолд гэртээ харж хандах хүнгүй, арай том нь багыгаа хараад л үлддэг байна. Ах, эгч нар нь хоол цайгаа хийж, гэр орноо авч явдаг нэг хэсэг байна.

Харин нөгөө нэг хэсэг нь гэртээ биш айл хөршийндөө, эмээ өвөөгийнхдөө, ах дүүгийнхдээ үлддэг. Айлд толгой хоргодож байгаа эдгээр хүүхдүүдийн хувьд нөгөө хүүхдүүдээс ч илүү их гэр орны ажил хийх, хоол унд хомс байх тохиолдол байна.

Зураг 3-19 Сэлэнгэ аймаг, Зүүнхараа хот, Усанд явж буй хүүхэд



Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Зүүнхараад бид нэг охинтой уулзахад, хойт эцгийнхээ ээж дээр үлддэг. Байнга загнуулдаг, гэр орны бүх ажлыг хийдэг. Ээжийгаа маш их санадаг, сэтгэлзүйн маш хүнд нөхцөлд амьдардаг бололтой байсан юм. Бидэнтэй ярихдаа миний ярьсныг тэдэнд хэлэхгүй биздээ гээд нүдэнд нь нулимс цийлэгнэж, хоолой нь зангирч байсан юм.

Өөр нэг хүүгийн өвөө нь хараагүй учир асаргаа хэрэгтэй. Өвөөгөө хардаг, давхар дүүгээ хардаг учир хэцүү байдаг, гэрийнхээ бүх ажлыг хийдэг гэж байсан юм. Мөн хагас өнчин хүүхдүүд аав нь, ээж нь явчихсан хойгуур их л зутруухан байдагтай бид тааралдсан.

Говь-Алтай аймаг, Бичил уурхайчин Баярмаа:

Би ихэвчлэн аав, ээж 2 дээрээ хүүхдүүдээ аваачиж өгдөг. Зарим тохиолдолд хүн амьтанд захиад гэрт нь үлдээдэг. Хоолгүй боллоо гэвэл, нэг хүнрүү яриад манай мах дуусчихаж, зээлээч. Би очоод мөнгийг нь өгье гэх маягтай л байдаг.

Нүүрс түлээ, хоол унд гээд л явахаасаа өмнө иртлээ хүрэлцэхээр юм бэлтгэж өгдөг. Ерөөсөө хэзээ ирэх нь тодорхойгүй учир ахиухан л бэлдэж өгөхгүй бол иртэл нүүрс түлээгээр, хоол ундаар тасарчих гээд байдаг. Сүлжээтэй газар алт гарвал утсаар холбогдоно, сүлжээгүй газар бол тэр чигээрээ л байна. Бид ч 500-600 км хол хүртэл явж байсан удаа бий.

Баянхонгор аймаг, Бичил уурхайчин Батбаяр:

Ээждээ 3 жоохон хүүхдээ орхино. Том хүүхдээ өөрөө дагуулаад явдаг. 7 хоногт 1 удаа л утсаар ярина. Ажил дээр овоо алт олдоод байвал сараар ч хамаагүй гэртээ очихгүй ажиллаад л байна.

Говь-Алтай аймаг, Бичил уурхайчин Бороо:

Өвөө, эмээ нь байвал тэнд үлддэг. Харин айлд бол хоцрох дургүй. Нөгөө айл нь аяга таваг угаа гээд л, дүү нь үймүүлээд юм хумыг нь нураавал хангинаж дарамталдаг гэсэн. Ер нь бол айлд байх дургүй. Тэгээд л гэртээ үлдэцгээдэг.

Говь-Алтай аймаг, Бичил уурхайчин Мөнхжаргал:

Таньж мэддэг, ойр орчны хүндээ захиад л явна. Явж ирээд буцаж явахдаа ахиад л захиад гарна. Түлээгээ ингэж түлдэг юм шүү, галаа түлчихээд дөрвөлжингөө хойш нь тавьдаг юм шүү... гээд л захиана шүү дээ.

Ханиад хүрвэл тэрэн дээр очино шүү гээд л бүх юмыг нь хэлээд л, захиад л үлдээдэг дээ. Санаа зовдог ч, санаа зовлоо гээд яахав. Хоолгүй хонолтой биш.

Баянхонгор аймаг, Бичил уурхайчин Баянмөнх:

Өглөө үүрээр гараад , орой бүрэнхий болтол ажилладаг. 3 хүүхэд гэртээ л үлддэг. Алт гарвал, очиж хүүхдүүдээ унтуулчихаад буцаад л гардаг. 3-р ангийн хүүхэд 2 дүүгээ хараад болгоод л байдаг даа.